PwC Их Британи компани, Менежер



**Б.Хос-Эрдэнэ**
**ТУЗ-ийн гишүүн**

**Боловсрол**

Япон Улс, Хитоцүбаши их сургууль, Бизнесийн удирдлагын магистр
Япон Улс, Хитоцүбаши их сургууль, Хөрөнгийн зах зээл, санхүү бакалавр
Япон Улс, Токёогийн гадаад судлалын их сургууль, Япон хэлний бэлтгэл

**Туршлага**

АНД Системс ХХК, Гүйцэтгэх захирал
АНД Глобал Пти.Лтд, Хөрөнгө оруулалт хариуцсан захирал/ Гүйцэтгэх захирал
Япон Улс, Мизухо банк, Байгууллагын судалгааны газар, Бизнес шинжээч
Япон дахь Швейцари Улсын хөрөнгө оруулалтын банк UBS Секьюритис, Хөрөнгийн зах зээлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч банкир

УЛААНБААТАР ХОТ
ЛЭНДМН АКТИВ ТЗК ХХК
РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
RHINOS INVESTMENT ҮЦК LLC

СЗХ
2022.09.21 өдөр
БҮРТГЭВ
№01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-07
БҮРТГЭВ-02





**С.Энх-Амгалан**

**ТУЗ-ийн гишүүн**

**Боловсрол**

АНУ-ын Монтерейн ОУХДС, Олон улсын бодлого судлалын магистр

Монгол Улсын их сургуулийн Олон улсын харилцаа бакалавр

**Туршлага**

Мэргэн Инвестмент Пти.Лтд, Захирал

Петровис ойл ХХК, Ерөнхий захирал

Эрдэнэс Монгол ХХК, Зөвлөх

Southgobi Sands & Southgobi Resource ХК, Ерөнхийлөгч/ Гүйцэтгэх захирал

---



**В.Баярсайхан**

**ТУЗ-ийн гишүүн**

**Боловсрол**

АНУ-ын Вашингтоны их сургууль, Фостер бизнесийн сургууль, Бүтээгдэхүүн удирдлага, маркетинг болон энтрепренершип мэргэшсэн, Бизнесийн удирдлагын магистр

Туркийн Ege их сургууль

**Туршлага**

ТомЁ Эдтек ХХК, Үүсгэн байгуулагч/ Ерөнхий захирал

АНД Глобал Пти.Лтд, Үйл ажиллагаа хариуцсан захирал/ Маркетинг хариуцсан захирал

Dell EMC компани, Big data treaming & real-time шинжээч

АНУ-ын Майкрософт компани, Бизнес зөвлөх

---



**Ц.Ууганбаяр**

**ТУЗ-ийн гишүүн**

**Боловсрол**

Болгар Улс, Америкийн Их сургууль, Бизнесийн удирдлага, Эдийн засгийн ухааны бакалавр

**Туршлага**

АНД Глобал Пти.Лтд, Санхүүгийн менежер/ Санхүү эрхэлсэн захирал

Эм Си Эс Холдинг ХХК, Санхүүгийн ахлах ажилтан

Америкийн Нэгдсэн Улс, Эдгартаун Үндэсний Банк, Нягтлан бодогч

Марта Вайнярд Хадгаламжийн банк, Теллер

---



**Б. Итгэл**

**ТУЗ-ийн гишүүн**

**Боловсрол**

Америкийн нэгдсэн улс, Жорж Мэсон Их сургууль, Санхүү бакалавр

**Туршлага**

АНД Глобал Пти.Лтд, Хөрөнгө оруулалт хариуцсан захирал

Мобиком Корпораци, Санхүү удирдлага, нягтлан бодох бүртгэлийн захирал/ Байгууллагын төлөвлөлтийн захирал

Новатерра, Санхүүгийн менежер/ Гүйцэтгэх захирал

Ньюком Групп, Хөрөнгө оруулалтын шинжээч/ Портфолио менежер

УЛААНБААТАР ХОТ
ЛЭНДМН АКТИВ ТЗК ХХК

РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК

СЗХ
2022 .09 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -10- 07



# Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийн танилцуулга



**С.Боргил**

**ТУЗ-ийн хараат бус гишүүн**

**Боловсрол**

АНУ-ын Колорадогийн их сургууль, Эдийн засгийн магистр /эконометрик болон санхүү/

Монгол Улсын их сургуулийн Эдийн засгийн сургууль, Санхүүгийн бакалавр

**Туршлага**

Сэргэлт консалтинг групп ХХК, Гүйцэтгэх захирал

Сангийн яам, Зөвлөх

Ирээдүйн өв сангийн тухай хуулийн төслийн ажлын хэсгийн гишүүн

Уул уурхай, хөнгөн үйлдвэрийн яам, Эрдэнэс Оюу Толгой ХХК, Зөвлөх



**Ж.Жаргалсүрэн**

**ТУЗ-ийн хараат бус гишүүн**

**Боловсрол**

Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэг, Татварын мэргэшсэн зөвлөх

Их Британи, Олон улсын мэргэшсэн нягтлан бодогчдын нийгэмлэг, Олон улсын мэргэшсэн нягтлан бодогч

Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт, Мэргэшсэн нягтлан бодогч

**Туршлага**

Далайван аудит ХХК, Удирдлагын партнер

Далайван аудит ХХК, Аудитын менежер

Далайван аудит ХХК, Аудитор



**Д.Галхүү**

**ТУЗ-ийн хараат бус гишүүн**

**Боловсрол**

Япон Улс, Кобе Их сургууль, Эдийн засгийн ухааны магистр

МУИС-ийн ЭЗДС, Нягтлан бодогч эдийн засагч бакалавр

**Туршлага**

ПрайсуотерхаусКуперс Аудит ХХК болон ПрайсуотерхаусКуперс Такс ТМЗ ХХК, Менежер

ПрайсуотерхаусКуперс Аудит ХХК, Санхүүгийн үйлчилгээний зөвлөх

Монголбанк, Хяналтын хэлтсийн төсөл, Менежер

Дэлхийн банк, Сангийн яам, Тогтвортой амьжиргаа төслийн II шат, Дотоод аудитор

УЛААНБААТАР ХОТ
ЛЭНДМН АКТИВ ТЗК ХХК
9022080559
ХТҮ4977 ⊕ 6888895

РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
33
RHINOS INVESTMENT UTsK LLC
УЛААНБААТАР ХОТ

### 2.2.3 Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн тухай

Үүсгэн байгуулагч/анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч нь тус компанийн нийт хувьцааны 75 хувийг эзэмшиж буй Монгол улсын хуулийн этгээд АНД Системс ХХК бөгөөд тус компанийн 100 хувийн хувьцаа эзэмшигч буюу толгой компани нь Сингапур улсын хуулийн этгээд АНД Глобал компани юм.

*Зураг 4: АНД Глобал компанийн хувьцаа эзэмшлийн бүтэц*




### АНД Глобал компанийн үйл ажиллагаа

АНД Глобал компани нь Япон, Америк, Солонгос, Монгол улсад мэргэжил эзэмшсэн шилдэг инженерүүд, мэргэжилтнүүдээс бүрдсэн 200 гаруй боловсон хүчин, баг хамт олонтой үйл ажиллагаагаа явуулж байна.

2022 оны 1-р сард **Камбож** улсын **SBI Ly Hour Plc**. банкинд санхүүгийн технологийн шийдлүүдийг нэвтрүүлэхээр гэрээг үзэглэв. Тус банк нь улс даяар 45 салбартай, Японы SBI Holding-ийн хөрөнгө оруулалттай банк юм.

2022 оны 2-р сард **Япон** улсын **Global Trust Networks** компанид зээлжих зэрэглэл тогтоох буюу санхүүгийн технологийн шийдлүүдийг нэвтрүүлэхээр гэрээлэв.

2022 оны 4-р сард **Австрали** улсын **Affordable Car Loans** компанид санхүүгийн технологийн шийдлүүдийг нэвтрүүлэхээр гэрээлэв.

СЭХ
2022 .08сар 24 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-07



## 2.3 АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН САНХҮҮГИЙН ШИНЖИЛГЭЭ

### 2.3.1 Санхүү байдлын тайлангийн шинжилгээ

*Хүснэгт 5: Санхүү байдлын шинжилгээ*

| Нэгж: тэрбум төгрөг | 2020.IV | 2021 I | 2021 II | 2021 III | 2021 IV | 2022 I |
|---|---|---|---|---|---|---|
| Мөнгөн хөрөнгө | 10.35 | 7.09 | 1.72 | 5.16 | 4.90 | 4.70 |
| Зээл (Цэвэр) | 25.43 | 27.54 | 25.70 | 30.16 | 31.71 | 32.97 |
| *Нийт зээл* | 28.77 | 30.58 | 28.38 | 33.03 | 33.91 | 35.50 |
| *Зээлийн эрсдэлийн сан* | - 3.34 | - 3.04 | - 2.68 | - 2.87 | - 2.20 | - 2.53 |
| Бусад хөрөнгө | 3.44 | 3.76 | 3.65 | 1.42 | 1.48 | 1.81 |
| Үндсэн хөрөнгө | 1.11 | 1.00 | 0.92 | 0.84 | 0.76 | 0.82 |
| Биет бус хөрөнгө | 0.40 | 0.17 | 0.17 | 0.16 | 0.45 | 0.44 |
| **Нийт хөрөнгө** | **40.73** | **39.56** | **32.16** | **37.74** | **39.30** | **40.74** |
| Эх үүсвэр | 21.12 | 19.63 | 12.49 | 14.00 | 14.85 | 15.31 |
| Бусад өр төлбөр | 1.91 | 2.53 | 1.46 | 1.99 | 1.85 | 2.96 |
| **Нийт өр төлбөр** | **23.03** | **22.16** | **13.95** | **15.99** | **16.70** | **18.28** |
| Хувьцаат капитал | 9.83 | 9.35 | 9.13 | 8.82 | 8.48 | 8.48 |
| Хуримтлагдсан ашиг/алдагдал | 7.89 | 8.05 | 9.07 | 10.09 | 11.28 | 11.14 |
| Хоёрдогч өглөг | - | - | - | 2.85 | 2.85 | 2.85 |
| **Нийт өөрийн хөрөнгө** | **17.72** | **17.40** | **18.20** | **21.76** | **22.61** | **22.46** |
| **Нийт өр төлбөр, өөрийн хөрөнгө** | **40.75** | **39.56** | **32.15** | **37.75** | **39.31** | **40.74** |

### 2.3.2 Хөрөнгө(актив)

2022 оны эхний улирлын байдлаар ЛэндМН ББСБ ХК-ийн нийт хөрөнгө 40.7 тэрбумд хүрч 2021 оны дундажтай харьцуулахад 8.7 хувийн өсөлттэй байна. 2022 оны 1-р улирлын байдлаар нийт хөрөнгийн 80.9 хувийг цэвэр зээлийн багц, 11.5 хувийг мөнгөн хөрөнгө, 7.5 хувийг бусад хөрөнгө буюу үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө зэрэг нь бүрдүүлж байна. Тайлант хугацаанд цэвэр зээлийн багц өмнөх оны мөн үетэй харьцуулахад 16.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

*График 22: Хөрөнгийн бүтэц (тэрбум.төгрөг)*




УЛААНБААТАР ХОТ
ЛЭНДМН АКТИВ ТЭК ХХК
9022080559
ХТҮ4977 6888895

РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
RHINOS INVESTMENT UTsK
УЛААНБААТАР ХОТ
9019120768 6481299

### 2.3.3 Зээлийн багц

2020 онд ЛэндМН ББСБ-ын нийт зээлийн хэмжээ аудитлагдсан дүнгээр 28.7 тэрбум төгрөг байсан бол 2021 онд 15.2 хувиар өсөж 33.9 тэрбум төгрөгт хүрсэн байна. 2022 оны эхний улирлын байдлаар нийт зээлийн үлдэгдэл 35.5 тэрбум төгрөг байгаа нь 2021 оны мөн үетэй харьцуулахад 13.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна. 2022 оны 1-р улиралд нийт зээлд эзлэх хугацаа хэтэрсэн зээл 3 хувь, чанаргүй зээл 6.5 хувь байна. Энэ нь 2022 оны финтек ББСБ салбарын чанаргүй зээлийн түвшин болох 7.9 хувьтай харьцуулахад 1.4 нэгж хувиар бага буюу ЛэндМН ББСБ ХК-ийн зээлийн багцын чанар сайн байгааг харуулж байгаа юм.

*График 23: Зээлийн багц, чанараар*




2022 оны 1-р улирлын байдлаар ЛэндМН ББСБ ХК-ийн нийт зээлийн багцын 93.2 хувийг цахим зээл бүрдүүлж байна. Энэ нь харилцагчдынхаа цаг хугацааг хэмнэж санхүүгийн асуудлаа шийдэхэд тусалдагаараа онцлог юм. Мөн 2022 оны 1-р улирлын байдлаар хэрэглээний зээлийн дундаж үлдэгдэл 191.6 мянган төгрөг, эко автомашины зээлийн дундаж үлдэгдэл 16.2 сая төгрөг байна.

### 2.3.4 Эх үүсвэр(пассив)

2021 жилийн эцсийн байдлаар ЛэндМН ББСБ ХК-ийн нийт хөрөнгийн 42.5 хувийг өр төлбөрөөр, 57.5 хувийг эздийн өмчөөр санхүүжүүлсэн байна. 2021 оны 8 сард бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлэхэд зориулан эздийн өмчийг 2.845 тэрбум төгрөгийн хоёрдогч өглөгөөр нэмэгдүүлэн өөрийн хөрөнгийн хэмжээ 2021 онд 22.6 тэрбум төгрөгт хүрсэн.

СЗХ
2022 .10 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-07
БҮРТГЭВ-02





*График 24: Өөрийн хөрөнгийн бүтэц /сая.төгрөг/*

Мөн ЛэндМН ББСБ ХК нь хувьцааны ханшийг тогтворжуулах, хувьцааны хөрвөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор 2021 оны эцсийн байдлаар 2.3 тэрбум төгрөгийн хувьцааг эргүүлэн худалдан авсан байна. ЛэндМН ББСБ ХК нь 2022 оны 1-р улиралд 2021 оны жилийн эцсийн цэвэр ашигаас компанийн хувьцаа эзэмшигчдэд нэгж хувьцаанд 1.5 төгрөг буюу нийт 1.1 тэрбум төгрөгийн ногдол ашгийг хуваарилсан.

*График 25: Өр төлбөрийн бүтэц /сая.төгрөг/*




2022 оны 1-р улиралд нийт өр төлбөр 18.3 тэрбум төгрөг, үүнд ББСБ-аас гаргасан өрийн бичиг, итгэлцлийн үйлчилгээний өглөг болон бусад өр төлбөр багтаж байгаа бол хоёрдогч өглөг болон хувьцаат капиталаас бүрдсэн эздийн өмч 22.5 тэрбум төгрөг байна.

УЛААНБААТАР ХОТ
ЛЭНДМН АКТИВ ТЭК ХХК
9022080669
ХТУ4977 6888895

РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
RHINOS INVESTMENT UTsK
УЛААНБААТАР ХОТ



УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2022 .06 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -10- 07



## 2.3.5 Орлогын тайлан

*Хүснэгт 6: Орлогын тайлан*

| Нэгж: тэрбум төгрөг | 2020 | 2021 I | 2021 II | 2021 III | 2021 IV | 2022 I |
|---|---|---|---|---|---|---|
| Нийт орлого (өссөн дүнгээр) | 16.39 | 2.93 | 6.05 | 9.00 | 12.52 | 3.80 |
| Хүүгийн зардал | -2.93 | -0.45 | -0.81 | -1.08 | -1.44 | -0.85 |
| **Цэвэр хүү болон түүнтэй адилтгах орлого** | **13.46** | **2.48** | **5.24** | **7.92** | **11.08** | **2.95** |
| Эрсдэлийн сангийн зардал | -1.15 | -0.07 | -0.08 | -0.47 | -0.08 | -0.35 |
| **Үйл ажиллагааны цэвэр орлого** | **12.31** | **2.41** | **5.16** | **7.45** | **11.00** | **2.60** |
| Удирдлагын болон үйл ажиллагааны зардал | -8.38 | - 1.51 | -3.10 | -4.27 | -6.50 | -1.55 |
| **Татвар төлөхийн өмнөх ашиг/алдагдал** | **3.93** | **0.90** | **2.06** | **3.18** | **4.50** | **1.05** |
| Орлогын албан татварын зардал | -0.42 | -0.10 | -0.24 | -0.34 | -0.48 | -0.12 |
| **Цэвэр ашиг** | **3.51** | **0.80** | **1.82** | **2.84** | **4.02** | **0.93** |

2022 оны 1-р улирлын байдлаар ЛэндМН ББСБ ХК-ийн нийт хүү болон түүнтэй адилтгах орлого нь өссөн дүнгээр 3.80 тэрбум төгрөг байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 29.7 хувиар, цэвэр хүүний орлого 2.95 тэрбум төгрөгт хүрч өмнөх онтой харьцуулахад 18.49хувиар өссөн үзүүлэлттэй байна.

*График 26: Хүү болон түүнтэй адилтгах орлого /тэрбум.төгрөг/*




Цэвэр ашгийн хувьд 2021 онд 4 тэрбум төгрөгт хүрч 2020 онтой харьцуулахад 12.8 хувиар өссөн бол 2022 оны 1-р улирлын байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад 14.3 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

УЛААНБААТАР ХОТ
ЛЭНДМН АКТИВ ТЭК ХХК
9022080669
РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
RHINOS INVESTMENT UTsK
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
2022 .09 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-07
БҮРТГЭВ-02



## 2.3.6 Санхүүгийн харьцаа үзүүлэлтүүд

*Хүснэгт 7: Санхүүгийн харьцаа үзүүлэлтүүд*

| | 2020 | 2021 | 2022 I |
|---|---|---|---|
| **Ашигт ажиллагаа** | | | |
| Цэвэр хүүний орлогын маржин ХО/НХ | 33.0% | 28.2% | 7.2% |
| Цэвэр ашгийн маржин ЦА/ХО | 21.4% | 32.1% | 24.5% |
| Нийт хөрөнгийн өгөөж ЦА/НХ | 8.6% | 10.2% | 2.3% |
| Өөрийн хөрөнгийн өгөөж ЦА/ЭӨ | 19.8% | 17.8% | 4.1% |
| Цэвэр зээл/Нийт хөрөнгө | 62.4% | 80.7% | 80.9% |
| **Санхүүгийн хөшүүрэг** | | | |
| Өр төлбөр/Эздийн өмчийн харьцаа | 130.0% | 73.9% | 81.3% |
| Өр төлбөр/Нийт хөрөнгө | 56.5% | 42.5% | 44.8% |
| **Хөрвөх чадвар** | | | |
| Эргэлтийн харьцаа | 3.8 | 5.2 | 5.4 |

## 2.3.7 Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд

*Хүснэгт 8: Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд*

| № | Зохистой Үзүүлэлт | Байвал Зохих | Тайлангаар | Хангасан Эсэх |
|---|---|---|---|---|
| | **Өөрийн Хөрөнгийн Хүрэлцээний Үзүүлэлт** | | | |
| 1 | Нэгдүгээр Зэрэглэлийн Өөрийн Хөрөнгө, Эрсдэлээр Жигнэсэн Нийт Активын Харьцаа | 10%-аас доошгүй | 46.5% | **Хангасан** |
| 2 | Өөрийн Хөрөнгө, Эрсдэлээр Жигнэсэн Нийт Активын Харьцаа | 20%-аас доошгүй | 53.2% | **Хангасан** |
| 3 | Нэгдүгээр Зэрэглэлийн Өөрийн Хөрөнгө, Нийт Активын Харьцаа | 10%-аас доошгүй | 48.2% | **Хангасан** |
| | **Төлбөр Түргэн Гүйцэтгэх Чадварын Харьцаа** | | | |
| 4 | Төлбөр Түргэн Гүйцэтгэх Чадварын Харьцаа | 8%-аас дээш | 25.7% | **Хангасан** |
| | **Актив Хөрөнгийн Төвлөрлийн Үзүүлэлт** | | | |
| 5 | Хөрөнгө /Актив/-Ийн Эрсдэлийн Сангийн Хүрэлцээ (+Илүү,- Дутуу ) | 1,412,067.64-с доошгүй | 2,534,566.0 | **Хангасан** |
| 6 | Нэг Зээлдэгч Болон Холбогдох Этгээдэд Олгосон Зээл, Зээлтэй Адилтган Тооцох Бусад Актив Хөрөнгө, Төлбөрийн Баталгааны Зохистой Харьцаа | 30%-аас хэтрэхгүй | 0.2% | **Хангасан** |
| 7 | ББСБ-аас Гаргасан Төлбөрийн Баталгааны Зохистой Харьцаа | 70%-аас хэтрэхгүй | 0.0% | **Хангасан** |
| 8 | ББСБ-ын Хувьцаа Эзэмшигч, Туз, Гүйцэтгэх Захирал Ажилтан Холбогдох Этгээдэд Олгосон Зээл, Зээлтэй Адилтган Тооцох Бусад Актив Хөрөнгө, Төлбөрийн Баталгааны Нийлбэр Дүнгийн Зохистой Харьцаа | 25%-аас хэтрэхгүй | 0.4% | **Хангасан** |
| 9 | ББСБ-ын Хувьцаа Эзэмшигч, Туз, Гүйцэтгэх Захирал Ажилтан, Холбогдох Нэг Этгээдэд Олгосон Зээл, Зээлтэй Адилтган Тооцох Бусад Актив Хөрөнгө, Төлбөрийн Баталгааны Зохистой Харьцаа | 10%-аас хэтрэхгүй | 0.1% | **Хангасан** |
| 10 | Үнэт Цаасны Эзэмшил Өөрийн Хөрөнгийн Зохистой Харьцаа | 50%-аас хэтрэхгүй | 0.0% | **Хангасан** |

УЛААНБААТАР ХОТ
ЛЭНДМН АКТИВ ТЗК ХХК
9022080569
ХТҮ4977 6888095



РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
RHINOS INVESTMENT ҮЦК
УЛААНБААТАР ХОТ
9019129768 5681299

УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2022 .09сар21 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-07



| | | | | |
|---|---|---|---|---|
| 11 | Компанийн Хувьцаа, Өөрийн Хөрөнгийн Зохистой Харьцаа | 20%-аас хэтрэхгүй | 0.0% | **Хангасан** |
| 12 | Монголын Хөрөнгийн Биржийн "I", "II" Ангилалын Нэг Компанийн Гаргасан Хувьцаанаас Худалдаж Авах Зохистой Харьцаа | 20%-аас хэтрэхгүй | 0.0% | **Хангасан** |
| 13 | Компанийн Өрийн Бичиг Өөрийн Хөрөнгийн Зохистой Харьцаа | 20%-аас хэтрэхгүй | 0.0% | **Хангасан** |
| 14 | Бусад Үнэт Цаас, Үнэт Цаасны Эзэмшлийн Зохистой Харьцаа | 10%-аас хэтрэхгүй | 0.0% | **Хангасан** |
| | **Гадаад Валютын Ханшийн Эрсдэл** | | | |
| 15 | Гадаад Актив, Пассивын Зөрүү Өөрийн Хөрөнгийн Зохистой Харьцаа | (+/-40%) | -11.0% | **Хангасан** |
| | **Бусдаас Татан Төвлөрүүлсэн Хөрөнгийн Үзүүлэлтүүд** | | | |
| 16 | Итгэлцлийн Үйлчилгээний Өглөг Өөрийн Хөрөнгийн Зохистой Харьцаа | 80%-аас хэтрэхгүй | 35.5% | **Хангасан** |
| 17 | Өрийн Бичгийн Зохистой Харьцаа | 50%-аас хэтрэхгүй | 32.6% | **Хангасан** |
| | **Үндсэн Хөрөнгийн Үзүүлэлт** | | | |
| 18 | Үндсэн Хөрөнгийн Зохистой Харьцаа | 15%-аас хэтрэхгүй | 2.0% | **Хангасан** |

СЗХ-оос баталсан "Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам"-ын дагуу ББСБ нь 18 шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллах шаардлагатай байдаг. Тус зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг ЛэндМН ББСБ ХК нь 2016 оноос хойш буюу үйл ажиллагаа эхэлснээс хойш тасралтгүй хангаж ажиллаж байна.

2022 оны 1-р улирлын байдлаар өөрийн хөрөнгийн хүрэлцээ хангалттай, төлбөр гүйцэтгэх чадвар сайн, хөрөнгийн төвлөрөл бага, гадаад валютын ханшийн эрсдэл маш бага буюу зохицуулагч байгууллагаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажилласан байна.

УЛААНБААТАР ХОТ
ЛЭНДМН АКТИВ ТЗК ХХК
9022080559
ХТҮ4977 ☏ 0888895



РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
RHINOS INVESTMENT UCK LLC
УЛААНБААТАР ХОТ
9019120768 ☏ 6481299

## 2.3.8 Сүүлийн 3-н жилийн аудитлагдсан санхүүгийн тайлан

Санхүү байдлын хураангуй тайлан

| MNT'000 | 2019 | 2020 | 2021 |
|---|---|---|---|
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 2,382,196 | 10,348,101 | 4,903,678 |
| Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа | 49,457,676 | 25,430,960 | 32,426,047 |
| Бусад хөрөнгө | 4,756,978 | 3,372,542 | 732,584 |
| Үндсэн хөрөнгө | 1,162,101 | 1,126,560 | 763,282 |
| Биет бус хөрөнгө | 342,002 | 403,145 | 447,838 |
| Хойшлогдсон татварын хөрөнгө | | 54,152 | 33,133 |
| **Нийт хөрөнгө** | **58,100,953** | **40,735,460** | **39,306,562** |
| Бондын өглөг | 3,601,164 | 7,266,443 | 7,321,652 |
| Итгэлцлийн үйлчилгээний өглөг | 13,845,212 | 10,364,269 | 7,753,394 |
| Банкны зээлийн өглөг | 21,133,646 | 2,858,668 | 2,946,544 |
| Цахим хэтэвчээрх өглөг | 964,265 | - | - |
| Бусад өглөг | 1,358,188 | 2,532,262 | 1,471,099 |
| **Нийт өр төлбөр** | **40,902,475** | **23,021,642** | **19,492,689** |
| Хувьцаат капитал | 10,756,859 | 10,756,859 | 10,756,859 |
| Халаасны хувьцаа | (266,086) | (988,939) | (2,337,547) |
| Бусад | 57,348 | 57,348 | 57,348 |
| Хуримтлагдсан ашиг | 6,650,357 | 7,888,550 | 11,337,213 |
| **Нийт эздийн өмч** | **17,198,478** | **17,713,818** | **19,813,873** |
| **Нийт өр төлбөр болон эздийн өмч** | **58,100,953** | **40,735,460** | **39,306,562** |

Орлого, үр дүнгийн хураангуй тайлан

| MNT'000 | 2019 | 2020 | 2021 |
|---|---|---|---|
| Шимтгэл болон түүнтэй адилтгах орлого | 18,321,082 | 16,377,802 | 12,491,742 |
| Хүүгийн зардал | (4,654,241) | (4,723,510) | (2,798,653) |
| **Цэвэр орлого** | **13,666,841** | **11,654,292** | **9,693,089** |
| Зээлийн болзошгүй эрсдлийн нөөцийн зардал | (1,618,802) | (2,360,681) | 725,556 |
| **Үйл ажиллагааны цэвэр орлого** | **12,048,039** | **9,293,611** | **10,418,645** |
| Удирдлагын болон ҮА-ны зардал | (6,016,664) | (6,538,130) | (5,947,174) |
| **Нийт зардал** | **(6,016,664)** | **(6,538,130)** | **(5,947,174)** |
| Татварын өмнөх ашиг | 6,031,375 | 2,755,481 | 4,471,471 |
| Татварын зардал | (1,121,186) | (323,288) | (469,564) |
| **Цэвэр ашиг** | **4,910,189** | **2,432,193** | **4,001,907** |
| Зогсоосон үйл ажиллагааны тайлант үеийн татварын дараах алдагдал | - | - | (110,996) |
| **Тайлант хугацааны цэвэр ашиг буюу хувьцаа эзэмшигчдэд ногдох нэгдсэн орлого** | **4,910,189** | **2,432,193** | **3,890,911** |

СЗХ
он сар өдөр 2022.09.21
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-07
БҮРТГЭВ-02

lendmn

# ГУРАВ. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ

СЗХ
2022 .09 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 11

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-07



## 3.1 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТАНИЛЦУУЛГА

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.4 дүгээрт "Тусгай зориулалтын компанийг банк, банк бус санхүүгийн байгууллага, орон сууцны санхүүжилтийн компани болон Хорооноос зөвшөөрсөн санхүүгийн бусад байгууллага байгуулж болно" хэмээн заасны дагуу ЛэндМН ББСБ ХК нь ЛэндМН Актив ХХК-ийг үүсгэн байгуулсан билээ.

ЛэндМН Актив ХХК нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 6.1, 7.2 болон 11.1 дүгээрт заасны дагуу Санхүүгийн зохицуулах хорооноос хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл авсанаар ЛэндМН Актив ТЗК ХХК болон өөрчлөгдсөн болно.

| | | |
|---|---|---|
| 1 | Хуулийн этгээдийн нэр | ЛэндМН Актив ТЗК ХХК |
| 2 | Үүсгэн байгуулсан огноо | 2022 он 06 сар 16 өдөр |
| 3 | Бүртгэгдсэн огноо | 2022 он 07 сар 03 өдөр |
| 4 | Улсын бүртгэлийн дугаар | 9011841085 |
| 5 | Регистрийн дугаар | 6888895 |
| 6 | Үйл ажиллагааны чиглэл | Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах |
| 7 | Холбоо барих | 976- 7722 2992 |
| 8 | Хаяг | Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 3-р хороо, Жуулчны гудамж-34, Сувд төв 2тоот |
| 9 | Цахим хаяг | www.lend.mn |
| 10 | Цахим шуудан | contact@lend.mn |

### 3.1.1 Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчийн мэдээлэл

*Хүснэгт 9: Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчийн мэдээлэл*

| | | |
|---|---|---|
| 1 | Хувьцааны төрөл | Энгийн |
| 2 | Хувьцааны тоо | 80 |
| 3 | Нэрлэсэн үнэ | 1,000,000 төгрөг |
| 4 | Хувьцаа эзэмшигчийн тоо | 1 |
| 5 | Хувьцаа эзэмшигч | ЛэндМН ББСБ ХК |
| 6 | Эзэмшиж буй хувь | 100 хувь |
| 7 | Өөрийн хөрөнгийн хэмжээ | 80,000,000 төгрөг |

## 3.2 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

### 3.2.1 Хувьцаа эзэмшигчдийн хурал

ТЗК-ийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал /цаашид "**ХЭХ**" гэх/ байх ба ХЭХ-ын эрх хэмжээ болон бусад асуудлыг Компанийн тухай хуульд заасан журмын дагуу зохицуулна.

Компанийн ХЭХ-ын бүрэн эрхийг ТЗК-ийн дүрмийн 1.4-т заасан цор ганц хувьцаа эзэмшигч болох "ЛэндМН ББСБ" ХК хэрэгжүүлэх бөгөөд ингэхдээ "ЛэндМН ББСБ" ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлөөс томилсон бүрэн эрхт

УЛААНБААТАР ХОТ
ЛЭНДМН АКТИВ ТЗК ХХК
9022080559
ХТҮ4977 ⊕ 6888895



РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ

төлөөлөгч буюу "ЛэндМН ББСБ" ХК-ийн Гүйцэтгэх захирлаар дамжуулан хэрэгжүүлнэ. "ЛэндМН ББСБ" ХК-ийн Гүйцэтгэх захирал нь өөрт олгогдсон бүрэн эрхийн хүрээнд ТЗК-ийн ХЭХ-ын эрхийг хэрэгжүүлж, шийдвэр гаргана.

Компанийн ХЭХ-ыг хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай Компанийн ТУЗ-ийн шийдвэр гарснаас хойш 5-аас доошгүй хоногийн дараа хуралдуулна.

Компанийн ХЭХ-ын чөлөөт цагт Компанийн эрх барих дээд байгууллагын бүрэн эрхийг Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл /цаашид "**ТУЗ**" гэх/ хэрэгжүүлнэ.

**3.2.2 Төлөөлөн удирдах зөвлөл**

ТЗК-ийн ТУЗ нь Компанийн үйл ажиллагааг удирдаж, хяналт тавьж ажиллах чиг үүрэгтэй байна. ТУЗ нь өөрийн үйл ажиллагаандаа ТУЗ-ийн үйл ажиллагааны журмыг баримтална.

- ТЗК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь **3 (гурав)** гишүүнтэй байх бөгөөд нийт гишүүдийн **2 (хоёр)** нь хараат бус гишүүн байна. Компанийн ТУЗ-ийн гишүүдийг ХЭХ-ын шийдвэрээр томилж, чөлөөлнө.
- ТЗК-ийн ТУЗ-ийн гишүүд нь Компанийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журамд заасан шаардлагыг хангасан байна.
- ТЗК-ийн ТУЗ-ийн гишүүнийг чөлөөлсөн, эсхүл аливаа шалтгаанаар гишүүний эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсон тохиолдолд Компанийн ХЭХ-ын шийдвэрээр нөхөн сонгоно.

ТЗК-ийн ТУЗ нь Компанийн тухай хуульд заасан бүрэн эрхээс гадна дор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Компанийн дүрмийн хэрэгжилтийг хангуулах;
- ТЗК-ийн хөрөнгийг хадгалж, хамгаалах;
- Эрх бүхий байгууллагаас хөрөнгө итгэмжлэн удирдах тусгай зөвшөөрөл авсан этгээдтэй гэрээ байгуулсны үндсэн дээр Компанийн өдөр тутмын удирдлагыг гүйцэтгүүлэх,
- Компанийн хөрөнгийг Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт заасан хөрөнгө итгэмжлэн удирдагчийн эзэмшил, удирдлагад шилжүүлэх. Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээг байгуулснаас хойш хууль тогтоомжид заасны дагуу хөрөнгө итгэмжлэн удирдагчийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохыг хориглоно.

- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасны дагуу хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд заасан эрх үүргийн дагуу хяналт тавих,
- Энэхүү дүрэмд заасан Компанийн зөвшөөрөгдсөн ажил хэрэг болон үйл ажиллагаатай холбоотой гэрээ болон бусад баримт бичиг байгуулах,
- Компанийн нэр дээр банкны данс нээлгэх, аудит, тайлан бүртгэлийг хянах, хөрөнгө оруулагчдад төлөх төлбөр болон бусад төлбөр, зардлын төсвийг батлах,
- Компанийн худалдан авсан зээлийн хөрөнгөд үйлчилгээ үзүүлж буй этгээдийн гүйцэтгэлийг хянах, шаардлагатай бол тэдгээрийг солих санал гаргах,
- Компани нь өөрийн байгуулсан гэрээ болон бусад баримт бичгүүдээр хүлээсэн үүргээ чанд мөрдөж, гүйцэтгэж байгаад хяналт тавьж, хангуулах,
- Компанийн байгуулсан гэрээ болон бусад баримт бичгүүдээр Компанид олгогдсон бүх эрх болон эрх хамгаалах хэрэгслийг хэрэгжүүлэх,
- ТЗК-ийн үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулж буй хууль тогтоомж, Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын Хөрөнгийн биржийн журам болон Компанийн дүрэм, Компанийн дотооддоо дагаж мөрдөж буй журам, зааварт заасан бусад бүрэн эрхийг хэрэгжүүлэх.

ТЗК-ийн ТУЗ нь улиралд нэгээс доошгүй удаа хуралдана. Шаардлагатай гэж үзвэл ТУЗ-ийн даргын санаачилгаар, эсхүл ТУЗ-ийн гишүүдийн олонхийн санал, эсхүл Хөрөнгө итгэмжлэн удирдагч, Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн санал, шаардлагаар ээлжит бус хурлыг хуралдуулж болно.

ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх олонх нь оролцсоноор хурлын ирцийг бүрдүүлэх ба Компанийн тухай хууль болон энэхүү дүрэмд өөрөөр заасанаас бусад тохиолдолд ТУЗ-ийн шийдвэр нь хуралд оролцсон гишүүдийн дийлэнх олонхын саналаар батлагдана.

ТУЗ-ийн гишүүн нь Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлд заасны дагуу эрх бүхий албан тушаалтанд тооцогдох бөгөөд тус хуулийн 85 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээнэ.

Компанийн тухай хууль болон энэхүү дүрэмд өөрөөр заагаагүй бол ТУЗ-ийг төлөөлж аливаа баримт бичигт ТУЗ-ийн дарга гарын үсэг зурна.

ТУЗ болон түүний гишүүдийн бүрэн эрхийн хугацаа нь Компани Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1

дэх хэсэгт заасан хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл авсан үеэс эхлэн Компани татан буугдах буюу ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан үндэслэлээр бүрэн эрхийг дуусгавар болгох хүртэл хугацаанд үргэлжилнэ.

## Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөл



**А. Ганбат**

**ТУЗ-ийн дарга, Хараат бус гишүүн**

**Боловсрол**

Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улс, "Стратклидын Их Сургууль"- Хөрөнгө оруулалт болон Санхүүгийн магистр

Япон Улс, "Киото их сургууль"- Шинжлэх ухааны сургууль, Математик болон Математикийн ухааны доктор

Монгол Улсын Их Сургууль, Математик компьютерын сургууль, Математикийн ухааны бакалавр

**Туршлага**

Мирэ Эссет Секьюритис Монгол ҮЦК ХХК, Хөрөнгө оруулалтын менежер

Монголбанк, Эдийн засагч

Монголбанк, Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн ажлын албаны дарга

Монгол Улсын Их Сургууль, Туслах Профессор



**Ө.Болортуяа**

**ТУЗ-ийн хараат бус гишүүн**

**Боловсрол**

Монгол Улсын Их Сургууль, Хууль зүйн сургууль, Эрх зүйн магистр

Монгол Улсын Их Сургууль, Хууль зүйн сургууль, Эрх зүйн бакалавр

**Туршлага**

Өмгөөллийн "Цогт энд Нандин" ХХН - Гүйцэтгэх захирал

Өмгөөллийн "Цогт энд Нандин" ХХН - Нөхөрлөлийн гишүүн /Партнер/

Өмгөөллийн "Цогт энд Нандин" ХХН - Хуульч, Ахлах хуульч

"Алтайн Хүдэр" ХХК - Хуулийн мэргэжилтэн



**Б.Удвал**

**ТУЗ-ийн гишүүн**

**Боловсрол**

Турк Улс, Анкарагийн Их сургууль, Эдийн засагч, магистр

Турк Улс, Анкарагийн Их сургууль, Эдийн засагч, бакалавр

Монгол Улсын Их Сургууль, Математикийн факультет

**Туршлага**

ЛэндМН ББСБ ХК, Дэд захирал, Гүйцэтгэх захирал

Ашид Капитал ББСБ ХХК, Дата хэлтсийн дарга

М-Си-Эс групп, М төсөл, "М" ХХК, Бизнес хөгжил, дата судалгааны багийн ахлагч

Анунгоо ХХК, Бизнес хөгжил, хангамж хариуцсан захирал, Маркетинг хариуцсан захирал

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасны дагуу ТЗК нь ажилтангүй байх тул Гүйцэтгэх удирдлага байхгүй болно.

СЭХ 2022 .10 сар 21 өдөр БҮРТГЭВ №: 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2022-10-07 БҮРТГЭВ-02



## 3.3 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ЭХЛЭЛТИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах зорилго бүхий ЛэндМН Актив ТЗК-ийн эхлэлтийн санхүүгийн тайлан нь дараах болно. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс шилжүүлсэн 5,335,006,689 төгрөгийн зээлийн багцын хөрөнгө болон 80.0 сая төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээтэй байна.

*Хүснэгт 10: Үнэт цаас гаргагчийн эхлэлтийн баланс*

| Үзүүлэлт | сая.төгрөг |
|---|---:|
| Мөнгөн хөрөнгө | 80 |
| **НИЙТ ХӨРӨНГӨ** | **80** |
| Хувьцаат капитал | 80 |
| **НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ** | **80** |

## 3.4 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН САНХҮҮГИЙН ТӨСӨӨЛӨЛ

### 3.4.1 Санхүү байдлын тайлангийн төсөөлөл

Үнэт цаас гаргагчийн санхүү байдлын тайлангийн төсөөллийг дараах байдлаар төсөвлөсөн болно.

*Хүснэгт 11: Санхүү байдлын тайлангийн төсөөлөл/сая.төгрөг/*

| Үзүүлэлт | 0 улирал | I улирал | II улирал | III улирал | IV улирал | V улирал | VI улирал | VII улирал | VIII улирал |
|---|---:|---:|---:|---:|---:|---:|---:|---:|---:|
| Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө | 80 | 451 | 542 | 539 | 536 | 531 | 525 | 520 | 70 |
| Зөвшөөрөгдсөн хөрөнгө оруулалт | | - | 288 | 677 | 1,080 | 1,497 | 1,924 | 2,364 | - |
| Дансны авлага | 5,335 | 4,969 | 4,599 | 4,216 | 3,826 | 3,423 | 3,010 | 2,582 | 65 |
| **Нийт хөрөнгө** | **5,415** | **5,420** | **5,428** | **5,432** | **5,443** | **5,451** | **5,460** | **5,466** | **135** |
| Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны өглөг | 4,850 | 4,850 | 4,850 | 4,850 | 4,850 | 4,850 | 4,850 | 4,850 | - |
| Бусад өглөг | 485 | 485 | 485 | 485 | 485 | 485 | 485 | 485 | - |
| Өр төлбөрийн дүн | 5,335 | 5,335 | 5,335 | 5,335 | 5,335 | 5,335 | 5,335 | 5,335 | - |
| Хувь нийлүүлсэн хөрөнгө | 80 | 80 | 80 | 80 | 80 | 80 | 80 | 80 | 80 |
| Хуримтлагдсан ашиг | - | 5 | 13 | 17 | 28 | 36 | 45 | 51 | 55 |
| Нийт өөрийн хөрөнгө | 80 | 85 | 93 | 97 | 108 | 116 | 125 | 131 | 135 |
| **Өр төлбөр ба эздийн өмч** | **5,415** | **5,420** | **5,428** | **5,432** | **5,443** | **5,451** | **5,460** | **5,466** | **135** |

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн тооцоолол*

УЛААНБААТАР ХОТ ЛЭНДМН АКТИВ ТЗК ХХК 9022080659 ХТҮ4977 6888895

РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК RHINOS INVESTMENT LLC УЛААНБААТАР ХОТ

СЭХ
2022 .09 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-07



### 3.4.2 Орлогын тайлангийн төсөөлөл

Үнэт цаас гаргагчийн орлогын тайлангийн төсөөллийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс шилжүүлж буй зээлийн багцаас орох мөнгөн урсгал болон төлөвлөж буй зардалд үндэслэн дараах байдлаар боловсруулсан болно.

*Хүснэгт 12: Орлогын тайлангийн төсөөлөл/сая.төгрөг/*

| Үзүүлэлт | I улирал | II улирал | III улирал | IV улирал | V улирал | VI улирал | VII улирал | VIII улирал |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Хүүгийн орлого** | **401** | **391** | **382** | **371** | **360** | **347** | **334** | **303** |
| ХБҮЦ-ийн хүүгийн төлбөр | (206) | (206) | (208) | (206) | (206) | (208) | (208) | (203) |
| Цэвэр хүүгийн орлого | 196 | 185 | 174 | 166 | 154 | 140 | 126 | 100 |
| Эрсдэлийн сангийн зардал | (127) | (113) | (107) | (91) | (82) | (66) | (57) | (32) |
| **Эрсдэлийн сангийн дараах ашиг** | **69** | **72** | **67** | **75** | **72** | **73** | **69** | **68** |
| Үйл ажиллагааны зардал | (63) | (63) | (63) | (63) | (63) | (63) | (63) | (63) |
| **Татварын өмнөх ашиг** | **6** | **9** | **4** | **12** | **9** | **10** | **6** | **5** |
| Татварын зардал | (1) | (1) | 0 | (1) | (1) | (1) | (1) | (1) |
| **Цэвэр ашиг** | **5** | **8** | **4** | **11** | **8** | **9** | **6** | **5** |

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн тооцоолол*

### 3.4.3 Зардлын төсөөлөл

Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2022 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн 22/11 тоот тогтоолоор баталсан "Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх тухай журам"-ын дагуу Үнэт цаас гаргагч нь хүүний болон үндсэн төлбөрийг Үнэт цаас эзэмшигчид олгохоос өмнө ТЗК-ийн татвар, ХБҮЦ-ны хүүгийн орлогын татвар, Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн ажлын хөлс, Үйлчилгээ үзүүлэгчийн төлбөр, Захиргааны үйлчилгээ үзүүлэгчийн хөлс, Хөндлөнгийн аудитын ажлын төлбөр, ТУЗ-ийн гишүүдийн цалингийн зардлыг төлөхөөр төсөвлөсөн болно.

*Хүснэгт 13: Үйл ажиллагааны зардлын төсөөлөл*

| Үйл ажиллагааны жилийн зардал | Нийт дүн | Төлбөр төлөх Давтамж |
|---|---|---|
| **Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн үйлчилгээний төлбөр** | Удирдаж буй хөрөнгийн 0.5% (жилийн) | Сар бүр |
| **Үйлчилгээ үзүүлэгчийн үйлчилгээний төлбөр** | Цуглуулсан төлбөрийн 1.5% (сарын) | Сар бүр |
| **Хөндлөнгийн аудитын зардал** | 15,000,000 | Жил бүр |
| **Ерөнхий удирдлагын зардал /ТУЗ-ийн гишүүдийн цалин/** | 10,256,400 | Улирал бүр |

УЛААНБААТАР ХОТ
ЛЭНДМН АКТИВ ТЗК ХХК
9022080559
ХТУ4977 ⊕ 6888895



РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
RHINOS INVESTMENT ҮЦК LLC
УЛААНБААТАР ХОТ
9019120763

УЛААНБААТАР ХОТ

### Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн үйлчилгээний төлбөр

Юнайтед Айр Файнэнс ХХК нь Үнэт цаас гаргагчтай Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээг байгуулж ТЗК-ийн бүхий л мөнгөн хөрөнгийг удирдах ба үйлчилгээний төлбөр нь удирдаж буй хөрөнгийн жилийн 0.5 хувь байхаар тохиролцсон болно. ТЗК нь Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн үйлчилгээний төлбөрийг сар бүр шилжүүлнэ.

### Үйлчилгээ үзүүлэгчийн үйлчилгээний төлбөр

Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2022 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн 22/11 тоот тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх тухай журам”-ын дагуу Үйлчилгээ үзүүлэгч ЛэндМН ББСБ ХК нь Үнэт цаас гаргагчийн хөрөнгийн багцын зээлийн эргэн төлөлтийг дараа сарын 10-ны өдөрт багтаан холбогдох авлагыг суутган төлбөр цуглуулах данс руу шилжүүлэх үүрэгтэй. Энэхүү үйлчилгээний төлбөр нь цуглуулсан төлбөрийн 1.5 хувьтай тэнцэнэ. Үйлчилгээ үзүүлэгч нь “Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх тухай журам”-ын 2.3.4-т заасны дагуу зээлийн эргэн төлөлтийг тооцоолсон зээлийн данс бүртгэлийг хөтөлж, зээлийн болон төлбөрийн мэдээллийг сард нэг удаа нэгтгэн дараа сарын ажлын 3 өдөрт багтаан Үнэт цаас гаргагч болон Хөрөнгө итгэмжлэн удирдагч компанид хүргүүлэн тайлагнана.

### Ерөнхий ба удирдлагын зардал

Үнэт цаас гаргагчийн компанийн ерөнхий үйл ажиллагаатай холбоотой ерөнхий ба удирдлагын зардал нь жилд 10.3 сая төгрөг байна.

### Хөндлөнгийн аудитын үйлчилгээний төлбөр

СЗХ-ны “ХБҮЦ гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журам”-ын 8.1-т заасны дагуу Үнэт цаас гаргагч нь жилд нэгээс багагүй удаа аудит хийлгэх шаардлагатай. Тус хүрээнд Үнэт цаас гаргагч нь Нийслэл Аудит ХХК-тай Аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээг байгуулсан. Тус гэрээний төлбөр жилийн 15.0 сая төгрөг байна.

### Үнэт цаасны төлбөрийг төлсний дараах үлдэгдлийн мэдээлэл

“Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам”-ын 2.9.5-т заасан болон Үнэт цаас гаргагчийн санхүүгийн төсөөллөөр үнэт цаас гаргагч нь хөрөнгө оруулагчдад үнэт цаасны төлбөрийг болон бусад холбогдох бүхий л төлбөрийг төлж барагдуулсаны дараа 70 сая төгрөгийн үлдэгдэл бий болохоор төсөөлсөн бөгөөд энэхүү үлдэгдэл мөнгөн хөрөнгийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгч буюу ЛэндМН ББСБ ХК-д ногдол ашиг болгон хуваарилна.

СЗХ
2022 .09 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-07
БҮРТГЭВ-02



### 3.4.4 Мөнгөн урсгалын төсөөлөл

*Хүснэгт 14: Мөнгөн урсгалын төсөөлөл/сая.төгрөг/*

| Үзүүлэлт | I улирал | II улирал | III улирал | IV улирал | V улирал | VI улирал | VII улирал | VIII улирал |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Хүүний орох мөнгөн урсгал | 401 | 383 | 363 | 341 | 319 | 294 | 268 | 240 |
| Зээлийн үндсэн төлбөр | 239 | 257 | 277 | 298 | 321 | 346 | 372 | 2,000 |
| ХБҮЦ-ийн үндсэн төлбөр | - | - | - | - | - | - | - | (4,850) |
| ХБҮЦ-ийн хүүний төлбөр | (206) | (206) | (208) | (206) | (206) | (208) | (208) | (203) |
| Үйл ажиллагааны зардал | (63) | (63) | (63) | (63) | (63) | (63) | (63) | (63) |
| Татварын зардалд төлсөн төлбөр | (1) | (1) | - | (1) | (1) | (1) | (1) | (1) |
| **Үйл ажиллагааны мөнгөн урсгал** | **371** | **371** | **369** | **370** | **371** | **368** | **369** | **(2,877)** |
| Зээл худалдан авалт | - | (288) | (390) | (403) | (416) | (428) | (439) | 2,364 |
| **Хадгаламжийн хүүгийн орлого** | - | 8 | 19 | 30 | 41 | 53 | 66 | 63 |
| Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн урсгал | **-** | **(280)** | **(371)** | **(373)** | **(375)** | **(374)** | **(374)** | **2,427** |
| **Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл** | 80 | 451 | 542 | 539 | 536 | 531 | 525 | 520 |
| Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 451 | 542 | 539 | 536 | 531 | 525 | 520 | 70 |
| (Харилцах, Хадгаламж+Зээл)/ХБҮЦ | **112%** | **112%** | **112%** | **112%** | **112%** | **113%** | **113%** | |

## 3.5 ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ

### Төлбөр цуглуулах данс

Үйлчилгээ үзүүлэгчийн зээлийн эргэн төлөлтийн дансанд хөрөнгийн багцаас эргэн төлөгдсөн төлбөрийг тусгайлан бүртгэх ба уг зээлийн эргэн төлөлтөөр цугласан хөрөнгийг татан төвлөрүүлэх, үнэт цаасны эргэн төлөлтийг төлөх зорилгоор ТЗК-ийн нэр дээр банкинд тусгайлан нээсэн данс байна. Мөн уг данснаас ТЗК-ийн үйл ажиллагаа болон багц бүрдүүлэхтэй холбоотой бусад зарлагын гүйлгээнүүд хийгдэх ба уг дансны захиран зарцуулах эрхтэй этгээд нь Хөрөнгө итгэмжлэн удирдагч байна.

### Хадгаламж болон зөвшөөрөгдсөн хөрөнгө оруулалт

ТЗК-ийн дансанд цугларсан чөлөөт эх үүсвэр, эрсдэлийн сангийн хөрөнгийг ашиглахгүй хугацаанд хадгаламж болон зөвшөөрөгдсөн хөрөнгө оруулалтын дансанд байршуулна. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь шаардлагатай тохиолдолд дээрх дансыг цуцлан, хөрөнгийн үлдэгдлийг

төлбөр цуглуулах данс руу татан шаардлагатай зарцуулалтуудыг хийх эрхтэй байна. Тус хадгаламжийн болон хөрөнгө оруулалтын данснаас зөвхөн ТЗК-ийн байгуулсан төлбөр цуглуулах данс руу зарлага гаргах боломжтой байна.

## 3.6 ТАТАН БУУГДАХ НӨХЦӨЛ

ЛэндМН Актив ТЗК ХХК нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 22 дугаар зүйлд зааснаас гадна, компанийн дүрмийн 8.2 дугаар зүйлд заасан дараах үндэслэлээр татан буугдана.

- Баталгаат үнэт цаасаар хүлээсэн үүргээ гүйцэтгэсэн;
- Баталгаат үнэт цаасны хөрөнгийн багцыг анхны үүрэг гүйцэтгүүлэгч, үүсгэн байгуулагч, худалдагч буцаан худалдан авсан;
- Баталгаат үнэт цаас бүрэн төлөгдөж дууссан;
- Баталгаат үнэт цаасны төлбөр төлөх болон үнэт цаасны танилцуулгад заасан үүргээ биелүүлээгүйн улмаас нийт үнэт цаасыг эзэмшиж байгаа хөрөнгө оруулагчдын гуравны хоёроос дээш хувь нь татан буулгахыг шаардсан.

СЗХ
2022 он 09 сар 21 өдөр
БҮРТГЭСЭН

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-07
БҮРТГЭВ-02

lendmn

# ДӨРӨВ. ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ

2022.09.21

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022.10.07
БҮРТГЭВ-02

## 4.1 ҮНЭТ ЦААСЖУУЛАХ ХЭЛЦЭЛ

ЛэндМН Актив ХБҮЦ-ыг зах зээлд санал болгох, үнэт цаасжуулах хэлцэлд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч/Үүсгэн байгуулагчаар ЛэндМН ББСБ ХК, Андеррайтераар Райнос Инвестмент ҮЦК ХХК болон Өлзий энд Ко Капитал ҮЦК ХХК, Хөндлөнгийн хуулийн дүгнэлт гаргагчаар Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс ХХН, Зээлийн шинжилгээ гаргагчаар Нийслэл Аудит ХХК, Хөрөнгө итгэмжлэн удирдагчаар Юнайтед Айр Файнэнс ХХК нар ажилласан. Үнэт цаасжуулах хэлцэл нь дараах байдалтай байна.

### 4.1.1 Үнэт цаас гаргах хэлцлийн бүтэц, тайлбар




1. **Үүсгэн байгуулагч, Анхны үүрэг гүйцэтгүүлэгч, Үйлчилгээ үзүүлэгч**: ТЗК байгуулж, зээлийн багцыг шилжүүлэх /Зээлийн багц шилжүүлэх, Үнэт цаасны төлбөрийг цуглуулж, ТЗК-д шилжүүлэх/
2. **Хөрөнгө оруулагч**: Үнэт цаас худалдаж авах, хүү болон үндсэн төлбөр хүлээж авах/Үнэт цаас худалдаж авах/
3. **ЛэндМН Актив ТЗК ХХК**: 4,850,000,000 төгрөг ХБҮЦ/Үнэт цаасны хүү болон үндсэн төлбөр шилжүүлэх/
4. **Аудитийн байгууллага**: Үнэт цаас гаргагчийн зээлийн багц болон санхүүд аудитын дүгнэлт гаргах /Зээлийн шижилгээ хийх, ТЗК-тай холбоотой аудитын дүгнэлт гаргах/

УЛААНБААТАР ХОТ
ЛЭНДМН АКТИВ ТЗК ХХК

РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
RHINOS INVESTMENT ҮЦК LLC
УЛААНБААТАР ХОТ

5. **Хуулийн фирм**: Багцад багтсан хөрөнгөөс санамсаргүй түүврийн аргаар сонгож, хууль зүйн шалгуур үзүүлэлт хангаж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийж, тайлан гаргах, Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан хууль зүйн мэдээлэл нь үнэн зөв, хуульд нийцсэн эсэх талаар хууль зүйн дүгнэлт гаргах /Хуулийн дүгнэлт гаргах/
6. **Хөрөнгө итгэмжлэн удирдагч**: Үнэт цаас гаргагчийн зээлийн багцыг удирдана /Багцын тайлан/, /Зээлийн хөрөнгийн багц удирдах/
7. **СЗХ**: ТЗК-ийн тусгай зөвшөөрөл болон ХБҮЦ гаргах зөвшөөрлийг олгоно.
8. **Андеррайтер**: Үнэт цаасны танилцуулга бэлтгэх, Үнэт цаас бүртгүүлэх, Анхдагч захиалгыг зохион байгуулах /Үнэт цаас бүртгүүлэх/
9. **Арилжаа эрхлэх байгууллага**: Хоёрдогч зах зээлийн арилжаа явагдах
10. **Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллага**: Үнэт цаас хадгалах

**ТЗК байгуулах**

ТЗК нь баталгаат үнэт цаас гаргах бүрд байгуулагддаг хуулийн этгээд юм. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.4-т заасны дагуу ЛэндМН ББСБ ХК нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах зорилгоор хууль журмын дагуу ЛэндМН Актив ТЗК ХХК-ийг үүсгэн байгуулсан билээ.

**Үнэт цаасжуулах хөрөнгийн багцыг сонгон шалгаруулах**

Хөрөнгийн багцад ТУЗ-с баталсан хуулийн болон санхүүгийн шалгуур үзүүлэлтүүдийн дагуу сонгогдсон автомашины зээлийн хөрөнгүүд багтсан болно. Уг шалгуур үзүүлэлтүүдийг багцын хөрөнгөд хамаарах зээлүүд нь хангаж байгаа эсэхийг хөндлөнгийн санхүүгийн болон хуулийн шинжээч нар санамсаргүй түүврийн аргаар сонгон дүн шинжилгээ хийж, тайлан гаргасан бөгөөд Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс шалгуур хангасан 100 хувийн чанартай хөрөнгийг ТЗК руу шилжүүлнэ.

**Багцад багтсан хөрөнгүүд шалгуур хангасан эсэхэд хөндлөнгийн дүгнэлт гаргуулах**

Хөндлөнгийн хууль зүйн дүн шинжилгээг Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс ХХН, санхүүгийн дүн шинжилгээг Нийслэл-Аудит ХХК тус тус гүйцэтгэж тайлан гаргасан болно.

**Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс ТЗК руу хөрөнгө шилжүүлэх**

СЗХ
2022.10сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-07



Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эзэмшилд буй зээлийн багцыг ТЗК-тай гэрээ байгуулсны үндсэн дээр шилжүүлнэ. Хөрөнгө итгэмжлэн удирдагч Юнайтед Айр Файнэнс ХХК нь ТЗК-тай байгуулсан гэрээний үндсэн дээр хөрөнгө оруулагчид барьцаалуулсан тус хөрөнгийг түүний эрх ашигт нийцүүлэн эзэмшиж, удирдана. Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн гэрээ үнэт цаасны хугацааны эцэст дуусгавар болох бөгөөд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч ХБҮЦ-ыг буцаан худалдан авсан тохиолдолд хугацаанаас өмнө Гэрээг дуусгавар болгож болно.

**Үнэт цаасыг СЗХ, МХБ-д бүртгүүлэх**

Андеррайтер нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Компанийн тухай хууль, СЗХ-ны "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам", МХБ-ийн "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам"-ын дагуу үнэт цаасны танилцуулга, хүсэлтийг боловсруулж, үнэт цаасыг бүртгүүлнэ.

**Анхдагч зах зээлийн захиалгыг зохион байгуулах**

Зохицуулагч байгууллагуудаас зөвшөөрөл олгогдсоны дараа Андеррайтер нь үнэт цаасыг нийтэд танилцуулах, сурталчлах ажиллагааг зохион байгуулж, андеррайтер төвтэй анхдагч зах зээлийн захиалгыг хүлээн авч гүйцэтгэнэ.

**Хөрөнгө оруулагчид үнэт цаас худалдаж авах**

Үнэт цаасны захиалга нээгдэх хугацаанд үнэт цаас эзэмших хүсэлтэй хөрөнгө оруулагчид Үнэт цаасны төвлөрсөн хадгаламж дах үнэт цаасны дансанд мөнгийг байршуулж, захиалгыг хийж гүйцэтгэнэ. Захиалга биелснээр үнэт цаас хөрөнгө оруулагчийн эзэмшилд шилжиж, үнэт цаасны танилцуулгад заасан төлбөрийн хуваарийн дагуу хүүгийн болон үндсэн төлбөрийг хүлээж авна.

**Хөрөнгийг удирдах**

Хөрөнгө итгэмжлэн удирдагч Юнайтед Айр Файнэнс ХХК нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс хөрөнгөтэй холбоотой бүртгэх, тайлагнах болон хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд заасан хөрөнгөтэй холбоотой бусад үйлчилгээг үнэт цаасны хугацааны турш үзүүлнэ.

**ТЗК татан буугдах**

Хууль болон компанийн дүрэмд заасны дагуу баталгаат үнэт цаастай холбогдсон үүрэг дуусгавар болмогц ТЗК нь татан буугдана.

УЛААНБААТАР ХОТ
ЛЭНДМН АКТИВ ТЗК ХХК
9022080559



РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
RHINOS INVESTMENT UTsK
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2022 он 09 сар 21 өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-07



## 4.2 ҮНЭТ ЦААСНЫ ХҮҮ ТОГТООСОН ҮНДЭСЛЭЛ

### 4.2.1 Инфляци, Хадгаламжийн хүүгийн түвшинтэй харьцуулахад

2022 оны эхний хагас жилийн байдлаар хугацаатай хадгаламжийн хүү 9.7%, улсын жилийн инфляцын төвшин 15.1%-д хүрээд байна. Хөрөнгө оруулагчдын хувьд инфляцийн төвшнөөс өндөр өгөөжөөр хөрөнгөө удирдах нь илэрхий бөгөөд үнэт цаас гаргагчийн санал болгож буй хүү тогтоох үндсэн нэг үндэслэл нь инфляцийн төвшин билээ.

*График 27: Хад. хүү, инфляц, хүүний харьцуулалт*




*Эх сурвалж: Монгол банк*

### 4.2.2 Нээлттэй бондын өгөөжийн түвшинтэй харьцуулахад

2021-2022 оны хооронд олон нийтээс нээлттэй байдлаар бонд босгосон үнэт цаасны хүүгийн төвшинг харьцуулахад дунджаар 12.75%-ийн өгөөжтэй байгаа ба өнөөгийн нөхцөл байдал болон инфляцийн өсөн нэмэгдэж буй өнөө үед хөрөнгө оруулагч, олон нийтийн хөрөнгийн үнэ цэнийг хамгаалахын тулд харьцангуй өндөр өгөөжтэй бүтээгдэхүүн зах зээлд шаардлагатай байна.

*График 28: Нээлттэй бондуудын өгөөж*




*Эх сурвалж: МХБ*

### 4.2.3 ХБҮЦ-ны өгөөжийн түвшинтэй харьцуулахад

Сүүлийн нэг жилийн хугацаанд МХБ дээр гурван удаагийн ХБҮЦ олон нийтээс дунджаар 14.6%-ийн өгөөж амлан нийтдээ 59 тэрбум төгрөгийн хөрөнгийг босгоод байна.

*График 29: ХБҮЦ-ын өгөөжийн харьцуулалт*




*Эх сурвалж: МХБ*

УЛААНБААТАР ХОТ
ЛЭНДМН АКТИВ ТЗК ХХК
9022080559

РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ

## 4.3 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ӨГӨӨЖ

### Хугацааны дундаар хүү авах боломж /сар тутам/

Үнэт цаас гаргагч нь хүүгийн төлбөрөө сар тутам олгох ба хөрөнгө оруулагчийн хувьд дахин хөрөнгө оруулах байдлаар өгөөжөө нэмэгдүүлэх боломжтой юм.

### Хугацааны дундуур арилжих боломж

Хөрөнгө оруулагч нь анхдагч зах зээлээс үнэт цаасны арилжаанд оролцсоныхоо дараа өөрийн хэрэгцээтэй үедээ хоёрдогч зах зээл дээр үнэт цаасаа арилжих бүрэн боломжтой юм.

### Харьцангуй өндөр өгөөж

*График 30: Хөрөнгө оруулалтын өгөөж /нэгж %/*




*Эх сурвалж: МХБ*

Үнэт цаас гаргагч нь хөрөнгө оруулагчдад 17.0 хувь, татварын дараа 16.15%-ийн өгөөжийг санал болгож байгаа ба 2021-2022 оны хооронд гарсан бусад боломжит үнэт цаасны өгөөжтэй харьцуулахад хамгийн өндөр өгөөжтэй байна.

Өнгөрсөн хугацаанд инфляцийн төвшин эрчимжиж улсын хэмжээнд 15.1%-д хүрсэн нь хөрөнгө оруулагчид илүү өндөр өгөөж эрэлхийлэхэд хүргэж байна.

### Татварын хөнгөлөлт

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хувьд 5%-ийн хүүгийн орлогын албан татвар төлөх зохицуулалттай байгаа ба хөрөнгө оруулагч нь татварын хувьд өгөөжөө нэмэгдүүлэх боломжтой юм.

### Ханшийн зөрүүгээр ашиг хүртэх боломж

Нээлттэй ХБҮЦ-г эзэмшиж байх хугацаанд зах зээл дээр хадгаламжийн хүү буурах юм уу эсвэл бондын эргэн төлөлтийн хугацаа дөхөх тусам бондын үнэ өссөнөөр бонд эзэмшигч нарын хувьд арилжааны зөрөөний ашиг олох боломж бий болдог.

## 4.4 ҮНЭТ ЦААСНЫ ТӨЛБӨРИЙН ХУВААРЬ

Үнэт цаас гаргагчийн ТУЗ-өөс баталсан "Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх тухай журам"-д үнэт цаасны төлбөр цуглуулах болон төлбөрийн зарцуулалт, үнэт цаас эзэмшигчдэд ХБҮЦ-ны төлбөр төлөхтэй холбоотой харилцааг зохицуулсан байна.

### Үнэт цаасны төлбөр цуглуулах

ХБҮЦ-ны төлбөр цуглуулах ажиллагаанд үнэт цаас гаргагч болон үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагч нар оролцож "Төлбөр цуглуулах, үйлчилгээ үзүүлэх" гэрээний дагуух эрх үүргийг тус бүр хэрэгжүүлнэ.

### Төлбөрийн зарцуулалт

Үнэт цаас эзэмшигчдэд төлөгдөх төлбөрийг зориулалтын бусаар захиран зарцуулахаас сэргийлж, төлбөр цуглуулах данснаас зөвхөн журамд заасан дараах зарцуулалтыг хийнэ.

- Үнэт цаас эзэмшигчдэд төлөгдөх төлбөрийг ҮЦТХТ-ийн данс руу шилжүүлэх;
- Үнэт цаасны хүүгийн орлогын татвар;
- Хөрөнгийн багцад хөрөнгө нэмж худалдан авах, солих, нэмэгдүүлэх;
- Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд заасан нөхцөл, журмын дагуу зөвшөөрөгдсөн хөрөнгө оруулалтад байршуулах;
- ТЗК-ийн төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан төсвийн дагуу ТЗК-ийн үйл ажиллагаатай холбоотой ерөнхий ба удирдлагын зардал

### Үнэт цаас эзэмшигчдэд төлбөр төлөх

ТЗК нь Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвтэй ХБҮЦ хадгалуулах, ХБҮЦ-ны төлбөрийн үүргийг гүйцэтгэх зорилгоор гэрээ байгуулна.

Анхдагч зах зээлийн арилжаа явагдаж, хоёрдогч зах зээлийн арилжаа эхлэх өдрөөс эхлэн хүүг тооцож эхэлнэ. Хүүгийн төлбөрийг 365 хоногоор тооцож, **сар бүрийн 10-ны өдөр**, үндсэн төлбөрийг хугацааны эцэст бүтэн дүнгээр эргүүлэн төлнө.

ХБҮЦ-ны үндсэн болон хүүг дараах байдлаар тооцож төлнө. Үүнд:

СЗХ 2022.10.21 өдөр БҮРТГЭВ №01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2022-10-07 БҮРТГЭВ-02

*Хүснэгт 15: ХБҮЦ-ны хүүгийн тооцоолол*

| | |
|---|---|
| ХБҮЦ-ны нэрлэсэн үнэ | 100,000.00 ₮ |
| ХБҮЦ-ны хүүгийн төлбөр төлөх давтамж | Сар бүрийн 10-ны өдөр<br><br>(ТЗК нь ХБҮЦ гаргасан сарын хүүгийн төлбөр буюу эхний удаагийн хүүгийн төлбөрийг хуримтлуулан тооцож, ХБҮЦ-ны 2 дахь удаагийн хүүгийн төлбөртэй хамтад нь төлнө) |
| ХБҮЦ-ны хүүгийн жилийн хувь | 17% |
| ХБҮЦ-ны хүүгийн төлбөр /татварын өмнөх/ | Тоо ширхэг * Нэрлэсэн үнэ * 17% /365*хоног |
| ХБҮЦ-ны хүүгийн төлбөр /татварын дараах/ | Тоо ширхэг * Нэрлэсэн үнэ * 16.15% /365*хоног |
| ХБҮЦ-ны үндсэн төлбөр | Хугацааны эцэст бүтнээр |

## Үнэт цаас эзэмшигчдэд төлбөр төлөх дараалал

Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь ХБҮЦ-ны төлбөр хүлээн авах Үнэт цаас эзэмшигчдийн жагсаалтыг төлбөр төлөх өдрөөс ажлын 5 хоногийн өмнө ҮЦТХТ-өөс авна.

ХБҮЦ-ны төлбөрийг ҮЦТХТ-өөс ирсэн Үнэт цаас эзэмшигчдийн жагсаалтын дагуу ТЗК нь шилжүүлэх бөгөөд нэрсийн жагсаалт гарсанаас хойш Үнэт цаас эзэмшигч солигдсон бол төлбөр авах боломжгүй байна.

Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь журамд заасан хугацаагаар Үнэт цаас эзэмшигчийн жагсаалт, эзэмшиж буй ХБҮЦ-ны тоо, төлбөрийн хуваарийн тооцоолол хийж, Үнэт цаас эзэмшигч тус бүрээр төлөгдөх төлбөрийн тооцоог гарган, тооцоог Анхны үүрэг гүйцэтгүүлэгч, Үйлчилгээ үзүүлэгч болон ҮЦТХТ-д тус тус хүргүүлнэ.

Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь тооцоо гаргахдаа татварын өмнөх болон дараах байдлаар гаргах бөгөөд ТЗК нь татварыг хассан дүнгээр ҮЦТХТ рүү шилжүүлж, үнэт цаас эзэмшигчийн нэрээр холбогдох татварыг суутган тайлагнана.

ТЗК нь ХБҮЦ-ны төлбөрийг ҮЦТХТ дэх ТЗК-ийн үнэт цаасны дансанд журамд заасны дагуу тооцооллыг баталгаажуулснаас хойш 1 хоногийн дотор байршуулж, ҮЦТХТ-өөс тооцоололд заасны дагуу Үнэт цаас эзэмшигч нарт хуваарьт өдөр төлбөрийг шилжүүлнэ.

Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь ХБҮЦ-ны төлбөр төлөгдсөн өдрөөс 3 хоногийн дотор ТЗК-ийн "Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргэх журам"-д заасны дагуу ХБҮЦ-ны төлбөр төлсөн тухай мэдээллийг хүргэнэ.

Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь ХБҮЦ-ны төлбөр төлөгдсөн өдрөөс хойш 3 хоногийн дотор Үнэт цаас эзэмшигчдийн жагсаалт, эзэмшиж буй ХБҮЦ-ны тоо, Үнэт цаас эзэмшигчдэд төлөгдсөн төлбөр, татварын дүн зэрэг мэдээллийг ТЗК-ийн ТУЗ-д танилцуулна.

УЛААНБААТАР ХОТ ЛЭНДМН АКТИВ ТЗК ХХК 9022080559

РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК RHINOS INVESTMENT UTsK LLC

## 4.5 ХӨРӨНГИЙН БАГЦЫН ТУХАЙ

### 4.5.1 Зээлийн багцын хөрөнгөд тавигдах хууль эрх зүйн шалгуур

Хэлцлийн хүрээнд худалдан авах хөрөнгийн багцыг Үнэт цаас гаргагчаас боловсруулсан дор дурдсан шалгуур үзүүлэлтийг хангасан зээлийн дансдаас бүрдүүлсэн. Хууль эрх зүйн шалгуур үзүүлэлтийг харуулбал:

**Автомашины зээлийн шалгуур:**

- Зээлийн гэрээ нь зээлдэгч (Үүрэг гүйцэтгэгч)-ийн хувьд хуульд нийцсэн, хүчин төгөлдөр, заавал биелэгдэх үүрэг үүсгэх бөгөөд шаардлагатай тохиолдолд уг зээлийг фидуцийн хөрөнгөөс гаргуулан төлүүлэх боломжтой байх;
- Зээлтэй холбоотойгоор анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон зээлдэгчийн хооронд байгуулсан фидуцийн гэрээ нь зээлдэгч (Үүрэг гүйцэтгэгч)-ийн хувьд хуульд нийцсэн, хүчин төгөлдөр, заавал биелэгдэх үүрэг үүсгэсэн зээлдэгч үүргээ биелүүлээгүй тохиолдолд анхны үүрэг гүйцэтгүүлэгч өмчлөгчийн эрхээ хэрэгжүүлж, худалдан борлуулж зээл, үүнтэй холбоотой бүх төлбөрийг гаргуулах боломжтой байх;
- Зээл нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн хувьд хууль, гэрээ эсхүл бусад байдлаар аливаа үүргээс ангид, фидуцийн гэрээний зүйлийн хамтаар гуравдагч этгээдэд шилжихэд хориглогдоогүй эсхүл хязгаарлагдаагүй байх;
- Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид байгаа мэдээллээр, тасалбар болгох өдрийн байдлаар зээлийн гэрээ нь Үүрэг гүйцэтгэгчийн хувьд үүргээ хугацаанаас өмнө дуусгавар болгох/урьдчилан төлөх нөхцөл, хэлцлээс татгалзах, харилцан суутгал хийх замаар үүргийг дуусгавар болгох, сөрөг нэхэмжлэл гаргах, эсхүл үүргээс татгалзах (илт хохиролтой хэлцлийн улмаас үүргээс татгалзах нөхцөлийг хамааруулан) эрх үүсээгүй, эсхүл эрхээ хэрэгжүүлэх хүсэл зориг илэрхийлээгүй байх;
- Фидуцийн гэрээ хүчин төгөлдөр болгоход Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн ердийн практикт мөрддөг бүх дүрэм журмыг дагаж мөрдсөн, тухайн үүргийн гүйцэтгэлийг хангуулах аргыг нотолж буй автомашины гэрчилгээ Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн нэр дээр байх, бүх баримт бичиг нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эзэмшил, хадгалалт хамгаалалтад байх.

### 4.5.2 Зээлийн хөрөнгөд тавигдах санхүүгийн шалгуур

Хэлцлийн хүрээнд худалдан авах хөрөнгийн багцыг Үнэт цаас гаргагчаас боловсруулсан дор дурдсан шалгуур үзүүлэлтийг хангасан зээлийн дансдаас бүрдүүлсэн. Санхүүгийн шалгуур үзүүлэлтийг харуулбал:

СЗХ
2022 .09 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№: 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-07
БҮРТГЭВ-02



**Автомашины зээлийн шалгуур:**

1. Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэх хөрөнгийн мэдээлэл нь зээлийн хувийн хэрэг дэх үндсэн баримттай нийцэж байх;
2. Зээл нь Монгол төгрөгөөр олгогдсон бөгөөд Монгол төгрөгөөр эргэн төлөгдөх зээл байх;
3. Зээлийн эргэн төлөлтийн хуваарьт зээлдэгчийн сар бүрийн төлөх дүнг (төлж дуусгах хугацаа) тусгасан байх, зээлийн хугацааны эцэст бүрэн төлөгдөж дуусахаар байх;
4. Фидуцийн гэрээний зүйл нь даатгалд даатгагдсан байх, даатгал нь хүчин төгөлдөр байх (тээврийн хэрэгслийн хувьд жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд даатгагдсан байх, хүчин төгөлдөр байх);
5. Тасалбар болгосон өдрийн байдлаар зээл нь хэвийн төлөлттэй байх;
6. Эрх зүйн бүрэн чадамжтай, 18 нас хүрсэн Монгол улсын иргэн байх;
7. Зээлдэгчийн тэтгэврийн нас буюу 50 нас хүртэл;

### 4.5.3 Хөрөнгийн багцын тойм

ЛэндМН Актив ТЗК ХХК-ийн санал болгож буй ХБҮЦ-ны хөрөнгөд шалгуур хангасан 306 зээлдэгчийн 5,335,006,689 төгрөгийн үлдэгдэл бүхий 306 зээлийн гэрээг багцалсан болно.

*Хүснэгт 16: Багцын үндсэн үзүүлэлтүүд*

| **Багцын үндсэн үзүүлэлтүүд** | |
|---|---|
| Нийт зээлийн үлдэгдэл /төгрөг/ | 5,335,006,689 |
| Авто машины зээл | 5,335,006,689 |
| Нийт анх олгосон зээлийн дүн /төгрөг/ | 5,736,037,500 |
| Барьцааны дүн /төгрөг/ | 7,029,050,000 |
| Зээлийн гэрээний тоо | 306 |
| Зээлийн дундаж үлдэгдэл /төгрөг/ | 17,434,662 |
| **Зээлийн төвлөрөл** | |
| Хамгийн том 1 зээлдэгчийн нийт багцад эзлэх % | 0.6% |
| Хамгийн том 10 зээлдэгчийн нийт багцад эзлэх % | 5.2% |
| Хамгийн том 50 зээлдэгчийн нийт багцад эзлэх % | 23.4% |
| **Жигнэсэн дундаж үзүүлэлт** | |
| Жигнэсэн дундаж хүү /сараар/ | 2.5% |
| LTV | 76.1% |
| Багцын зээлийн чанар | Хэвийн зээлийн багц |

УЛААНБААТАР ХОТ
ЛЭНДМН АКТИВ ТЗК ХХК
9022080559
ХТҮ4977 ⊕ С888895



РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
RHINOS INVESTMENT UTsK LLC

СЗХ
2022.09.21 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-07



**Зээлийн багцын төвлөрөл**

Зээлийн багцын төвлөрлийг зээлийн дүнгээр ангилахад хамгийн их дүнтэй зээл 0.6%, хамгийн их дүнтэй 10 зээл 5.2%, хамгийн их дүнтэй 50 зээл 23.4%-ийг тус тус эзэлж байгаа нь зээлийн төвлөрөл бага болохыг харуулж байна. Тус зээлийн багцад нийт 306 зээл багтаж байгаагаас 0-10.0 сая төгрөг хүртэлх үнийн дүн бүхий зээл 0.2%, 10.0-20.0 сая төгрөг хүртэлх үнийн дүн бүхий зээл 57.5%, 20.0-30.0 сая төгрөгийн үнийн дүн бүхий зээл 41.7%, 30.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зээл 0.6%-ийг эзэлж байгаа ба тухайн багц нь олон зээлдэгчдийн бага дүнтэй зээлээс бүрдэж байгаагаараа онцлог юм.

*Хүснэгт 17: Зээлийн багцын төвлөрөл*

| Олгосон дүн | Зээлийн тоо | | Зээлийн дүн /сая.төг/ | |
|---|---|---|---|---|
| | Тоо | % | Дүн | % |
| **0-10.0 сая** | 1 | 0.3% | 9.9 | 0.2% |
| **10.0-20.0 сая** | 207 | 67.6% | 3,065.8 | 57.5% |
| **20.0-30.0 сая** | 97 | 31.7% | 2,226.5 | 41.7% |
| **30.0-с дээш** | 1 | 0.3% | 32.8 | 0.6% |

## Зээлийн багцын хугацаа

ЛэндМН Актив ТЗК ХХК-ийн хөрөнгийн багцын үнийн дүнг 48 сар хүртэлх хугацаатай автомашины зээл эзэлж байна. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хугацаа 24 сарын хугацаатай ба хөрөнгийн багцын 100%-ийг эзэлж буй автомашины зээл нь 48 хүртэлх сарын хугацаатай тул эрсдэл багатай зээлийн бүтээгдэхүүн гэдгээрээ онцлог юм.

*Хүснэгт 18: Зээлийн багцын хугацаа*

| Зээлийн анхны хугацаа /хоногоор/ | Зээлийн тоо | | Анх олгосон дүн /сая.төг/ | |
|---|---|---|---|---|
| | Тоо | % | Дүн | % |
| **24-36 сар** | 7 | 1.8% | 354.2 | 6.6% |
| **36 сар -48 сар** | 299 | 98.2% | 4,980.8 | 93.4% |

Зээлийн багцын үнийн дүнгийн 71.6% нь 2022 оны нэгээс гуравдугаар улиралд олгогдсон зээл, үлдсэн 28.4%-ийг 2021 оны гурав болон дөрөвдүгээр улиралд олгосон зээл эзэлж байна.

*Хүснэгт 19: Зээлийн багц, улирлаар(Анх олгогдсон огноогоор)*

| Анх олгосон огноо | Зээлийн тоо | | Зээлийн дүн /сая.төг/ | |
|---|---|---|---|---|
| | Тоо | % | Дүн | % |
| **2021 III- IV улирал** | 87 | 28.4% | 1,279.5 | 24.0% |
| **2022 I- II улирал** | 120 | 39.2% | 2,042.9 | 38.3% |
| **2022 III улирал** | 99 | 32.4% | 2,012.6 | 37.7% |

УЛААНБААТАР ХОТ
ЛЭНДМН АКТИВ ТЗК ХХК
9022080569
ХТҮ4977 6888895



РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
RHINOS INVESTMENT UTsK LLC

СЗХ
2022 .09.21 өдөр
БҮРТГЭВ
№ 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-07
БҮРТГЭВ-02



## Зээлийн багц, хүүгийн түвшингээр

ЛэндМН Актив ТЗК ХХК-ийн зээлийн багцын үнийн дүнд 24.4 хувь нь сарын 2.5% хүртэлх, 75.6 хувь нь сарын 2.5%-3.0% хүүтэй зээл ээлж байгаа ба жигнэсэн дундаж хүү сарын 2.5%-тай байна.

*Хүснэгт 20: Зээлийн багц, хүүгийн түвшингээр*

| Хүүгийн түвшин | Зээлийн тоо | | Зээлийн дүн /сая.төг/ | |
|---|---|---|---|---|
| | Тоо | % | Дүн | % |
| **2.5% хүртэл** | 78 | 25.5% | 1,304.0 | 24.4% |
| **2.5%-3.0%** | 228 | 74.5% | 4,031.0 | 75.6% |

## Зээлийн багц, төрлөөр

Зээлийн багцыг 306 ширхэг барьцаатай автомашины зээл 100% бүрдүүлж байгаа ба дээрх зээл нь зээлийн шалгуурын дагуу бүгд хэвийн зээлийн ангилалд буй зээл юм.

### 4.5.4 Багцын дүгнэлт

**Зээлийн чанар**

ЛэндМН Актив ТЗК ХХК-ийн ТУЗ-аас баталсан зээлийн шалгуур үзүүлэлтийн дагуу зөвхөн "Хэвийн" зээл нь тухайн багцыг бүрдүүлж байгаа ба зээлийн чанарын холбогдох зохицуулалтыг "Хөрөнгийн багцад өөрчлөлт оруулах" журамд тусгасан нь багцын зээл хугацаа хэтрэх үндсэн эрсдэлээс хамгаалагдсан байна.

**Бусад**

Зээлийн багцын 100%-г 306 зээлдэгчийн, хэвийн ангилалтай нийт 306 ширхэг автомашины зээл бүрдүүлж байна. Эдгээр зээлийн хугацаа нь 24 – 48 сар бөгөөд хөрөнгө итгэмжлэн удирдагч нь ХБҮЦ-н хугацааны дундуурх автомашины зээлийн эргэн төлөлтөөр хөрөнгийн багцад хөрөнгө нэмж худалдан авах, солих замаар, эсвэл хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд заасан нөхцөл, журмын дагуу зөвшөөрөгдсөн хөрөнгө оруулалтанд байршуулах замаар үнэт цаасны эргэн төлөлтийг хуваарийн дагуу гүйцэтгэж, хөрөнгө оруулагчдын эрсдэлийг хамгийн бага түвшинд байлгаж ажиллана.

УЛААНБААТАР ХОТ
ЛЭНДМН АКТИВ ТЗК ХХК
9022080559
ХТҮ4977 ☏ 6888895

РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
RHINOS INVESTMENT UTsK
УЛААНБААТАР ХОТ



УЛААНБААТАР ХОТ
ХХК

## 4.6 ХӨРӨНГИЙН БАГЦАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Хөрөнгийн багцад өөрчлөлт оруулах ажиллагааг Үнэт цаас гаргагчийн ТУЗ-өөс баталсан "Хөрөнгийн багцад өөрчлөлт оруулах журам"-д дараах байдлаар зохицуулахаар заасан байна. **Үүнд:**

Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний дагуу багцыг шилжүүлэн авсан зээлийн хөрөнгө нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 9 дүгээр зүйл болон зээлийн багцад тавигдах шалгуур үзүүлэлтийг хангахгүй болсон эсхүл Журамд заасан үндэслэл бий болсон тохиолдолд хөрөнгийн багцад өөрчлөлт оруулна.

Хөрөнгийн багцад өөрчлөлт оруулах нөхцөл

- Багцын хөрөнгийг солих
- Багцын хөрөнгийг нэмэгдүүлэх
- Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдах

### Багцын хөрөнгийг солих

Хөрөнгийн багцыг шилжүүлэхээс өмнө дор дурдсан үндэслэл бий болсон нь илэрсэн тохиолдолд шаардлага хангахгүй хөрөнгөд тооцож, хөрөнгийн багцад байгаа хөрөнгийг багцаас хасаж солино.

- Зээлдэгчийн хүсэлтээр тухайн зээлийн гэрээнд өөрчлөлт оруулсан нь Үнэт цаас эзэмшигчдэд төлөх ХБҮЦ-ны төлбөрийн нөхцөлд нөлөөлөхүйц байна гэж Компаниас үзсэн
- Хөрөнгийн багцын шалгуур үзүүлэлттэй холбоотойгоор анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн "Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ"-нд заасан аль нэг шалгуур хангахгүй болох, эсхүл мэдэгдэл, баталгаа зөрчигдсөн
- Зээлийн эргэн төлөлтийн хугацаа "Хөрөнгө худалдах худалдан авах гэрээ"-нд зааснаас хэтэрсэн
- Зээл хугацаанаас өмнө эргэн төлөгдсөн

### Багцын хөрөнгийг нэмэгдүүлэх

Дараах үндэслэл бий болсон тохиолдолд хөрөнгийн багцад хөрөнгийг нэмэгдүүлнэ.

- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 15.3.1-д заасны дагуу ХБҮЦ-ны хөрөнгийн багцаас орох орлого нь ХБҮЦ-ны төлбөрийн үүргийг гүйцэтгэж хүрэхгүй болсон
- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 15.3.2-д заасны

СЗХ
2022 он 09 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-07
БҮРТГЭВ-02

дагуу Компани нь нээлттэй гаргах нөхцөлийн дагуу нэмэлт үнэт цаас гаргахаар болсон

- Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь багцын өгөөжийг нэмэгдүүлэх, төлбөрийн тасалдал үүсэхээс урьдчилсан сэргийлэх зорилгоор Үнэт цаас эзэмшигчдэд төлөх ХБҮЦ-ны төлбөрөөс бусад сул мөнгөн дүнгээр багц худалдан авах боломжтой гэж үзсэн, зээлийн багц худалдан авах талаар анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй харилцан тохиролцсон

Хөрөнгийн багцыг нэмэгдүүлэхэд багцад ийнхүү нэмэгдсэн хөрөнгө нь ХБҮЦ гаргах өргөдөл, Үнэт цаасны танилцуулгад тусгагдсантай адил онцлог, шинж чанартай байна.

**Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдах**

Дараах үндэслэл бий болсон тохиолдолд Компани нь хөрөнгийн багцыг анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдахаар заасан байна.

- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.11.5-д заасан нөхцөл байдал үүссэн бөгөөд талууд харилцан тохиролцсон тохиолдолд;
- “Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ”-нд заасан нөхцөл бий болсон.

## 4.7 ХӨРӨНГИЙН БАГЦЫН ҮНЭЛГЭЭ

Хөрөнгийн багц нь 100 хувь “хэвийн” зээлээс бүрдэх бөгөөд зээлийн багцын 100 хувийг 48 сар хүртэлх хугацаатай, барьцаатай, автомашины зээл эзэлж байна. ТЗК нь Хорооноос баталсан “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулах, зарцуулах журам”-ын дагуу эрсдэлийн сан байгуулж зээлтэй холбоотой эрсдэлийг бууруулах юм. Энэхүү эрсдэлийн сангийн эх үүсвэрээр чанаргүй болсон, төлбөрийн чадваргүй болсон зээлийн хөрөнгийн төлбөрийг Хөрөнгө оруулагчдад хуваарилан ажиллах тул барьцаа хөрөнгийг дахин үнэлэх шаардлагагүй байна.

## 4.8 ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Үнэт цаас гаргагчийн ТУЗ-өөс 2022 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн 22/11 тоот тогтоолоор баталсан “Эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын журам”-ыг баталж, хөрөнгийн багцын эргэн төлөлт хугацаандаа төлөгдөхгүй байх, зээлийн багцын эрсдэл, үнэт цаас эзэмшигчдэд төлбөр төлөхтэй холбогдуулан байнгын дотоод хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх, эрсдэлийг бууруулах, удирдах харилцааг зохицуулсан байна.

УЛААНБААТАР ХОТ
ЛЭНДМН АКТИВ ТЗК ХХК



РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
RHINOS INVESTMENT UTsK LLC

Энэхүү журамд Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны төлбөр төлөхтэй холбоотой учирч болох эрсдэлийг дараах байдлаар ангилсан байна.

1. Зээлтэй холбоотой эрсдэл
2. ХБҮЦ гаргах үйл ажиллагаанд оролцогч талуудтай холбоотой эрсдэл
   - Анхны үүрэг гүйцэтгүүлэгч
   - Үйлчилгээ үзүүлэгч
   - Хөрөнгө итгэмжлэн удирдагч

Гадаад хүчин зүйлстэй холбоотой эрсдэлийг дараах байдлаар ангилсан байна

3. Хууль тогтоомж, журам, зохицуулалт
4. Давагдашгүй хүчин зүйлс

## ЗЭЭЛТЭЙ ХОЛБООТОЙ ЭРСДЭЛ

- Зээлийн эрсдэл гэдэг нь зээлдэгч зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй улмаас үүсэх эрсдэлийг хэлнэ. Үүнд зээлдэгч зээлийн хугацаа хэтрүүлэх, төлбөрийн чадваргүй болох, Зээлдэгч эрх зүйн чадамжгүй болох, нас барах, сураггүй алга болсон нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон байхыг ойлгоно.
- Хугацаанаас өмнө эргэн төлөгдөх эрсдэл гэдэг нь зээлдэгч зээлээ хугацаанаас нь өмнө төлөх буюу хүлээгдэж байсан хүүгийн орлого буурах, хаагдахыг ойлгоно.

Зээлтэй холбоотой эрсдэлийг дараах байдлаар удирдана. Үүнд:

- ТЗК нь хөрөнгийн багцад буй тухайн хөрөнгийг солих, буцаан худалдаж авахыг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс шаардах замаар эрсдэлийг бууруулах буюу арилгана.
- Үйлчилгээ үзүүлэгчтэй байгуулсан гэрээний дагуу зээлдэгчийн фидуцийн хөрөнгө, эсхүл бусад хөрөнгөөр шаардлага хангуулж зээлийн эрсдэлийг бууруулна.
- ТЗК нь зээлтэй холбоотой эрсдэлийг Хорооноос баталсан Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулах, зарцуулах журмыг мөрдөж, зээлийг ангилж, эрсдэлийн сан байгуулж ажиллана.
- ТЗК нь хагас жил тутамд зээлийн эрсдэлийн санг СТОУС-ийн дагуу тооцож, холбогдох эрсдэлийн сангийн тохируулгыг хийнэ.
- ТЗК нь хугацаа хэтэрсэн зээл дээр үйлчилгээ үзүүлэгч талаас зээлийг эргэн төлүүлэхтэй холбоотой үйлчилгээ үзүүлэгчийн дотооддоо мөрдөж буй холбогдох заавар журмын хүрээнд үйлчилгээг авч, хяналт тавьж ажиллана. Үүнтэй холбоотой зохицуулалтыг Үйлчилгээ үзүүлэгчтэй байгуулах гэрээнд тусгана.

- ТЗК нь зээл хугацаанаас өмнө эргэн төлөгдөх эрсдэл үүссэн тохиолдолд Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэг болон ТЗК-ийн Хөрөнгийн багцад өөрчлөлт оруулах тухай журам, холбогдох гэрээнд заасны дагуу хөрөнгийн багцад хөрөнгө нэмэх замаар арга хэмжээ авна.

## ОРОЛЦОГЧ ТАЛУУДТАЙ ХОЛБООТОЙ ЭРСДЭЛ

1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй холбоотой эрсдэл.
    - ТЗК-ийн Хөрөнгийн багцад өөрчлөлт оруулах журмын 2 дугаар зүйлийн 2.3 дахь хэсэгт заасан зээл шилжүүлсэн;
    - Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь хөрөнгийн багцыг сольж нэмж чадахгүй болсон;
    - Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь төлбөрийн чадваргүй болсон, дампуурсан, татан буугдсан.
2. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй холбоотой эрсдэлийг дараах байдлаар удирдана. Үүнд:
    - Хөрөнгийн багцыг шилжүүлэхээс өмнө энэхүү Журмын 3.3.1.1 дэх хэсэгт заасан эрсдэл үүсэх тохиолдолд Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс хөрөнгийн багцыг солихыг шаардах, ТЗК-ийн Хөрөнгийн багцад өөрчлөлт оруулах журамд заасны дагуу эрсдэлийг удирдана.
    - Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь сайн дурын үндсэн дээр, эсхүл хуульд заасан үндэслэлээр татан буугдах тохиолдолд түүний ТЗК-д шилжүүлсэн Багцын хөрөнгийн үлдэгдлийг зохих журмын дагуу сонгогдсон өөр Үйлчилгээ үзүүлэгчид шилжүүлэх арга хэмжээ авна.
    - ТЗК нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй холбоотой эрсдэлийг бууруулах зорилгоор холбогдох журам, гэрээнд тус бүр эрсдэл бууруулах, мэдээллийг цаг тухай бүр хүргэх, хянах, мэдээлэл солилцох зохицуулалтуудыг тусгасан байна.
3. Үйлчилгээ үзүүлэгчтэй холбоотой эрсдэл.
    - Үйлчилгээ үзүүлэгч нь төлбөрийг бүрэн гүйцэд, гэрээгээр хүлээсэн хугацааны дагуу цуглуулан ТЗК-д шилжүүлэхгүй байх;
    - Үйлчилгээ үзүүлэгчийн тусгай зөвшөөрлийг хорооноос цуцлах;
    - Үйлчилгээ үзүүлэгч нь төлбөрийн чадваргүй, татан буугдсан, дампуурсан.
4. Үйлчилгээ үзүүлэгчтэй холбоотой эрсдэлийг дараах байдлаар удирдана. Үүнд:
    - Үйлчилгээ үзүүлэгч нь зээлийн эргэн төлөлтийг өөрийн харилцах дансанд цуглуулах ба ТЗК-ийн хөрөнгийн багцад буй

зээлүүдийн үндсэн болон хүүгийн төлөлтийг цуглуулан өөрийн бусад хөрөнгөөс ангид байлгана.

- Үйлчилгээ үзүүлэгч нь төлбөр цуглуулах үйл ажиллагааг цаг хугацааны дагуу, бүрэн гүйцэд цуглуулах үүргээ санаатай буюу болгоомжгүй үйлдлийн улмаас зөрчсөний улмаас бусдад хохирол учруулсан бол Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.9 дэх хэсэгт заасны дагуу хохирлыг арилгана. Үйлчилгээ үзүүлэгч нь учруулсан хохиролтой тэнцэх хэмжээний мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгийг өөрийн хөрөнгөөр төлж барагдуулна.
- Үйлчилгээ үзүүлэгч нь зээлийг төлүүлэхдээ ТЗК-тай байгуулсан гэрээний дагуу үйлчилгээ үзүүлэгч байгууллагын дотооддоо мөрдөгдөж буй Зээлийн үйл ажиллагааны журам, Зээл төлүүлэхтэй холбогдсон бусад журмыг дагаж мөрдөнө.
- Үйлчилгээ үзүүлэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа биелүүлэхгүй , эсхүл Үйлчилгээ үзүүлэгч нь төлбөрийн чадваргүй болсон, татан буугдах, дампуурах эрсдэл үүссэн, төрийн зохицуулах байгууллагаас тусгай зөвшөөрлийг цуцалсан тохиолдолд ТЗК нь тусгаарласан зээлийн багцтай холбоотой авлага цуглуулах, төлбөр гүйцэтгэх үйл ажиллагааг зохих журмын дагуу сонгогдсон, өөр хэвийн үйл ажиллагаатай үйлчилгээ үзүүлэгчид шилжүүл эх, үйлчилгээ үзүүлэгчийг солих арга хэмжээ авна.
- ТЗК нь үйлчилгээ үзүүлэгчтэй холбоотой эрсдэлийг бууруулах, үүссэн эрсдэлийг шийдвэрлэх зорилгоор холбогдох журам, гэрээнд эрсдэл бууруулах, мэдээллийг цаг тухай бүр хүргэх, хянах, мэдээлэл солилцох зохицуулалтуудыг тусгасан байна.

5. Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай холбоотой эрсдэл.
    - Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь хөрөнгийг гэрээнд зааснаас гадуур, Үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагчид хохиролтойгоор зүй бусаар удирдах, ашиглах;
    - Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн тусгай зөвшөөрлийг Хорооноос цуцалсан;
    - Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь татан буугдсан, дампуурсан.
6. Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай холбоотой эрсдэлийг дараах байдлаар удирдана. Үүнд:
    - Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь багцын удирдлагатай холбоотой тайлан мэдээллийг Үнэт цаас гаргагчтай байгуулсан гэрээний дагуу Үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагч, холбогдох эрх бүхий байгууллагад тогтмол хүргэх бөгөөд хууль болон

гэрээнд зааснаас гадуур, зүй бусаар удирдаж, ашиглах тохиолдолд ТЗК-ийн ТУЗ нь хөрөнгө итгэмжлэн удирдагчийг нэн даруй солих шийдвэр гаргах, эсхүл үйл ажиллагааг залруулах, хохирлыг барагдуулах тодорхой хугацаа өгөх эрхтэй. Мөн зүй бус хөрөнгийн удирдлагатай холбоотой аливаа хохирол учирсан тохиолдолд Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь өөрийн хөрөнгөөр бүрэн төлж барагдуулах талаар гэрээнд тодорхой тусгаж баталгаажуулсан байна.

- Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн тусгай зөвшөөрлийг төрийн зохицуулах байгууллагаас цуцлах, хөрөнгө итгэмжлэн удирдагч нь төлбөрийн чадваргүй болох, татан буугдах, дампуурах нөхцөл үүссэн тохиолдолд шаардлага хангах хөрөнгө итгэмжлэн удирдагчийг яаралтай шинээр сонгон ажиллуулна.
- ТЗК нь Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай холбоотой эрсдэлийг бууруулах, үүссэн эрсдэлийг шийдвэрлэх зорилгоор холбогдох журам, гэрээнд эрсдэл бууруулах, мэдээллийг цаг тухай бүр хүргэх, хянах, мэдээлэл солилцох зохицуулалтуудыг тусгасан байна.

## ГАДААД ХҮЧИН ЗҮЙЛСТЭЙ ХОЛБООТОЙ ЭРСДЭЛ

1. Энэ журмын 3.4 дүгээр зүйлийн 3.4.1-д заасан эрсдэлтэй холбогдуулан ТЗК-ийн ТУЗ- ийн хурал хуралдаж, шаардлагатай гэж үзсэн тохиолдолд эрсдэлийн үнэлгээ, үр нөлөөтэй холбоотой хөндлөнгийн байгууллага, хуулийн фирмийг хөлслөн ажиллуулах, зохицуулагч эрх бүхий байгууллагуудтай тогтмол мэдээлэл солилцох, шийдвэр гаргах замаар эрсдэлийг бууруулж ажиллана.
2. Давагдашгүй хүчин зүйлстэй холбоотой эрсдэлд дараах арга хэмжээг авч ажиллана. Үүнд:
   - Давагдашгүй хүчин зүйл бий болсон тухайгаа Үнэт цаас эзэмшигчдэд тухайн брокерын компаниар дамжуулан бичгээр мэдэгдэх, ТЗК болон Биржийн цахим хуудсаар мэдээлнэ. Тухайн мэдэгдэлд учирсан давагдашгүй хүчин зүйлийг, түүний хор уршгийг бууруулах талаар авсан, эсхүл авах гэж буй арга хэмжээг, давагдашгүй хүчин зүйлийн улмаас үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон хугацааг тус тус тусгасан байна.

Давагдашгүй хүчин зүйлийн улмаас ТЗК нь Үнэт цаас эзэмшигчдийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж чадаагүй нь хариуцлагаас бүрэн болон хэсэгчлэн чөлөөлөх ч үндсэн үүргээс чөлөөлөхгүй. Давагдашгүй хүчин зүйлийн үед ТЗК-ийн үүрэг биелүүлэх хугацаа нь давагдашгүй хүчин зүйлийн үргэлжлэх хугацаагаар хойшлогдоно.

СЭХ
2022.08сар21 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-07



## 4.9 АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧЭЭС ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болох ЛэндМН ББСБ ХК нь хиймэл оюун ухаанд суурилан харилцагчдын зээлжих зэрэглэлийг LendMN аппликейшнээр дамжуулан тогтоодог ба барьцаагүй, түргэн шуурхай бичил цахим зээлийг санхүүгийн салбарт анх нэвтрүүлсэн билээ. Энэхүү зээлийн бүтээгдэхүүний онцлог нь дэвшилтэт технологи, хиймэл оюун ухаанд суурилсан зээлжих зэрэглэл тогтоох аргачлалаар буюу зээлжих зэрэглэлийг харилцагчийн орлого, ажил эрхлэлт, өр орлогын харьцаа зэргийг харгалзан тогтоож, харилцагч тогтоосон зээлийн эрхийн хэмжээнд шаардлагатай үедээ, хүссэн давтамж болон хэмжээгээр зээл авах боломжтой бүтээгдэхүүн юм.

Мөн 2021 онд зээлийн үйл ажиллагаагаа тэлж харилцагчдынхаа хүсэл сонирхолд нийцүүлэн зээлийн хугацаа болон зээлийн дүнг нэмэгдүүлж, барьцаатай, дунд хугацааны зээлийг нэвтрүүлсэн билээ. Харилцагч зээлийн мастер гэрээ байгуулснаар харилцагчийн мэдээлэл ЛэндМН ББСБ ХК-ийн эцсийн толгой компани болох АНД Глобал Пти.Лтд компанийн 100%-н хөрөнгө оруулалттай АНД Системс Тех ХХК-ийн тусгайлан хөгжүүлсэн зээлийн програмд хадгалагдаж, тухайн харилцагчийн авч буй зээл болгонд тусгайлан дугаар үүсч эргэн төлөлт, зээлийн хяналт зэргийг хийж ажилладаг юм.

ЛэндМН ББСБ ХК нь 2016 оноос хойш зээлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа ба энэ хугацаанд өөрсдийн харилцагчдыг зээлээ хугацаанд нь эргэн төлөх, санхүүгээ зөв удирдахад өөрсдийн аппликейшн, мессеж сануулга, авлагын албаны ажилтнууд сануулах зэргээр зээлдэгчдийг зээлээ хугацаанд төлөх хэвшил суулгаснаар зээл хугацаа хэтрэх эрсдэлийг бууруулж ирээдүйн үнэнч хэрэглэгчийг бэлтгэн ажиллаж ирсэн билээ.

Зээлдэгч төлбөрийн чадваргүй болох, төлбөрийн үүргээ биелүүлэхгүй болсон тохиолдолд үйлчилгээ үзүүлэгчийн зүгээс зээлийн эрсдэлийн санг СТОУС-ын дагуу байгуулах, эрсдэлийн олон талт удирдлагын үйл ажиллагааг хэрэгжүүлж үнэт цаас эзэмшигчийг эрсдэлээс хамгаалах болно.

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Үйлчилгээ үзүүлэгчийн хувьд ТЗК болон Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай байгуулсан Үйлчилгээ үзүүлэх гэрээний дагуу зээлийн багцын 100%-ийг бүрдүүлж буй автомашины зээл эргэн төлөгдөх бүрт зээлийн эргэн төлөлтийг цуглуулж, ижил хэмжээтэй зээлийн багцыг шалгуур үзүүлэлтийн дагуу ТЗК-д худалдах замаар хөрөнгийн багцыг бүрдүүлж ажиллана. Ингэснээр ТЗК дээр үүсэх эрсдэл болох зээл эргэн төлөгдөхгүй байх, зээлийн чанар буурах зэрэг эрсдэлийг хааж үнэт цаас эзэмшигчдийн эрх ашгийн хамгаалах чухал ач холбогдолтой юм.

УЛААНБААТАР ХОТ
ЛЭНДМН АКТИВ ТЗК ХХК
9022080559
ХТҮ4977 6888395

РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
RHINOS INVESTMENT UTsK LLC



УЛААНБААТАР ХОТ

СЭХ
2022 .10 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-07



ТЗК-ийн хөрөнгийн багцын 100%-ийг бүрдүүлж буй автомашины зээл нь 24-48 сар хүртэлх хугацаатай, 30 сая төгрөг хүртэлх зээлийг тухайн автомашиныг барьцаалан олгож байгаа ба тухайн зээлийн эргэн төлөлтийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь цуглуулан ТЗК руу шилжүүлнэ.

Хөрөнгийн багцын жигнэсэн дундаж хүү нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хүүгийн хэмжээнээс 79.6 хувиар илүү байгаа нь зээлийн хүүгийн орлого нь үнэт цаасны хүүний төлбөрийг эргэн төлөхөд хүрэлцээтэй байна. Хөрөнгө итгэмжлэн удирдах компани нь үнэт цаасны төлбөр болон зөвшөөрөгдсөн хөрөнгө оруулалтын дагуу ТЗК-ийн хөрөнгийг үр ашигтай, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалан удирдан ажиллана.

## 4.10 ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН УДИРДАГЧИЙН ТУХАЙ

"Юнайтед Айр Файнэнс" ХХК нь Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн хувиар банк, банк бус санхүүгийн байгууллага, ОССК болон Санхүүгийн зохицуулах хорооноос зөвшөөрсөн бусад байгууллагын ТЗК-ийн санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэлийг хөтлөх, үнэт цаасны баталгаа болж буй хөрөнгийн эргэн төлөлтийг цуглуулж үнэт цаасны хэлцэлтэй холбоотой төлбөрийг гүйцэтгэх, мөнгөн хөрөнгийг зөвшөөрөгдсөн хөрөнгө оруулалтад байршуулах, хөрөнгө оруулагч болон зохицуулагч байгууллагад тайлан мэдээ гаргах, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах ажлыг хийж гүйцэтгэнэ.

**Компанийн товч танилцуулга**

- 2005 оны 1 дүгээр сард Юнайтед Айр Карго ХХК нэртэйгээр анх үүсгэн байгуулагдсан.
- 2005 оны 3 дугаар сараас эхлэн МИАТ ХК-тай агаарын шуудан тээврийн тооцоог Дэлхийн Шуудан Холбоо болон ОУ-ын Иргэний Агаарын тээврийн байгууллагын журам зааврын дагуу гэрээний үндсэн дээр хийж гүйцэтгэж ирсэн.
- 2021 оны 9 дүгээр сард компанийн нэрийг Юнайтед Айр Файнэнс ХХК болгон өөрчилсөн.
- Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасны дагуу хөрөнгө итгэмжлэн удирдах тусгай зөвшөөрөл авч, зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх зорилгоор компанийн бүтэц зохион байгуулалтыг шинэчилсэн баталсан.
- Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 473 дугаар тогтоолоор Үнэт цаасны зах зээлд Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөл авсан.

УЛААНБААТАР ХОТ
ЛЭНДМН АКТИВ ТЗК ХХК
9022080559
ХТҮ4977 6888895



РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
RHINOS INVESTMENT ҮЦК LLC
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2022 он .09 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-07
БҮРТГЭВ-02

lendmn

# ТАВ. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

## 5.1 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Хөрөнгөөр батгаажсан үнэт цаас гаргагчтай холбоотой үйл ажиллагаа нь хууль эрх зүйн орчны хувьд дараах хууль тогтоомжуудаар зохицуулагдаж байна Үүнд:

- Иргэний хууль
- Үнэт цаасны зах зээлийн тухай хууль
- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль
- Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль
- Компанийн тухай хууль
- Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль
- Зээлийн мэдээллийн тухай хууль
- Татварын ерөнхий хууль
- Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хууль
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
- Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль

### Зохицуулагч байгууллагаас гаргасан дүрэм журмууд

- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журам
- Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам
- Үнэт цаас зах зээл дэх дотоод мэдээллийн жагсаалт, түүнийг мэдээлэх журам
- Үнэт цаасанд нэгдсэн дугаар олгох журам

### Монголын Хөрөнгийн биржийн журмууд

- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас бүртгэлийн журам
- Арилжааны журам

### Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн журмууд

- Үнэт цаасны хадгаламжийн журам
- Үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг бүртгэх үйл ажиллагааны журам

### Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтууд

Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн үйл ажиллагаа нь Банк бус санхүүгийн байгууллага болохын хувьд хууль эрх зүйн орчны хувьд дараах хууль тогтоомжуудаар зохицуулагдаж байна.

- Монгол улсын үндсэн хууль
- Монгол улсын Олон гэрээ конвенцийг соёрхон батлах тухай /Монгол Улс 2001 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр гарын үсэг зурсан Терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай олон улсын Конвенц/
- Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц, түүний нэмэлт болох хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол, шилжин суурьшигчдыг газраар, далайгаар болон агаараар хууль бусаар оруулахын эсрэг протокол, шилжин суурьшигчдыг газраар, далайгаар, болон агаараар хууль бусаар тээвэрлэх, үйлдвэрлэхийн эсрэг протоколд нэгдэн орсныг соёрхон батлах туай /Палермогийн конвенц/
- Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам
- Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам
- Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам
- Банкнаас бусад санхүүгийн болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх тохиромжтой этгээдийг тодорхойлох журам
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам
- Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх, хорогдуулах, шинээр хувьцаа гаргах, худалдах, шилжүүлэхэд мөрдөх журам
- Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалуулагчид мэдээлэл өгөх журам
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд зайны болон газар дээрх хяналт хийх журам

## Хөрөнгийн багцтай холбоотой эрх зүйн зохицуулалтууд

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 1.1-д "Энэ хуулийн зорилт нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, түүнд хяналт тавих, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино" гэж тодорхойлсон байдаг.

Дээрхээс үзвэл Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, түүнийг гаргагчтай холбоотой эрх зүйн үндсийг тогтож байгаа эрх зүйн гол баримт бичиг нь энэ хууль болох бөгөөд уг хуулиар Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргагч болон оролцогч этгээдүүдэд танигдахшаардлага, хөрөнгийн багцад тавигдах шаардлага, баталгаат үнэт цаас гаргах харилцаанд

оролцогч этгээдүүдийн хоорондын харилцаа, эрх үүрэг болон хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зохицуулалтууд бүгд тусгагдсан байна. Дээрх хуульд үндэслэн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тусгай зөвшөөрөл олгох болон, үнэт цаасыг бүртгэх үйл ажиллагааг зохицуулагч байгууллага болох СЗХ-оос гаргасан журмуудаар зохицуулж байна.

СЗХ-ны 2011 оны 9 дүгээр сарын 14-ний өдрийн 266 дугаар тогтоолоор батлагдсан "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам–ын 1.1-д "Энэхүү журмын зорилго нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг СЗХ-нд бүртгэх, түүнд хяналт тавих, зэх зээлийн харилцаанд оролцогчдод тусгай зөвшөөрөл олгох, шалгуур үзүүлэлтүүдийг тогтоох, эрх олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино" гэж заасан, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тусгай зөвшөөрөл олгох болон түүнийг бүртгэх, оролцогчдод тавих шалгуурыг тогтоох, эрх олгохтой холбоотой харилцааг тусгайлан зохицуулсан байна.

Мөн энэхүү журмаар Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргагч хуулийн этгээдтэй холбоотой Компанийн тухай хуулиар шийдвэрлэгдээгүй асуудлууд болох үүсгэн байгуулагчид тавигдах шаардлага, ТУЗ-ийн гишүүдэд тавигдах шаардлага зэргийг нарийвчлан зохицуулсан байна.

МХБ-ийн "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам"-аар хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг тус биржийн бүртгэлд бүртгэх, Бүртгэлийн шалгуур шаардлага тогтоох, Үнэт цаас гаргагчийн хүлээх үүрэг, түүнд биржээс хяналт тавих журмыг тогтоосон байна.

## 5.2 ҮНЭТ ЦААСТАЙ ХОЛБООТОЙ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргахтай холбоотой үйл ажиллагаанд мөрдөх дараах журмуудыг Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь 2022 оны 07 сарын 4-ний өдрийн 22/03, 22/04 тоот тогтоолуудаар, 2022 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн 22/11 тоот тогтоолоор тус тус баталсан.

### Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам

Тус журамд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, холбогдох хууль тогтоомж, зохицуулалтын байгууллагаас баталсан дүрэм, журам, стандартуудыг дагаж мөрдөх, үүсэж болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх харилцааг зохицуулсан.

### Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргүүлэх журам

СЭХ
2022 он 09 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01

MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-07



Тус журамд хөрөнгө оруулагч, үнэт цаас эзэмшигчид Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны талаар болон хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг тогтмол хүргэх, уг мэдээллийн төрөл, хэлбэр, давтамж, мэдээллийн ил тод байдлыг хангах, нийтэд хүргэх, нэгдсэн нэг мэдээллийн урсгалтай байх, түүнийг хэрэгжүүлэх, хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулсан.

### Хөндлөнгийн аудитор, үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгох, солих журам

Тус журамд холбогдох этгээдүүдэд тавигдах шаардлага, шалгуур, гэрээ байгуулах, тэдгээрийг солих болон гэрээ цуцлахтай холбоотой харилцааг зохицуулсан.

### Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам

Тус журамд хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргахтай холбоотойгоор үүсгэн байгуулагдсан төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг зохицуулсан.

### Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх тухай журам

Тус журамд ТЗК-аас гаргах хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны хөрөнгийн багц дахь зээлүүдийн төлбөрийг цуглуулах, үнэт цаас эзэмшигчдэд үнэт цаасны төлбөр төлөхтэй холбоотойгоор ТЗК, Үйлчилгээ үзүүлэгч, Хөрөнгө итгэмжлэн удирдагч болон бусад холбогдох этгээдийн хооронд үүсэх харилцааг зохицуулсан.

### Хөрөнгийн багцад өөрчлөлт оруулах журам

Тус журамд компанийн гаргаж буй хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны баталгаа болох зээлийн хөрөнгийн багцад буй хөрөнгийг солих, нэмэх, хасах замаар багцад өөрчлөлт оруулахтай холбоотойгоор Үнэт цаас гаргагчийн Анхны үүрэг гүйцэтгүүлэгч, Хөрөнгө итгэмжлэн удирдагч болон бусад оролцогчтой холбоотой харилцааг зохицуулсан.

### Эрсдэл удирдлага, дотоод хяналтын журам

Тус журамд ТЗК-ийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, үнэт цаасны төлбөрийг хөрөнгө оруулагч, үнэт цаас эзэмшигчдэд төлөхтэй холбоотой үйл ажиллагааны эрсдэлийг удирдах, түүнтэй холбогдсон дотоод хяналтыг хэрэгжүүлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээ авахтай холбоотой холбогдох хууль, журмын хүрээнд зохицуулагч байгууллагууд болон оролцогч талуудтай харилцах харилцааг зохицуулсан.

УЛААНБААТАР ХОТ
ЛЭНДМН АКТИВ ТЗК ХХК



РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
RHINOS INVESTMENT
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2022.09.21 өдөр
БҮРТГЭВ
№

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-07
БҮРТГЭВ-02

lendmn

# ЗУРГАА. ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА

## 6.1 ҮНЭТ ЦААСЫГ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛД БАЙРШУУЛАХ

Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржээс үнэт цаас гаргагчийн гаргаж буй Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг нээлттэй хүрээнд нийтэд санал болгон арилжаалахыг зөвшөөрч үнэт цаасны бүртгэлд бүртгэсэн тохиолдолд Андеррайтер нь бусад үнэт цаасны компаниудад анхдагч зах зээлд байршуулах дэлгэрэнгүй төлөвлөгөө буюу Андеррайтер төвтэй анхдагч зах зээлийн захиалга авах системийг танилцуулж, захиалга бүртгэл явагдах болно.

*Хүснэгт 21: Үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулах*




## 6.2 ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААНД ОРОЛЦОХ, ЗАХИАЛГА АВАХ ЗААВАР

- **Үнэт цаасны данс нээлгэх**
  Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй аль нэг үнэт цаасны компанид үнэт цаасны данс нээлгэх
- **Мөнгө байршуулах**
  Үнэт цаасны дансанд доорх зааврын дагуу ХБҮЦ худалдан авах мөнгөн дүн болон арилжааны шимтгэлийг хамт байршуулах
- **Захиалга өгөх**
  Харилцагч та өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компанидаа үнэт цаас худалдаж авах захиалга өгөх

Үнэт цаасны дансанд мөнгө байршуулах заавар

- Хүлээн авагч банк: ҮЦТХТ ХХК /92 кодтой банк/
- Дансны дугаар: Өөрийн харилцагч Брокероос авах
- Дансны нэр: Харилцагчийн нэр/Овог бичихгүй/
- Гүйлгээний утга: ЛэндМН ХБҮЦ , Нэр, Регистр

### 6.3 ҮНЭТ ЦААС ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ

**Үнэт цаасны эзэмшигч нь дараах эрхтэй байна.**

- Үнэт цаасыг биржийн арилжааны журмаар худалдан авснаар үнэт цаасыг эзэмшилдээ шилжүүлэн авах, шилжүүлэн авахыг шаардах;
- Үнэт цаасны хүү болон үндсэн төлбөрийг тогтоосон хугацаанд хүлээн авах, төлөхийг үнэт цаас гаргагчаас шаардах;
- Үнэт цаас эзэмших эрхээ гуравдагч этгээдэд чөлөөтэй шилжүүлж, захиран зарцуулах, арилжаалах;
- Үнэт цаас эзэмшиж буй хугацаандаа Үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагааны талаар мэдээлэл хүлээн авах, мэдээллээр хангахыг шаардах;
- Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны танилцуулга болон гэрээнд заасан үүргээ зохих ёсоор биелүүлээгүй бол биелүүлэхийг шаардах;

### 6.4 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮҮРЭГ

ТЗК нь хөрөнгийг өмчлөх, бизнесийн үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх эсхүл шинээр эхлүүлэх болон ХБҮЦ гаргах баримт бичиг, хэлцлийн баримт бичгийн дагуу үүрэг хүлээх, эсхүл хүлээсэн үүргээ биелүүлэхтэй холбоотой, эсхүл тэдгээрийг зохицуулдаг бүх хууль, журам зааврыг бүх талаар дагаж мөрдөх үүрэгтэй.

- Үнэт цаасны үндсэн болон хүүний төлбөрийг төлбөр гүйцэтгэх хуваарийн дагуу бүрэн төлж барагдуулах;
- Үнэт цаасны танилцуулгад тусгагдсаны дагуу Үнэт цаасны хүүний орлогод ногдох татварыг суутган төсөвт төлөх, тайлагнах;
- Холбогдох гэрээний дагуу хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүйн улмаас Үнэт цаас эзэмшигчид учруулсан аливаа хохирлыг үл маргах журмаар төлж барагдуулах;
- Хөрөнгө болон хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны санхүүгийн нөхцөлд нөлөөлөхүйц мэдээллийг Үнэт цаас гаргагчийн "Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргэх, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах журам"- заасны дагуу Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэх;
- Холбогдох хууль тогтоомж, гэрээгээр тодорхойлогдох бусад үүрэг.

## 6.5 ҮНЭТ ЦААС ЭЗЭМШИГЧДЭД МЭДЭЭЛЭЛ ХҮРГҮҮЛЭХ ТУХАЙ

Үнэт цаас гаргагч нь хөрөнгө оруулагч, үнэт цаас эзэмшигчид Компанийн үйл ажиллагааны талаар болон хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг тогтмол хүргэх, уг мэдээллийн төрөл, хэлбэр, давтамж, мэдээллийн ил тод байдлыг хангах, нийтэд хүргэх, нэгдсэн нэг мэдээллийн урсгалтай байх, түүнийг хэрэгжүүлэх, хяналт тавих үүрэгтэй.

Үнэт цаас гаргагч нь мэдээлэл хүргэхдээ Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны "Үнэт цаасны бүртгэлийн журам", "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журам", "Үнэт цаасны зах зээлд дотоод мэдээллийн жагсаалт, түүнийг мэдээлэх журам", Монголын хөрөнгийн биржийн "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам" болон энэхүү "Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргэх журам" -д заасны дагуу мэдээллийг цаг тухайд нь үнэн зөв, агуулгын хувьд хоёрдмол утгагүй, бүрэн гүйцэт мэдээлэх үүрэгтэй.

Үнэт цаас гаргагч нь мэдээллийг Монгол хэл дээр хүргэх ба мэдээллийг олон нийт болон хөрөнгө оруулагч, үнэт цаас эзэмшигчид өөрийн болон Биржийн цахим хуудсаар хүргэнэ. Компани шаардлагатай гэж үзвэл гадаад хэл дээр мэдээллийг давхар хүргэж болно.

Мэдээ, мэдээллийг үнэн зөв олон нийтэд хүргэх, үнэт цаас эзэмшигчид, эрх бүхий байгууллагын өмнө хүлээсэн үүргийн хэрэгжилтийг гэрээний үндсэн дээр хөрөнгө итгэмжлэн удирдагчаар гүйцэтгүүлнэ. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь мэдээллийг үнэн зөв, цаг хугацаанд нь хөрөнгө оруулагч, үнэт цаас эзэмшигчид хүргэхийг хариуцан ажиллах ба Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл хөрөнгө итгэмжлэн удирдагчтай байгуулсан гэрээний хэрэгжилтийг хянана.

**Мэдээлэл хүргэх хугацаа**

- Хорооны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журмын 3.22-д заасан мэдээллийг Хороо болон хөрөнгө оруулагч, үнэт цаас эзэмшигчид, Биржийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 9.7.1.3-д заасан мэдээллийг Биржид тус тус дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор мэдээлнэ.
- Хорооны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журмын 3.22-д заасан мэдээлэл, Биржийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 9.7.1.1-д заасан хагас жилийн тайлангийн мэдээллийг 7 сарын 20-ны дотор мэдээлнэ.

- Хорооны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журмын 3.23-д заасан жилийн үйл ажиллагааны тайланг Хороо болон хөрөнгө оруулагч, үнэт цаас эзэмшигчид дараа оны 2 дугаар сарын 20-ны дотор, Биржийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 9.7.1.1-д заасан мэдээллийг дараа оны 2 дугаар сарын 10-ны дотор, тус журмын 9.7.1.2-д заасан мэдээллийг дараа оны 3 дугаар сарын 31-ны дотор Биржид тус тус мэдээлнэ.
- Хорооны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журмын 3.22-т заасан мэдээлэлд өөрчлөлт орсон бол Хороо болон хөрөнгө оруулагч, үнэт цаас эзэмшигчид, Биржийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 9.7.2-д заасан мэдээлэлд өөрчлөлт орсон бол Биржид тус тус өөрчлөгдсөн тухай бүр ажлын 3 өдөрт багтаан мэдэгдэнэ.
- Үнэт цаас гаргагч нь улирлын шинж чанартай тайланг Хороо болон Биржид цахимаар мэдэгдэх бөгөөд хагас жил тутмын болон жилийн тайланг бичгээр мэдэгдэнэ.

**Мэдээллийн архив бүрдүүлэх, хадгалах**

Үнэт цаас гаргагч нь олон нийтэд хүргэх мэдээллийг нэгэн зэрэг сонирхогч бүх этгээдэд Биржийн болон Компанийн цахим хуудсаар дамжуулан тогтоосон хугацаанд мэдээлнэ. Компанийн цахим хуудсанд нийтэд тогтмол мэдээлэл хүргэх хэсэг байрших бөгөөд тус хэсгийн мэдээлэл нь Компани татан буугдах хүртэл хугацаанд байршина.

Үнэт цаас гаргагчийн бүхий л баримт бичгийг татан буугдах хүртэл хугацаагаар хадгалах бөгөөд Үнэт цаас гаргагч, эсхүл Захиргааны үйлчилгээ үзүүлэгч нь гэрээний үндсэн дээр энэхүү хугацаанд баримт бичгийг архивлан хадгалах ажлыг хариуцна.

Үнэт цаас гаргагч татан буугдах үед холбогдох бүхий л баримт, материалыг үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагчид хүлээлгэн өгөх бөгөөд үүсгэн байгуулагч хүлээн авсан материалыг 5 жил хадгалсны дараа архивлана.

СЗХ
2022 .09.21
БҮРТГЭВ
№

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-07
БҮРТГЭВ-02

lendmn

# ДОЛОО. ҮНЭТ ЦААС ГАРГАХАД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУДЫН ТУХАЙ

## 7.1 ЕРӨНХИЙ АНДЕРРАЙТЕРИЙН ТУХАЙ

| **Байгууллагын нэр** | **Райнос Инвестмент ҮЦК ХХК** |
|---|---|
| **Үйл ажиллагааны чиглэл** | Андеррайтер, Брокер, Дилер |
| **Үүсгэн байгуулагдсан огноо** | 2019/10 |
| **Улсын бүртгэлийн дугаар** | 9019097033 |
| **Регистрийн дугаар** | 6481299 |
| **Хаяг** | Монгол улс, Улаанбаатар хот 14200, Сүхбаатар дүүрэг-8, Д.Сүхбаатарын талбай-2, Сэнтрал тауэр, 13 давхар, 1308б тоот |
| **Утас** | 7510-0575 |
| **Цахим шуудан** | info@rhinosinvest.mn |

“Райнос Инвестмент ҮЦК” ХХК нь БНСУ-ын хуулийн этгээд Райнос Эссет Менежмент ХХК-ийн 100 хувийн хөрөнгө оруулалттайгаар 2019 онд анх үүсгэн байгуулагдсан бөгөөд Монгол улсын хөрөнгийн зах зээлд амжилттай үйл ажиллагаагаа явуулахаар зорин ажиллаж байна. “Райнос Инвестмент ҮЦК” ХХК нь Брокер, Дилер, Хөрөнгө оруулалтын зөвлөх, Гадаад улсын зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах, Номинал дансаар дамжуулан үнэт цаасны брокерын цогц үйлчилгээг Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн дагуу эрхэлж байгаа бөгөөд гадаадын хөрөнгийн зах зээлд бонд зуучлах, хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээг үзүүлж эхлээд байна.

Үйл ажиллагаа явуулж эхлээд удаагүй боловч манай компани гадаадын зах зээлд арилжаалагдаж буй Монгол Улсын Засгийн Газрын Бонд болон санхүүгийн байгууллагын бондуудад гадаадын хөрөнгө оруулагчдыг амжилттай зуучлан ажиллаж байна.

| | |
|---|---|
| 2019.01 | Үүсгэн байгуулагдсан |
| 2019.12 | Брокер, гадаад арилжааны зуучлал, номинал данс эзэмших үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлөө авсан |
| 2020.06 | ЛэндМН компанийн 5 тэрбум төгрөгийн нээлттэй бондын төсөлд Синдикатаар оролцсон |
| 2020.12 | Дилерийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлөө авсан. |
| 2021.01 | Дүрмийн сангаа $200,000-р нэмэгдүүлсэн |
| 2021.03 | МҮЦКлирингийн төвийн гишүүн болсон |
| 2021.06 | ЛэндМН компанийн 5 тэрбум төгрөгийн нээлттэй бондын төсөлд Синдикатаар оролцсон |
| 2021.07 | Дүрмийн сангаа $200,000-р нэмэгдүүлсэн |
| 2021.09 | Биржийн Бус Зах Зээлийн шууд оролцогч болсон |
| 2021.12 | Андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлөө авсан |

“Райнос Инвестмент ҮЦК” ХХК-ийн толгой компани болох Райнос Эссет Менежмент компанийн Монголд хийсэн томоохон хөрөнгө оруулалтууд:

- Монголын анхны финтек компани болон ЛэндМН ББСБ-ын IPO-д стратегийн хөрөнгө оруулалтыг гадаадын мэргэжлийн хөрөнгө оруулагчийн хувиар хийсэн.
- Монголын хөрөнгийн зах зээлийн түүхэнд анх удаа АНД Системс ХХК-ийн санхүүжилтэд зориулж хувьцаа барьцаалсан солилцох бондын 7 тэрбум төгрөгийн санг амжилттай байгуулсан.
- 2017 оноос хойш БНСУ-ын хөрөнгө оруулалтын сантай хамтран нийт 14 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийж, Монголын компаниудыг өсөлт үзүүлэхэд нь дэмжиж ажилласаар ирсэн.
- Монголын Хөгжлийн Банкны гаргасан хадгаламжийн сертификатын (CD) бүтээгдэхүүнд 2017-2019 онуудад хуримтлагдсан дүнгээр нийт 210.0 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийжээ.
- 2021 онд Технологийн салбарын старт-ап компанид 2.0 сая ам.долларын хөрвөх бондын санхүүжилт хийсэн байна.

Өнөөгийн байдлаар “Райнос Инвестмент ҮЦК” нь:

- "Анд Глобал" ХХК
- "Анд Системс" ХХК
- “ОНДО” ХХК
- "Хас Банк" ХХК
- “ЛэндМН ББСБ” ХХК
- "Капитрон банк" ХХК
- “Гарнетон” ХХК
- "Эрхэт Монгол"
- "Ган Хийц"
- "Beauty Secrets"
- "Томъёо" ХХК

зэрэг дотоодын тэргүүлэгч банк, банк бус санхүүгийн байгууллагууд болон уул уурхай, үйлдвэрлэл, харилцаа холбоо, барилга, технологийн салбарын компаниудад андеррайтерийн болон зөвлөх үйлчилгээ үзүүлэн нийт 45 гаруй тэрбум төгрөгийн санхүүжилтийг татан төвлөрүүлээд байна.

## Андеррайтерийн гэрээний тухай

### Андеррайтерийн үйлчилгээ

- Андеррайтер нь Гэрээний 2.1.2-т заасан Үйлчилгээг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.4.3-д заасан Хөрөнгө оруулагчид тухайн үнэт цаасыг танилцуулах замаар түүнийг худалдахад шаардлагатай бүх хүчин чармайлт гаргах /Best Effort/ хэлбэрээр зохион байгуулна.

- Андеррайтер нь үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг зохион байгуулахдаа Үнэт цаас гаргагчийн үнэт цаасыг тогтоосон үнийн аргаар санал болгон арилжаална.
- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хороо болон Биржийн бүртгэлийн журмын дагуу үнэт цаасыг нийтэд санал болгох үйл ажиллагаанд Хорооны шаардлагыг хангасан хөндлөнгийн хууль, аудит болон хөрөнгө итгэмжлэн удирдах компанитай (цаашид “Түншлэлийн байгууллага” гэх) гэрээ байгуулан, ажиллуулна.

**Андеррайтерийн хүлээх үүрэг**

- Андеррайтер нь Гэрээний дагуу гүйцэтгэвэл зохих үүрэг болон үзүүлэх үйлчилгээг Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хороо болон Биржийн Бүртгэлийн журам болон үнэт цаас гаргах бэлтгэл ажлыг хангахад дагаж мөрдөх шаардлагатай холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн мэргэжлийн өндөр түвшинд зохион байгуулах;
- Андеррайтер нь Гэрээний дагуу гүйцэтгэвэл зохих үүрэг болон үзүүлэх үйлчилгээг нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн болон бодит жишигт нийцүүлэн үр ашигтай, хэмнэлттэй байдлаар гүйцэтгэх бөгөөд үр дүнтэй арга зүйг ашиглан үйл ажиллагааны шуурхай удирдлагыг ханган ажиллана;
- Гэрээ болон үйлчилгээтэй холбоотой ямарваа нэгэн асуудлаар ямагт Үнэт цаас гаргагчийн Андеррайтерийн хувиар хандан ажиллаж, гуравдагч этгээдтэй харилцах аливаа харилцаанд Үнэт цаас гаргагчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах;
- Андеррайтер нь Үнэт цаас гаргагчийн ашиг сонирхлыг эн тэргүүнд тавих бөгөөд өөр төсөл арга хэмжээ болон өөрийн байгууллагын эрх ашигтай сонирхлын зөрчилд орохоос зайлсхийх;
- Гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан олж авсан Үнэт цаас гаргагчийн аливаа мэдээллийн нууцлалыг хадгалах, энэхүү үүргээ зөрчсөнөөс Үнэт цаас гаргагч болон аливаа гуравдагч этгээдэд учирсан бодит хохирлыг бүрэн хариуцах;

**Андеррайтерийн эрх**

- Андеррайтерийн үйлчилгээг үр дүнтэй, шуурхай хэрэгжүүлэхэд шаардлагатай байж болох зааварчилгаа, удирдамжийг Үнэт цаас гаргагчаас томилсон ажилтан болон удирдлагад гарган өгөх;

- Үнэт цаас гаргагчаас томилсон ажилтан нь үүргээ зохих ёсоор гүйцэтгэж чадахгүй байгаа тохиолдолд уг ажилтныг өөр чадвартай ажилтнаар солихыг Үнэт цаас гаргагчаас шаардах;
- Үнэт цаас гаргагч, түүний эрх бүхий этгээд нь нийтэд санал болгох үнэт цаасны үнийг үндэслэлгүйгээр тогтоосон эсхүл тус үнэ нь үнэт цаас гаргах үйл ажиллагааг амжилтгүй болгоход хүргэнэ гэж Андеррайтер үзсэн тохиолдолд Андеррайтер нь андеррайтерийн үйлчилгээ үзүүлэхээс татгалзах;
- Үнэт цаас гаргагчийн нэмж гаргаж буй үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулах, хуваарилалт хийх зарчмыг тогтоох, хуваарилалтыг хийх;
- Үнэт цаас гаргагчаас хууль болон Гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн гүйцэтгэхийг шаардах;

**Синдикат компанийн хүлээх үүрэг**

- Гэрээ болон үйлчилгээтэй холбоотой ямарваа нэгэн асуудлаар ямагт Үнэт цаас гаргагчийн синдикатын хувиар хандан ажиллаж, гуравдагч этгээдтэй харилцах аливаа харилцаанд Үнэт цаас гаргагчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах;
- Үнэт цаас гаргагчаас бичгээр зөвшөөрснөөс бусад тохиолдолд Үнэт цаас гаргагчийн нууц мэдээллийг аливаа гуравдагч этгээдэд ямар нэгэн хэлбэрээр задруулахгүй байх;
- Синдикат нь Гэрээний дагуу гүйцэтгэвэл зохих үүрэг болон үзүүлэх үйлчилгээг Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржийн Бүртгэлийн журам болон үнэт цаас гаргах бэлтгэл ажлыг хангахад дагаж мөрдөх шаардлагатай холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн мэргэжлийн өндөр түвшинд зохион байгуулах;
- Синдикат нь хөрөнгө оруулагч нарт үнэт цаасыг хуулийн дагуу худалдан борлуулах үүрэгтэй.

**Синдикат компанийн эрх**

- Үнэт цаас гаргагчаас гүйцэтгэх ажилтай холбоотой мэдээллийг гаргуулах;
- Үйлчилгээний хөлсийг гэрээний дагуу төлөхийг шаардах;
- Үнэт цаас гаргагчаас хууль болон гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн гүйцэтгэхийг шаардах.

**Үнэт цаас гаргагчийн хүлээх үүрэг**

- Үнэт цаас гаргагч нь Андеррайтер ажил, үүргээ гүйцэтгэхэд шаардагдах аливаа зөвшөөрөл, түүнчлэн үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай гэж үзсэн Үнэт цаас гаргагчийн эрх бүхий этгээдийн тогтоол шийдвэр, мэдээ мэдээлэл, баримт бичгүүдийг Андеррайтераас тогтоосон хугацаанд түргэн шуурхай, бүрэн гүйцэд гаргаж өгөх бөгөөд Андеррайтерийг гагцхүү үнэн зөв мэдээллээр хангах;
- Үнэт цаас гаргагч нь Андеррайтертай харилцах үнэт цаас гаргах бэлтгэл ажлыг хангахтай холбоотой ажлыг хариуцан гүйцэтгэх ажилтан, мэргэжилтэнг томилон ажиллуулах ба тэдгээр ажилтанууд нь удирдамжийн дагуу холбогдох ажил үүргийг зохих ёсоор гүйцэтгэж чадаагүй тохиолдолд түүнийг солих шаардлагыг Андеррайтерийн зүгээс тавьж болох бөгөөд Үнэт цаас гаргагч энэхүү шаардлагыг биелүүлэх;
- Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай анхан шатны баримт бичиг, мэдээлэл, үйлчилгээ үзүүлэх явцад шаардсан бусад баримт бичиг, мэдээллийг Андеррайтерийн санал болгосон хугацаанд, хугацаа заагаагүй бол 14 хоногийн дотор гаргаж өгөх;

**Үнэт цаас гаргагчийн эрх**

- Андеррайтер нь Үйлчилгээг доголдолтой гүйцэтгэсэн бол доголдлыг өөрийн зардлаар арилгахыг шаардах;
- Андеррайтераас томилсон ажилтан нь үүргээ зохих ёсоор гүйцэтгэж чадахгүй байгаа тохиолдолд уг ажилтныг өөр чадвартай ажилтнаар солихыг Андеррайтераас шаардах;
- Андеррайтер нь Гэрээний дагуу хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй бол Үнэт цаас гаргагч нь Гэрээг түдгэлзүүлэх мэдэгдлийг бичгээр үйлдэж, түүнд төлбөл зохих төлбөрийг түдгэлзүүлж болох бөгөөд энэхүү мэдэгдэлд (a) биелүүлээгүй үүргийн шинж чанарыг тодорхойлох ба (b) энэхүү мэдэгдлийг хүлээн авснаас хойш 30 хоногт багтаан тухайн зөрчлийг арилгах арга хэмжээ авахыг Андеррайтераас шаардах

## 7.2 ТУСЛАХ АНДЕРРАЙТЕРИЙН ТУХАЙ

| **Байгууллагын нэр** | **Өлзий энд Ко капитал ҮЦК ХХК** |
|---|---|
| **Үйл ажиллагааны чиглэл** | Андеррайтер, Брокер, Дилер |
| **Үүсгэн байгуулагдсан огноо** | 2017/12/06 |
| **Улсын бүртгэлийн дугаар** | 9011125147 |
| **Регистрийн дугаар** | 5283855 |
| **Хаяг** | Монгол Улс, Улаанбаатар 14200 Сүхбаатар дүүрэг, 8-р хороо Сити тауэр, 25 давхар, 2506 тоот |
| **Утас** | 7777-6377 |
| **Цахим шуудан** | info@ucc.mn |

Өлзий энд Ко капитал ҮЦК ХХК нь Монголын тэргүүний үнэт цаасны компаниудын нэг бөгөөд хөрөнгө оруулалтын банкны үйлчилгээг үзүүлэх үндсэн зорилготойгоор 2007 онд байгуулагдсан билээ. Тус компани нь Санхүүгийн зохицуулах хорооны үнэт цаасны зах зээл дээр брокер, дилер болон андеррайтерийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй, Монголын хөрөнгийн бирж болон Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны гишүүн байгууллага юм.

Өлзий энд Ко капитал ҮЦК ХХК нь Монголын хөрөнгийн биржийн арилжаанд онлайнаар оролцох боломжийг харилцагч нарт олгож, мэдээ мэдээлэл, зөвлөгөөг өгч ажилладаг ба дотоодын үнэт цаасны арилжаа төдийгүй Хонгконг, Лондон, Австрали, НьюЙоркийн хөрөнгийн биржийн арилжаанд бодит цагийн горимоор хувьцаа болон бусад үнэт цаасыг худалдах, худалдан авахад зуучилдаг ба энэхүү үйлчилгээг Монголд анх удаа нэвтрүүлсэн.

Хөгжлийн цоо шинэ шатандаа гарч байгаа Монголын компаниудад хөрөнгийн зах зээлээс хөрөнгө оруулалт татаж бизнесээ өргөжүүлэх боломжийг таниулан, бизнес болон санхүүгийн мэргэжлийн зөвлөгөө өгч хамтран ажилладаг. Мөн түүнчлэн салбартаа тэргүүлэгч томоохон компаниудын үнэт цаас гаргах үйл ажиллагаанд андеррайтерийн мэргэжлийн үйлчилгээг үзүүлж байна.

- 2008 он, Брокер дилер андеррайтерийн тусгай зөвшөөрөл авсан.
- 2009 он, Лондонгийн хөрөнгийн бирж болон АНУ-н банк Bank New York Mellonтой хөрөнгө босгох боломжтийн талаарх форумыг анх удаа зохион байгуулсан
- 2010 он, Монголд анх удаа HKEX, LSE, ASX, NYSE зэрэг биржүүдийн гадаадын арилжаанд оролцох үйлчилгээг нэвтрүүлсэн.
- 2010 он, Bank of China International-тай түншлэв.
- 2011 он, Шилдэг брокерийн компани

- 2011 он, Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбооны гишүүн
- 2013 он, Монголын хөрөнгийн зах зээлийн дээд шагнал Grand Bull Awards "Шинийг санаачлагч байгууллага"
- 2015-2018 он, Япон улсын JICA хамтын ажиллагааны байгууллагад макро эдийн засгийн зөвлөх
- 2016 он, Австралийн CPS Capital ҮЦК-ийн Монгол дахь төлөөлөгч.
- 2018 он, МҮОНТ-ийн "Ногоон сум" реалити шоуны ялагч
- 2018 он, Гүйцэтгэх захирал Б.Өлзийбаяр нь Монголын хөрөнгийн зах зээлийн дээд шагнал Grand Bull Awards "Шилдэг Мэргэжилтэн"
- 2019-2020 он, Үнэт цаасны арилжаанд голлох байр суурьтай оролцож, МХБ-ийн ТОП-5 ҮЦК-д багтсан.
- 2019 он, "Ард Кредит ББСБ" ХК-ийн IPO-д үндсэн андеррайтераар ажиллаж хөрөнгийн зах зээлийн түүхэнд анх удаа захиалгын бүртгэлийн аргыг ашиглан, эрэлтэд үндэслэн хувьцааны үнийг тогтоов.
- 2020 он "ЛэндМН" ББСБ ХК-ийн нээлттэй бондын үндсэн андеррайтер
- 2020 он, Монголын Үнэт Цаасны Клирингийн төвийн шууд гишүүн
- 2020 он, МҮОНТ-н "Цагийн хүрдийн баатар"
- 2020 он, Европын сэргээн босголт хөгжлийн банкны брокер
- 2021 он, Биржийн бус зах зээл /OTC/-ийн анхны гишүүн байгууллага
- 2021 он, Монгол банк, СЗХ, Сангийн яамны хамтарсан тушаалаар баталсан "Sandbox" төслийн анхны бүтээгдэхүүн болох "Монпэй" бондын андеррайтер
- 2021 он, Биржийн бус зах зээлийн /OTC/-ийн анхны "БИД" бондын андеррайтер
- 2022 он, Биржийн бус зах зээл /OTC/-д гаргасан "Ашид капитал ББСБ" ХХК хаалттай бондын үндсэн андеррайтер
- 2022 он, МҮОНТ-ийн орон даяарх "Ногоон сум" аянд хамтрагч компани

Өнөөгийн байдлаар "Өлзий энд Ко Капитал ҮЦК" нь:

- "Мобифинанс ББСБ" ХХК
- "Бэрс финанс ББСБ" ХХК
- "Бичил Глобус ББСБ" ХХК
- "Ард Кредит ББСБ" ХХК
- "Соно финтек ББСБ" ХХК
- "ЛэндМН ББСБ" ХХК
- "Микрокредит ББСБ" ХХК
- "БИД ББСБ" ХХК
- "Хүлэгү Инженеринг" ХХК
- "Монголчех Метал" ХХК
- "Ай Си Ти групп"
- "Монголиан м ючүал финанс групп"
- "Эрхэт Монгол групп"
- "Монголын финтек групп"
- "ОНДО" ХХК
- "Мишээл лайф стайл" ХХК

- “АБТС ББСБ” ХХК
- “Ашид Капитал ББСБ” ХХК
- Капитрон банк
- “Гарнетон” ХХК
- “Шарын гол” ХК
- “Сүү” ХК
- “Говь экуйпмент рентал флийт”

зэрэг дотоодын тэргүүлэгч банк, банк бус санхүүгийн байгууллагууд болон уул уурхай, үйлдвэрлэл, харилцаа холбоо, барилга, технологийн салбарын компаниудад андеррайтерийн болон зөвлөх үйлчилгээ үзүүлэн нийт 150.0+ тэрбум төгрөгийн санхүүжилтийг татан төвлөрүүлээд байна.

## 7.3 ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН УДИРДАГЧ КОМПАНИЙН ТУХАЙ

| **Байгууллагын нэр** | **Юнайтед Айр Файнэнс ХХК** |
|---|---|
| **Үйл ажиллагааны чиглэл** | Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа |
| **Үүсгэн байгуулагдсан огноо** | 2005/01/27 |
| **Улсын бүртгэлийн дугаар** | 9011831586 |
| **Регистрийн дугаар** | 2870657 |
| **Хаяг** | Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, СТӨ 10 давхар, 1005 тоот |
| **Утас** | 7012-2346 |
| **Цахим шуудан** | info@uaf.mn |

Олон нийтэд нээлттэй хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас санал болгож байгаа үйл ажиллагаанд хөрөнгө итгэмжлэн удирдагч болох Юнайтед Айр Файнэнс ХХК нь Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 473 дугаар тогтоолоор Үнэт цаасны зах зээлд Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөл авсан.

Юнайтед Айр Файнэнс ХХК нь Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн хувиар банк, банк бус санхүүгийн байгууллага, ОССК болон Санхүүгийн зохицуулах хорооноос зөвшөөрсөн бусад байгууллагын ТЗК-ийн санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэлийг хөтлөх, үнэт цаасны баталгаа болж буй хөрөнгийн эргэн төлөлтийг цуглуулж үнэт цаасны хэлцэлтэй холбоотой төлбөрийг гүйцэтгэх, мөнгөн хөрөнгийг зөвшөөрөгдсөн хөрөнгө оруулалтад байршуулах, хөрөнгө оруулагч болон зохицуулагч байгууллагад тайлан мэдээ гаргах, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах ажлыг хийж гүйцэтгэнэ.

### Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай байгуулсан гэрээний тухай

Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь хөрөнгө оруулагчийн эрх ашигт нийцүүлэн хөрөнгийг эзэмших, удирдах үндсэн үүргийн хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Хөрөнгийн багцыг удирдах хяналт тавих;
- Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс ТЗК-д хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний дагуу шилжүүлсэн хөрөнгийн жагсаалтын дагуу

компанийн нэрийн өмнөөс өөрийн программ хангамжаар хүлээн авч, багцын бүртгэлийг цаасаар баталгаажуулах;

- ТЗК-ийн хөрөнгийн багц дахь зээлийн данс бүртгэлийг өөрийн компанийн данс бүртгэл, санхүүгийн тайлан тооцооноос тусад нь бүртгэх;
- Зээлийн данс бүртгэлийг хянаж, алдаа, зөрчил илэрсэн бол түүнийг залруулах арга хэмжээг тухай бүр авах шаардлагыг Үйлчилгээ үзүүлэгчид хүргүүлэх;
- Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний дагуу шилжүүлэн авах хөрөнгө нь ТЗК-ийн ТУЗ-өөс баталсан хуулийн болон санхүүгийн шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхэд хяналт тавих;
- ТЗК-ийн төлбөр цуглуулах дансанд цугларсан төлбөрөөр үнэт цаасны төлбөр болон ТЗК-ийн бусад төлбөрийн үүргийг гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд нэн даруй ТЗК-д мэдэгдэх.

**Хөрөнгө итгэмжлэн удирдагчийг солих**

Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд заасан зөрчил гаргасан эсхүл гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй, үүргээ биелүүлэх шаардлага хүргүүлсэн боловч гаргасан зөрчлөө арилгаагүй, үүргээ гүйцэтгэхгүй болох нь тогтоогдсон эсхүл гүйцэтгэх чадваргүй болсон, дампуурах байдалд хүрсэн зэргээр хөрөнгө итгэмжлэн удирдагчийг солих шаардлага үүссэн тохиолдолд ТУЗ-ийн шийдвэрээр гэрээг цуцлах тухай санал гаргана солино.

Үнэт цаас гаргагч нь Хөрөнгө итгэмжлэн удирдагчийг солих тохиолдолд Хөрөнгө итгэмжлэн удирдагчид ажлын 30 өдрийн өмнө мэдэгдэл хүргүүлнэ. Мэдэгдэл хүргүүлсэн өдрөөс хойш ажлын 30 өдөрт багтаан Хөрөнгө итгэмжлэн удирдагчид хадгалагдаж байсан Үнэт цаасны болон Хөрөнгийн багцтай холбоотой баримт бичгийг үнэт цаас гаргагчийн шинээр томилогдсон этгээдэд хүлээлгэн өгөх эрхтэй.

Үнэт цаас гаргагч нь шинэ хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгон, томилж амжаагүй тохиолдолд буюу шинээр хөрөнгө итгэмжлэн удирдагчтай гэрээ байгуулах хүртэл ТЗК-ийн ТУЗ өөрөөр шийдвэрлээгүй бол тийнхүү шинээр томилогдох хүртэл хугацаанд Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь хууль тогтоомж болон энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ хэвийн, урьдын адил гүйцэтгэх үүрэгтэй.

## 7.4 ЗЭЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ ГАРГАГЧ КОМПАНИЙН ТУХАЙ

| Байгууллагын нэр | Нийслэл-Аудит ХХК |
|---|---|
| Үйл ажиллагааны чиглэл | Аудитын үйл ажиллагаа |
| Үүсгэн байгуулагдсан огноо | 2005 |
| Улсын бүртгэлийн дугаар | 9011005110 |
| Регистрийн дугаар | 5009766 |
| Хаяг | Сүхбаатар дүүрэг, 6-р хороо, НҮБ-ын гудамж, 44-р байр 1 тоот |
| Утас | 318918, 70110095, 70120095 |
| Цахим шуудан | info@niislelaudit.mn |

“Нийслэл-Аудит” ХХК нь 2005 онд санхүүгийн тайлангийн аудит, баталгаажуулалт, нягтлан бодох бүртгэл, мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх чиглэлээр байгуулагдсан. Бид үйл ажиллагаагаа Монгол улсын нягтлан бодох бүртгэлийн болон Аудитын тухай хууль, Санхүүгийн тайлагнал ба Аудитын олон улсын стандартыг мөрдлөг болгон мэргэжлийн ёс зүйн шаардлагад нийцүүлэн бие даасан, хараат бусаар үйл ажиллагаагаа явуулдаг үндэсний томоохон аудитын байгууллагуудын нэг юм.

### Тусгай зөвшөөрлүүд

- Аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл № 052-2005;
- Хөрөнгийн үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл № 081100093;
- Үнэт цаасны зах зээлд оролцогчдод аудитын үйлчилгээ үзүүлэх эрх №14/17;

### Үйл ажиллагааны чиглэлүүд

Аудитын үйлчилгээ

- Санхүүгийн тайлангийн аудит ба баталгаажуулалт;
- Тусгай зориулалтын хүрээнд бэлтгэсэн санхүүгийн тайлангийн аудит;
- Салангид санхүүгийн тайлан, санхүүгийн тайлангийн тусгай бүрдэл хэсэг, данс, үзүүлэлтийн аудит;
- Гүйцэтгэлийн аудит;
- Санхүүгийн тайлангийн нягтлах үйлчилгээ;

Зөвлөх үйлчилгээ

- Санхүү нягтлан бодох бүртгэл хөтлөх зөвлөгөө;
- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримт боловсруулах арга зүй;
- Татвар, нийгмийн даатгалын тайлан гаргахад туслах;

- Татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчийн зөвлөгөө;
- Байгууллагын дотоод хяналтын системийг боловсронгуй болгох;

Аутсорсингийн үйлчилгээ

- Байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан бэлтгэх;
- Татвар, нийгмийн даатгалын тайлан бэлтгэх;
- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримт боловсруулах;
- Бизнес төлөвлөгөө, төсөл боловсруулах;
- Санхүүгийн тайланд шинжилгээ хийх;
- Байгууллагын хөрөнгийн тооллого хийх;
- Санхүүгийн баримтыг цэгцлэх; "Нийслэл Аудит" ХХК

Хөрөнгийн үнэлгээ

- Бизнесийн үнэлгээ;
- Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ;
- Эд хогшил, машин тоног төхөөрөмжийн үнэлгээ;

Сургалт

- Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны сургалт;
- Эд хариуцагчийн сургалт;
- Санхүүгийн тайлагналын болон Аудитын Олон Улсын Стандартуудын Үндсэн ойлголт, хэрэглээний тайлбар;

Нийслэл-Аудит ХХК нь эзэмшиж буй тусгай зөвшөөрлийн дагуу 2020 оны 09 сарын 10-ны байдлаар давхардсан тоогоор өмчийн бүх төрлийн 4500 гаруй хуулийн этгээдэд санхүүгийн тайлангийн аудит, баталгаажуулалт, 12 аж ахуйн нэгжид хөрөнгийн үнэлгээ, 22 байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтыг боловсруулж өгснөөс томоохныг нь дурдвал:

НЭГ. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ, БАТАЛГААЖУУЛАЛТЫН АЖИЛ

А. АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГУУД (үйл ажиллагааны чиглэлээр):

Зам , барилга, тээврийн салбар

Зорчигч Тээврийн Нэгтгэл ОНӨААТҮГ;
Нийслэлийн Нийтийн Тээврийн Газар;
Иргэний Нисэхийн Ерөнхий Газар;
Эрдэнэ Зам ХХК;
Улаанбаатар АЗЗА ХК

Банк, санхүү, даатгалын салбар

Төрийн Банк;
Монгол Даатгал;

Капитрон Банк;
Ард Даатгал;
Монре Даатгал;
Соёмбо Даатгал;
Улаанбаатар Даатгал;
Нийслэлийн Нийгмийн Даатгалын Газар;

Боловсролын салбар

Монгол Улсын Их Сургууль;
Улаанбаатар Их Сургууль;
Сант Бүрэн Дунд Сургууль;
Монголын Хүүхдийн Ордон;
Улаанбаатар дахь Олон Улсын Дунд Сургууль;
Жет Дунд Сургууль;

Мэдээлэл холбоо, шуудангийн салбар

Монгол Шуудан ТӨХК;
Мэдээлэл Харилцаа Холбоо Технологийн Газар;
Улаанбаатар Телевиз ХХК;
Ситинэтворкс ХХК

Эрчим хүч, уул уурхайн салбар

Эрдэнэтийн Дулааны Цахилгаан Станц ТӨХК;
ТЭЦ II ТӨХК;
ТЭЦ III ТӨХК;
Цайрт Минерал ХХК;

Үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний салбар

Илч Түлш ХХК
Магнай трейд групп;
Ус Сувгийн Удирдах Газар;
Орон Сууц Нийтийн Аж Ахуйн Удирдах Газар;
Оол-Эм Групп;
Жагар интернэшнл ХХК;
Монтээвэр ХХК;
Хүрд ХХК;
Монгол Базальт ХХК;

Б. ГАДААДЫН ЗЭЭЛ ТУСЛАМЖ БОЛОН ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГААС САНХҮҮЖҮҮЛСЭН ТӨСЛҮҮД:

- Дэлхийн банкны санхүүжилтээр Монгол Улсад хэрэгжсэн төслүүд:
- Засаглалыг Дэмжих, Эдийн Засгийн Чадавхийг Хөгжүүлэх Төсөл;
- Хувийн Хэвшилийг Дэмжих Зээлийн Төсөл;
- Санхүүгийн Чадавхийгхөгжүүлэх Төсөл;
- Хөдөөгийн Цахилгаан Хангамжид Сэргээгдэх Эрчим Хүчийг Ашиглах Төсөл;
- Олборлох Үйлдвэрлэлийн Ил Тод Байдлыг Сайжруулах Төсөл;
- Шувууны Томуугийн Төсөл;
- Хөдөөгийн Боловсролыг Дэмжих Төсөл;
- Бүх Нийтийн Боловсролыг Дэмжих Төсөл;
- Олон Салбарыг Хамарсан Техник Туслалцааны Төсөл;
- Уул Уурхайн Техник Туслалцааны Төсөл;
- Боловсролын Чадавхийг Сайжруулах Төсөл;
- Хөдөө Аж Ахуйн Маркетинг, Бодлогын Дүн Шинжилгээ Мониторингийг Сайжруулах Төсөл;
- Алслагдсан Хөдөөгийн Малчдын Хүүхдүүдийн Бага Боловсролын Үр Дүнг Сайжруулах Төсөл;
- Боловсролын Чанарын Шинэчлэлийн Төсөл;

- Цахим Эрүүл Мэндийн Төсөл;
- Бодлогын Дүн Шинжилгээ, Мониторингийн Чадавхийг Бэхжүүлэх Төсөл;
- Улаанбаатар Хотын Цэвэр Агаар Төсөл;
- Орон Нутгийн Дулаан Хангамжийг Сайжруулах Төсөл;
- Улаанбаатар Хотын Эмзэг Бүлгийн Эрүүл Мэндийг Сайжруулах Төсөл;
- Хот Хөгжүүлэх Төсөл;
- НҮБ-ийн санхүүжилтээр Монгол улсад хэрэгжсэн төслүүд:
- Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг бууруулах төсөл;
- Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Монгол Улсад хэрэгжсэн төслүүд:
- Баруун бүсийн автозам сайжруулах төсөл;
- Боловсролын III төсөл;
- Эрүүл мэндийн III төсөл;
- Хот хөгжүүлэх төсөл;
- Иргэдийн оролцоонд тулгуурласан дулааны нийлүүлэлтийн үр ашгийг нэмэгдүүлэх төсөл;
- Улаанбаатар хотын эмзэг бүлгийхэнд үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээний төсөл;
- Монгол улсын Засгийн газар, Япон улсын Засгийн газрын санхүүжилтээр хэрэгжсэн төслүүд:
- Тогтвортой амжиргаа-II төсөл;
- Алслагдсан хөдөөгийн малчдын хүүхдүүдийн бага боловсролын үр дүнг сайжруулах төсөл;

ХОЁР. ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ

Эрдэнэтийн Дулааны Цахилгаан Станц;
Онцгой Байдлын Ерөнхий Газар;
Патрикейн ХХК;
Эр И Эй Б ХХК;
Шижир Алт ХХК;
Сити Инвест ХХК;
Саусгоби Сэндс ХХК;
Кино Урлагийн Дээд Сургууль;

ГУРАВ. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГЫН БИЧИГ БАРИМТ

Нийслэлийн Хөрөнгө Оруулалтын Газар
Хөдөө Аж Ахуйн Давхар Даатгал
Сант Дунд Сургууль
Гадаадын Иргэн Харьяатын Газар

## Зээлийн шинжилгээ гаргагчтай байгуулсан гэрээний тухай

### Аудитын ажил гүйцэтгэгч талын эрх, үүрэг

- Үйлчлүүлэгч байгууллага нь зээлийн багцыг ХБҮЦ гаргах, бүртгүүлэхтэй холбогдох хууль тогтоомжийн дагуу гаргасан эсэхэд харилцан тохиролцсон горимын дагуу аудит хийх,
- Хөрөнгийн багцад гарсан алдаа дутагдал, зөрчлийн талаар холбогдох залруулга, тохируулга хийх саналыг үйлчлүүлэгчид тавих, мөн шаардлагатай асуудлаар зөвлөгөө, туслалцаа үзүүлэх,

- Аудитаар олж авсан хангалттай, зохистой нотлох баримтад үндэслэн **хараат бус санхүүгийн шинжилгээний тайлан гаргах**, шаардлагатай бол нэмэлт тайлбар бичих,
- Аудитын зөвлөмжид заасан алдаа дутагдлыг арилгасан талаар гүйцэтгэлийн хяналт тавих,
- Аудитын явцад болон түүнийг дуусгавар болгосноос хойш үйлчлүүлэгчийн үйл ажиллагаа, өмчлөл гэх мэт үйлчлүүлэгчтэй холбоотой мэдээллийг бусдад задруулахгүй байх,
- Аудитын ажилд шаардлагатай мэдээллийг үйлчлүүлэгчээс авч танилцах эрхтэй

**Хариуцлага**

- Санхүүгийн удирдлагыг зохион байгуулах, дотоод хяналт тавих, төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийг зохих ёсоор хэрэгжүүлэх хууль тогтоомж, заавар, журам, стандартыг мөрдөх, санхүүгийн тайланг үнэн зөв, иж бүрэн, найдвартай илэрхийлээгүйгээс үүсэх хариуцлагыг үйлчлүүлэгч тал хүлээнэ.
- Үйлчлүүлэгчийн санхүүгийн тайланд өгсөн **аудитын дүгнэлтийн талаарх хариуцлагыг гүйцэтгэгч тал хүлээнэ**.
- Гэрээний үүргийн биелэлттэй холбоотой гарсан бусад асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

## 7.5 ХУУЛИЙН КОМПАНИЙН ТУХАЙ

| Байгууллагын нэр | “Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс” ХХН |
|---|---|
| Үйл ажиллагааны чиглэл | Хуулийн зөвлөгөө |
| Улсын бүртгэлийн дугаар | 9022001010 |
| Регистрийн дугаар | 5495997 |
| Хаяг | Улаанбаатар хот 14200, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай гудамж, Сентрал Тауэр, 13 давхар, 1301 тоот |
| Утас | 11-330048 |
| Цахим шуудан | info@mdsa.mn |

“Эм Ди Эс энд ХаанЛекс ” ХХН нь Монгол Улсын томоохон хуулийн фирмүүдийн нэг бөгөөд “Илүү сайн үйлчилгээ үзүүлэх” зорилготойгоор 2011 онд байгуулагдсан цагаасаа хойш гадаад, дотоодын бизнесийн байгууллагуудад дэлхийн стандартад нийцсэн хууль зүйн үйлчилгээг дотоодын туршлага, ур чадвартай хослуулан хүргэдэг.

“Эм Ди Эс энд ХаанЛекс” ХХН нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 3.2.1-д заасан үнэт цаасны зах зээлд хууль зүйн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдээр 2014 оны 01 сарын 29-ний өдрийн №25 тоот тогтоолын үндсэн дээр бүртгэгдсэн (Санхүүгийн Зохицуулах

хорооны 2016 оны 02-р сарын 24-ний өдрийн 42 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан), үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээд бөгөөд тус зах зээл дээр хөрөнгө босгож буй компаниудтай хамтран ажиллаж байсан арвин туршлагатай.

## Хууль зүйн зөвлөхтэй байгуулсан гэрээний тухай

### Хууль зүйн зөвлөхийн гэрээгээр хүлээсэн эрх, үүрэг

Хуулийн зөвлөх дараах эрх эдлэнэ.

- Гэрээнд заасан үүргээ гүйцэтгэхийг Үйлчлүүлэгчээс шаардах,
- Гэрээний төлбөрөө Гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэхийг шаардах,
- Үйлчлүүлэгч нь Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд Гэрээг цуцлах,
- Гэрээнд заасан Зөвлөх үйлчилгээг гүйцэтгэхтэй холбоотойгоор тухай бүрт шаардлагатай мэдээ мэдээлэл, баримт бичгийг Үйлчлүүлэгчээс шаардан авах.

Хуулийн зөвлөх дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

- Хуулийн зөвлөх нь Гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор, Гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэх,
- Хуулийн зөвлөх нь гаргасан хөндлөнгийн шинжилгээний тайлан, хуулийн дүгнэлттэй холбогдуулан шаардлагатай тохиолдолд зөвлөмж гаргах, шалгасан материалын хүрээнд тайлбар, тодруулга өгөх, танилцуулга хийх,
- Гэрээнд заасны дагуу үйлчилгээ үзүүлэхдээ үнэн бодит мэдээллээр хангах, үйлчилгээ үзүүлсэн талаар бүртгэл хөтлөх, тайлан гаргах, Үйлчлүүлэгчийн нууцыг чандлан хадгалах.

### Хариуцлага

- Үйлчлүүлэгч нь Хуулийн зөвлөхөд Зөвлөх үйлчилгээтэй холбоотой байж болох аливаа бүх мэдээллийг бүрэн бөгөөд үнэн зөвөөр өгөх үүрэгтэй. Энэ зүйлд заасан "Мэдээлэл" гэдэгт бичгийн, аман, дуу, дүрс, ам дамжсан яриа, бодит таамаг гэх мэт үйлчилгээ авах асуудалтай холбоотой бүх хэлбэр, төрлийн мэдээ, мэдээлэл, мэдүүлэг зэрэг үйлчилгээ үзүүлэхэд ач холбогдолтой болон ач холбогдолтой байж болох Үйлчлүүлэгч, түүний ажилтан, албан хаагч,
- төлөөлөгч, Холбоотой этгээдийн мэдэж байгаа аливаа зүйлийг ойлгоно.
- Үйлчлүүлэгч дээрх заалтад заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд үүсэх хариуцлагаас Хуулийн зөвлөх чөлөөлөгдөнө.

СЗХ
2022 .09. 21
БҮРТГЭВ
№

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -10- 07
БҮРТГЭВ-02

lendmn

# НАЙМ. ДҮГНЭЛТҮҮД

СЗХ
2022 .09. 21 өдөр
БҮРТГЭВ
№ ...

МОНГОЛЫН ... MONGOLIAN ...
2022 -10- 07



## 8.1 ЗЭЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ ГАРГАГЧИЙН ДҮГНЭЛТ

Захиалагч: "ЛЭНДМН ББСБ" ХК болон "ЛЭНДМН АКТИВ" (ЛЭНДМН АКТИВ ТЗК) ХХК

# Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргахтай холбоотой зээлийн баталгаажуулалтын ажлын тайлан

Гүйцэтгэгч: "НИЙСЛЭЛ АУДИТ" ХХК

Улаанбаатар хот
2022 он

УЛААНБААТАР ХОТ
ЛЭНДМН АКТИВ ТЗК ХХК
9022080559
ХТҮ4977 ... 5858895

РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
RHINOS INVESTMENT ҮЦК
УЛААНБААТАР ХОТ

"НИЙСЛЭЛ-АУДИТ" ХХК
НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, ХЯНАЛТЫН ИТГЭМЖЛЭГДСЭН БАЙГУУЛЛАГА
Сүхбаатар дүүрэг, Бага тойруу 44-01,
Улаанбаатар 21046, Монгол улс
Утас: 318918, 70110095 Факс: 70120095
И-мэйл: info@niislelaudit.mn

2022.09.12 № 22/184

танай ______ -ны № ______ -т

"ЛЭНДМН ББСБ" ХК,
"ЛЭНДМН АКТИВ"
(ЛЭНДМН АКТИВ ТЗК) ХХК-д

Тайлан хүргүүлэх тухай

Энэхүү гэрээт ажлыг 2022 оны 6 дугаар сарын 22-ны өдөр "ЛЭНДМН ББСБ" ХК-тай байгуулсан ажил гүйцэтгэх гэрээний дагуу Монгол улсын холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актууд заасан нөхцөлөөр санхүүгийн хэрэглэгдэхүүнийг СТОУС-ын дагуу бүртгэсэн эсэх, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхийг тодорхойлох шинжилгээ хийх, тулган баталгаажуулах ажлыг гэрээний дагуу хийж гүйцэтгэлээ.

Гэрээт ажлын хүрээнд хийж байгаа шинжилгээ, шалгуур үзүүлэлтээр тулган батлагаажуулах ажлыг "ЛЭНДМН ББСБ" ХК-наас ирүүлсэн санхүүгийн болон зээлийн мэдээлэл, компанийн тухайн харилцааг зохицуулах тайлбарлах, хэрэглэхэд зориулагдсан баримт бичгүүд, СТОУС, АОУС-ын холбогдох стандартууд, Монгол Улсын хууль тогтоомжууд, тэдгээрт нийцүүлэн гарсан эрх зүйн актуудыг эх үндэс болгон ашигласан болно. Энэхүү ажлыг гүйцэтгэхдээ мэргэжлийн ёс зүйн шаардлагыг хангаж, шудрага, бодитой байж, мэргэжлийн ур чадвараа хангаж ажилласан.

Энэхүү гэрээт ажлын хүрээнд ашигласан мэдээллийн үнэн зөв байдал нь компанийн удирдлагын үүрэг хариуцлага болно.

ЗАХИРАЛ Т.СУГАРСҮРЭН

**“ЛЭНДМН ББСБ” ХК БОЛОН “ЛЭНДМН АКТИВ” (ЛЭНДМН АКТИВ ТЗК) ХХК-ИЙН УДИРДЛАГАД**

**Хамрах хүрээ**
Бид “ЛЭНДМН ББСБ” ХК-ийн охин компани болох “ЛЭНДМН АКТИВ” (ЛЭНДМН АКТИВ ТЗК) ХХК (цаашид хамтад нь “Захиалагч” гэх) хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргахад зориулан захиалагчаас ирүүлсэн 2022 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн тайланд тусгагдсан зээлийн мэдээллийн бодит байдал захиалагчтай байгуулсан гэрээний хавсралтаарх шалгуур үзүүлэлтүүдийг үндэслэн гэрээт ажлыг гүйцэтгэлээ.

**Зорилго**
“ЛЭНДМН ББСБ” ХК-ийн санхүүгийн хэрэглүүр болох зээлийн талаарх мэдээллийг үндэслэлтэй нотолгоогоор олж авч, уг мэдээлэлд үндэслэн “ЛЭНДМН АКТИВ” (ЛЭНДМН АКТИВ ТЗК) ХХК-ийн зүгээс хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргахад шаардагдах мэдээллийн нийцлийг тулган баталгаажуулах ба уг дүгнэлт нь захиалагч болон хэрэглэгчдийг мэдээллээр хангах, ашиглахад зориулагдсан болно.

**Мэдээллийн эх үүсвэр**
Захиалагчтай байгуулсан гэрээний ажлын даалгаварт мэдээллээр хангах үүргийг захиалагч хүлээсэн тул өөр эх сурвалжийг ашиглаагүй, “ЛЭНДМН ББСБ” ХК-аас ирүүлсэн санхүүгийн тайлан түүнд тусгагдсан зээлийн мэдээллийг эх сурвалж болгосон болно.

*Хүснэгт I. “ЛЭНДМН ББСБ” ХК-ийн санхүүгийн тайлан (сая төгрөгөөр)*

| | 12/31/2021 | 8/31/2022 |
|---|---|---|
| **Нийт хөрөнгө** | | |
| Мөнгөн хөрөнгө | 4,903.68 | 483.43 |
| Богино хугацаат хөрөнгө оруулалт / цэврээр/ | - | 180.00 |
| Нийт зээл | 33,912.81 | 49,218.48 |
| (Зээлийн эрсдлийн сан) | (2,196.76) | (3,454.50) |
| Бусад авлага | 1,433.21 | 1,803.46 |
| Бусад хөрөнгө | 42.50 | 80.33 |
| Эргэлтийн бус хөрөнгийн дүн | 1,211.12 | 1,110.24 |
| **Нийт хөрөнгийн дүн** | **39,306.56** | **49,284.23** |
| **Нийт эх үүсвэр** | | |
| Богино хугацаат өр төлбөр | 16,661.75 | 25,256.31 |
| Урт хугацаат өр төлбөр | 2,845.00 | 2,845.00 |
| Хувьцаат капиталын дүн | 5,662.45 | 3,662.43 |
| Бусад өмч | 14,137.36 | 15,520.47 |
| **Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн** | **39,306.56** | **49,284.23** |

**Шалгуур үзүүлэлт**
Захиалагчтай байгуулсан гэрээний ажлын даалгаврын шалгуурыг баталгаажуулахдаа:

1. СТОУС-9. Санхүүгийн хэрэглүүр
2. Монгол Улсын “Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай” хууль
3. Монгол Улсын “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай” хууль

СЗХ
2022 .09 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-07
БҮРТГЭВ 02



4. Санхүүгийн зохицуулах хороо. "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай" журмын заалтуудыг ашигласан болно.

Дээрх шалгуурууудын үндэслэл нь Аудитын Олон Улсын Стандарт, Нягтлах Гэрээт Ажил Олон Улсын Стандартын дагуу хийгдэх аудитын ажил биш болохыг илэрхийлнэ. Дээрх эх сурвалжууд болон ажлын даалгаварт хавсралтаар санал болгосон шалгууруудыг дараах үзүүлэлтүүдийг үндэслэн үнэлгээнд ашиглалаа.

***Хүснэгт 2. Шалгуур үзүүлэлтүүдийг сонгосон байдал (Автомашины зээл)***

| Эх сурвалж | | Сонгон ашигласан шалгуур үзүүлэлтүүд |
|---|---|---|
| A | Монгол Улсын "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай" хууль | 1. Барьцаат үнэт цаасны хөрөнгийн багцаас орох орлого нь барьцаат үнэт цаасны дагуу хүлээсэн үүргийг гүйцэтгэхэд хүрэлцэхүйц байх;<br>2. Барьцаат үнэт цаасны хөрөнгийн багцад байгаа хөрөнгийн үнийн дүнгийн нийлбэр нь үнэт цаасны төлбөрийн төлөгдөөгүй үнийн дүнгийн нийлбэрийн 110 хувиас багагүй байх;<br>3. Барьцаат үнэт цаасны хөрөнгийн багцад байгаа хөрөнгийн дундаж хүү үнэт цаасны хүүтэй тэнцүү буюу түүнээс их байх;<br>4. Барьцаат үнэт цаасны хөрөнгийн багцад байгаа хөрөнгийн дундаж хугацаа үнэт цаасны дундаж хугацаанаас багагүй байх |
| B | Санхүүгийн зохицуулах хороо "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай" журмын заалтуудын хүрээнд захиалагчийн даалгавар болгосон үзүүлэлтүүд | 1. Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэх хөрөнгийн мэдээлэл нь зээлийн хувийн хэрэг дэх үндсэн баримттай нийцэж байх;<br>2. Зээл нь Монгол төгрөгөөр олгогдсон бөгөөд Монгол төгрөгөөр эргэн төлөгдөх зээл байх;<br>3. Зээлийн эргэн төлөлтийн хуваарьт зээлдэгчийн сар бүрийн төлөх дүнг (төлж дуусгах хугацаа) тусгасан байх, зээлийн хугацааны эцэст бүрэн төлөгдөж дуусахаар байх;<br>4. Фидуцийн гэрээний зүйл нь даатгалд даатгагдсан байх, даатгал нь хүчин төгөлдөр байх<br>5. тээврийн хэрэгслийн хувьд жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд даатгагдсан байх, хүчин төгөлдөр байх<br>6. Тасалбар болгосон өдрийн байдлаар зээл нь хэвийн төлөлттэй байх<br>7. Эрх зүйн бүрэн чадамжтай, 18 нас хүрсэн Монгол улсын иргэн байх;<br>8. Сүүлийн 6 сар тасралтгүй ажил, хөдөлмөр эрхэлсэн байх;<br>9. Зээлдэгчийн тэтгэврийн нас буюу 50 нас хүртэл; |
| C | Монгол Улсын "Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай" хууль | 1. Зээл олгохыг хүссэн өргөдөл;<br>2. Зээлийн гэрээ;<br>3. Зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар сонгосон арга хэлбэр, түүнтэй холбогдох мэдээлэл,<br>4. Иргэн бол орлогын талаарх мэдээлэл;<br>5. Хуулийн этгээд, Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу эрх зүйн байдал нь тодорхойлогдсон этгээд бол орлогын талаарх мэдээлэл, хуульд заасны дагуу татварын байгууллагад тайлагнасан санхүүгийн тайлан;<br>6. Зээл хүсэгчийн өр, орлогын харьцааг нотолсон баримт бичиг;<br>7. Зээлийн ашиглалтыг шалгасан материал;<br>8. Зээлдэгчийн бусад зээлдүүлэгчээс авсан зээл, гуравдагч этгээдийн өмнө хүлээсэн мөнгөн төлбөрийн үүргийн талаарх зээлийн мэдээллийн сангийн мэдээлэл; |

NISLEL-AUDIT LLC
CERTIFIED ACCOUNTING AUDIT & APPRAISAL

УЛААНБААТАР ХОТ
ЛЭНДМН АКТИВ ТЗК ХХК
9022080569

РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
ХХК

**Удирдлагын үүрэг, хариуцлага**
Захиалагчтай байгуулсан гэрээний ажлын даалгаварт өгөгдсөн шалгуурын дагуу бодит, үнэн зөв мэдээллээр хангах, толилуулах үүрэгтэй.

**Хараат бус байдал**
Бид мэргэжлийн ёс зүйн шаардлагыг хангаж ажиллаж, шалгуур үзүүлэлтүүдийг нотлохдоо эрх зүйн хэм хэмжээ болон мэргэжлийн стандартуудыг мөрдөн ажилласан.

**Бидний үүрэг ба хариуцлага**
Бидний үүрэг санхүүгийн хэрэглэгдэхүүн болох зээлийг барьцаалбар болох хөрөнгийн баталгаа болох эсэхэд дүгнэлт өгөх бөгөөд энэхүү ажлыг СТОУС, АОУС-ын хэрэглэгдэх стандарт, тухайн харилцаар зохицуулж байгаа эрх зүйн актуудыг хэм хэмжээ болгон гүйцэтгэлээ.

**Хэрэглээ**

Энэхүү шинжилгээ, шалгуур үзүүлэлтийн нийцлийн тайлан нь "ЛЭНДМН ББСБ" ХК-ийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргахтай холбоотой хэрэглээнд зориулагдсан болно.

"Нийслэл аудит" ХХК

Захирал Т.Сугарсүрэн

СЗХ 2022.09.21 өдөр БҮРТГЭВ №

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2022-10-07 БҮРТГЭВ

## ШИНЖИЛГЭЭ, БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГҮЙЦЭТГЭЛ, ТАЙЛАН

**Шалгуур үзүүлэлтийг сонгон шалгах**

Шалган баталгаажуулахдаа 2022 оны 8 сарын 31 өдрөөрх санхүүгийн тайланд бүртгэгдсэн автомашины зээлийн үлдэгдлийг холбогдох шалгуур үзүүлэлтээр шалган баталгаажууллаа.

**Эх сурвалж ба түүвэрлэлт**

"ЛЭНДМН ББСБ" ХК-ний 2022 оны 8 дугаар сарын 31 өдөөр санхүүгийн тайлангаар нийт эх үүсвэрийн хэмжээ 49.3 тэрбум төгрөг, энэ нь оны эхнээс 25% өссөн, үүнд богино хугацаат өр төлбөрийн өсөлт (51.6%) голлох нөлөө үзүүлсэн байна.

Нийт 49.2 тэрбум төгрөгийн хөрөнгийг зээлд байршуулсан, зээлийн чанарын ангиллыг ерөнхий ба тусгай зохицуулалтын хүрээнд хийж 3.4 тэрбум төгрөгийн эрсдэлийн санг байгуулсан ба энэ нь зээлийн балансын үнэлгээг 7.0% бууруулсан.

*Хүснэгт 3. Санхүүгийн тайлангийн бүтэц, өөрчлөлт (оны эхнээс)*

| Үзүүлэлтүүд | Өөрчлөлт | 12/31/2021 | 8/31/2022 |
|---|---|---|---|
| **Нийт хөрөнгө** | | | |
| Мөнгөн хөрөнгө | -90.1% | 12.5% | 1.0% |
| Богино хугацаат хөрөнгө оруулалт / цэвэрээр/ | 100.0% | 0.0% | 0.4% |
| Нийт зээл | 45.1% | 86.3% | 99.9% |
| (Зээлийн эрсдэлийн сан) | 57.3% | -5.6% | -7.0% |
| Бусад авлага | 25.8% | 3.6% | 3.7% |
| Бусад хөрөнгө | 89.0% | 0.1% | 0.2% |
| Эргэлтийн бус хөрөнгийн дүн | -8.3% | .1% | 2.3% |
| **Нийт хөрөнгийн дүн** | 25.4% | 100.0% | 100.0% |
| **Нийт эх үүсвэр** | | | |
| Богино хугацаат өр төлбөр | 51.6% | 42.4% | 51.2% |
| Урт хугацаат өр төлбөр | 0.0% | 7.2% | 3.8% |
| Хувьцаат капиталын дүн | 0.0% | 14.4% | 11.5% |
| Бусад өмч | 9.8% | 36.0% | 31.5% |
| **Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн** | 25.4% | 100.0% | 100.0% |

Нийт зээлийн 91% хэвийн, хугацаа хэтэрсэн болон чанарын ангилал буурсан зээл 9%-ийг эзэлж байна (Хүснэгт 5). Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргахаар автомашины зээлийн багцыг баталгааны хэрэгслээр ашиглахаар төлөвлөж байгаа ба энэхүү зээл нь нийт зээлийн багцын 12%, хэвийн зээлийн багцын 13%-ийг эзэлж байна. Компанийн зээлийн багцын чанарыг дараах байдлаар харуулав.

NISLEL-AUDIT LLC CERTIFIED ACCOUNTING AUDIT & APPRAISAL

УЛААНБААТАР ХОТ ЛЭНДМН АКТИВ ТЭК ХХК 9022080559

РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК

СЭХ
2022 .09. 21 өдөр
БҮРТГЭВ
№

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -10- 07
БҮРТГЭВ-02



*Хүснэгт 4. Зээлийн багцын чанар (сая төгрөгөөр)*

| Зээлийн багц | Нийт дүн | Хэвийн | Хугацаа хэтэрсэн | Хэвийн бус | Эргэлзээтэй | Муу |
|---|---|---|---|---|---|---|
| Автомашины зээл | 6,037.58 | 5,629.49 | 344.96 | 63.13 | - | - |
| Бусад | 43,180.90 | 39,236.70 | 1,200.72 | 655.04 | 1,005.76 | 1,082.68 |
| **Нийт** | 49,218.48 | 44,866.18 | 1,545.68 | 718.17 | 1,005.76 | 1,082.68 |

*Хүснэгт 5. Зээлийн багцын чанар (хувиар)*

| Зээлийн багц | Нийт | Хэвийн | Хугацаа хэтэрсэн | Хэвийн бус | Эргэлзээтэй | Муу |
|---|---|---|---|---|---|---|
| Автомашины зээл | 12.27% | 11.44% | 0.70% | 0.13% | 0.00% | 0.00% |
| Бусад | 87.73% | 79.72% | 2.44% | 1.33% | 2.04% | 2.20% |
| **Нийт** | **100.00%** | **91.16%** | **3.14%** | **1.46%** | **2.04%** | **2.20%** |

NISLEL-AUDIT LLC
CERTIFIED ACCOUNTING AUDIT & APPRAISAL

УЛААНБААТАР ХОТ
ЛЭНДМН АКТИВ ТЭК ХХК
9022080559
ХТҮ4977 С888095

РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК



УЛААНБААТАР ХОТ
ХХК

СЗХ
2022 оны 09 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-07

**"ЛЭНДМН ББСБ" ХК-ийн зээлийг тулган баталгаажуулах түүврийн сонголт**

"ЛЭНДМН ББСБ" ХК-ийн хөрөнгийн багцад шинжүүлж буй автомашины зээл нь нийт зээлийн 12%-ийг бүрдүүлэх ба хамгийн том нэг зээлдэгчийн багцад эзлэх хувь 0.6% буюу төвлөрөл багатай зээл байна.

Дээрх шинжилгээ, харьцуулалтыг үндэслэн үнэт цаасжуулах жагсаалтад санал болгосон зээлүүдээр түүвэрлэн, тулган баталгаажуулалтыг хийлээ. Түүврийг сонгохдоо:

- 2022 оны 8 дугаар сарын 31 өдрөөр санхүүгийн тайланд тусгагдсан байх,
- Төвлөрөл өндөртэй зээлийн багцийн түүврийн тоо, төлөөлөх утгыг 40%-аас багагүй байхаар,
- Түүвэрт сонгогдсон зээлийн хэмжээ тухайн зээлийн багцын дундаж хэмжээнээс өндөр байх шалгуурыг тавин түүврийг сонголтыг хийлээ.

Түүвэрт дараах тооны зээлийг тухайн багцуудаас сонгон авлаа.

- Авто машины зээлийн гэрээний тоо 157, зээлийн хэмжээ 3,277.2 сая төгрөг энэ нь тухайн зээлийн гэрээний 51.3%, нийт зээлийн 61%-ийг тус тус төлөөлж байгаа болно.

**Зээлийг тулган баталгаажуулах**

Түүвэрт сонгогдсон зээлүүдийг анхан шатны баримт болох гүйлгээ үлдэгдлийн тайлан, зээлийн хувийн хэрэгт хуулийн дагуу бүрдүүлэх ёстой баримтуудтай тулган баталгаажуулах ажлыг хийлээ. Тулган баталгаажуулах ажлын гүйцэтгэл ажлын даалгаварт тусгагдсан шалгуур үзүүлэлтүүдийг хангаж байгааг баталгаажуулах юм. Нотлох баримт бичгийг захиалагчаас эх үүсвэр бүхий зээлийн хувийн хэрэгт тусгагдсан баримтаар хязгаарлав.

Автомашины зээлийг баталгаажуулах зорилгоор 20 үзүүлэлтийг ашиглан, хэрэгжилтийн гүйцэтгэлийг хувиар илэрхийллээ. Шалгуур үзүүлэлтүүдийн гүйцэтгэлийн дундаж 97.5% байгааг дараах хүснэгтээр харуулав.

*Хүснэгт 6. Машины зээлийн тулган баталгаажуулалт*[1]

| Шалгуур үзүүлэлтүүд | | Нотлох баримт бичиг | Шалгуур хангасан эсэх | Тайлбар нотолгоо |
|---|---|---|---|---|
| Шалгуур үзүүлэлтүүд (Ажлын даалгавраар) B | B1 | Анхан шатны баримт, зээлийн жагсаалт | 100% | Анхан шатны баримтаарх зээл, зээлийн жагсаалтаарх зээлийн нэр, дансны үлдэгдэл зөрүүгүй |
| | B2 | Анхан шатны бүртгэл, зээлийн гэрээ | 100% | Зээлийн гэрээ, зээлийн нэрийн данс төгрөгөөр илэрхийлдсэн. |
| | B3 | Анхан шатны бүртгэл, зээлийн гэрээ | 100% | Бүх зээлийн хугацаа гэрээнии өөрчлөлтгүй. |
| | B4 | Машины даатгалын гэрээ | 100% | Бүх машин даатгагдсан, даатгалийн гэрээ хийгдсэн, тухайн оноор хүчинтэй. |
| | B5 | Жолоочийн хариуцлагын даатгалын гэрээ | 96% | Түүвэрт сонгогдсон 7 зээлийн машин эзэмшигч жолоочийн хариуцлагын даатгал хийлгээгүй |

[1] Баталгаажуулалт хийсэн эх материал, ажлын баримтыг хавсралтаар оруусан болно

ИНСЛЕЛ-АУДИТ ХХК
CERTIFIED ACCOUNTING AUDIT & APPRAISAL

УЛААНБААТАР ХОТ
ЛЭНДМН АКТИВ ТЭК ХХК
9022080669
ХТУ4977 С888396

РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
RHINOS INVESTMENT UTsK LLC
УЛААНБААТАР ХОТ

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах зориулалтаар хийгдсэн энэхүү шинжилгээний захиалагчаас санал болгосон шалгуур үзүүлэлтийн зохистой байдлыг тухайн харилцаа зохицуулж буй эрхзүйн акт болох эрх зүйн актуудтай нийцэл бүхий байдлыг дараах байдлаар харуулав.

*Хүснэгт 7. Шалгуур үзүүлэлт, хуулийн заалтын нийцэл*

| Захиалагчийн ажлын даалгаварт санал болгосон үзүүлэлтүүд | Монгол Улсын "Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай" хууль |
|---|---|
| **Автомашины зээлийн шалгуур:** | |
| 1. Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэх хөрөнгийн мэдээлэл нь зээлийн хувийн хэрэг дэх үндсэн баримттай нийцэж байх; | 19.2. Зээлийн гэрээ; |
| 2. Зээл нь Монгол төгрөгөөр олгогдсон бөгөөд Монгол төгрөгөөр эргэн төлөгдөх зээл байх; | 19.2. Зээлийн гэрээ; |
| 3. Зээлийн эргэн төлөлтийн хуваарьт зээлдэгчийн сар бүрийн төлөх дүнг (төлж дуусгах хугацаа) тусгасан байх, зээлийн хугацааны эцэст бүрэн төлөгдөж дуусахаар байх; | 19.3. Зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар сонгосон арга хэлбэр, түүнтэй холбогдох мэдээлэл;<br>19.8. Зээлдэгчийн бусад зээлдүүлэгчээс авсан зээл, гуравдагч этгээдийн өмнө хүлээсэн мөнгөн төлбөрийн үүргийн талаарх зээлийн мэдээллийн сангийн мэдээлэл; |
| 4. Фидуцийн гэрээний зүйл нь даатгалд даатгагдсан байх,<br>5. Даатгал нь хүчин төгөлдөр байх тээврийн хэрэгслийн хувьд жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд даатгагдсан байх, хүчин төгөлдөр байх | Авто машины болон, жолоочийн хариуцлагын даатгалын гэрээ |
| 6. Тасалбар болгосон өдрийн байдлаар зээл нь хэвийн төлөлттэй байх | 19.5. Хуулийн этгээд, Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу эрх зүйн байдал нь тодорхойлогдсон этгээд бол орлогын талаарх мэдээлэл, хуульд заасны дагуу татварын байгууллагад тайлагнасан санхүүгийн тайлан;<br>19.6. Зээл хүсэгчийн өр, орлогын харьцаа нотолсон баримт бичиг;<br>19.7. Зээлийн ашиглалтыг шалгасан материал; |
| 7. Эрх зүйн бүрэн чадамжтай, 18 нас хүрсэн Монгол улсын иргэн байх; | 19.1. Зээл олгохыг хүсээн өргөдөл;<br>19.2. Зээлийн гэрээ;<br>19. 7. Зээлийн ашиглалтыг шалгасан материал; |
| 8. Сүүлийн 6 сар тасралтгүй ажил, хөдөлмөр эрхэлсэн байх; | 19.8. Зээлдэгчийн бусад зээлдүүлэгчээс авсан зээл, гуравдагч этгээдийн өмнө хүлээсэн мөнгөн төлбөрийн үүргийн талаарх зээлийн мэдээллийн сангийн мэдээлэл; |
| 9. Зээлдэгчийн тэтгэврийн нас буюу 50 нас хүртэл; | 19.2. Зээлийн гэрээ |

СЗХ
2022 он 09 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 11

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-07
БҮРТГЭВ



Шалгуур тус бүрийн үнэлгээ болон тайлбар баримт, тулган баталгаажуулсан ажлын баримтаар нотлогдоно.

**Зөвлөмж**

"ЛЭНД МН ББСБ" ХК-ээс эх сурвалж бүхий мэдээлэл, баримт бичгүүдийг үндэслэн хийсэн тулган баталгаажуулсан мэдээлэл дээр үндэслэн хийсэн шинжилгээний үр дүнд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна

1. Зээлийн хувийн хэрэг хөтлөлтийн хэрэгжилт сайн, төлбөр хийгдсэн,зээлийн баримтыг бүрэн гүйцэд хадгалж байна.

NISLEL-AUDIT LLC
CERTIFIED ACCOUNTING AUDIT & APPRAISAL

УЛААНБААТАР ХОТ
ЛЭНДМН АКТИВ ТЗК ХХК
9022080569
ХТҮ4977 С688895

РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
RHINOS INVESTMENT UTsK

УЛААНБААТАР ХОТ

## 8.2 ХУУЛИЙН ЗӨВЛӨХИЙН ДҮГНЭЛТ

MDSKhanLex

**“ЛЭНДМН АКТИВ ТЗК” ХХК-ААС ЦАХИМ БОЛОН АВТОМАШИНЫ ФИДУЦИ БҮХИЙ ЗЭЭЛИЙН ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН БАТАЛГААТ ҮНЭТ ЦААС (ХБҮЦ) ГАРГАН НИЙТЭД САНАЛ БОЛГОХТОЙ ХОЛБОГДУУЛАН БЭЛТГЭСЭН ХУУЛЬ ЗҮЙН ДҮГНЭЛТ**

| | |
|---|---|
| Хаана: | **“ЛЭНДМН АКТИВ ТЗК” ХХК-Д** |
| Хаяг: | Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 3-р хороо, Жуулчны, Сувд төв, 2 тоот |
| Утас/Факс: | (976) 77222992 |

| | |
|---|---|
| Хаанаас: | **“ӨМГӨӨЛЛИЙН ЭМ ДИ ЭС ЭНД ХААНЛЕКС” ХХН** |
| Хаяг: | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Сүхбаатарын талбай 2 Сэнтрал Тауэр, 13 давхар, 1301 тоот |
| Утас/Факс: | (976-11) 330048, (976-11) 330049 |

| | |
|---|---|
| Огноо: | 2022 оны 08 дугаар сарын 16-ны өдөр |

СЭХ
2022.09.21 өдөр
БҮРТГЭВ
№ 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-07
БҮРТГЭГДЭВ



MDSKhanLex

2022.08.16 Д-22/214

"ЛЭНДМН АКТИВ ТЗК" ХХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ ТАНАА

**"ЛЭНДМН АКТИВ ТЗК" ХХК-ААС ЦАХИМ БОЛОН АВТОМАШИНЫ ФИДУЦИ БҮХИЙ ЗЭЭЛИЙН ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН БАТАЛГААТ ҮНЭТ ЦААС (ХБҮЦ) ГАРГАН НИЙТЭД САНАЛ БОЛГОХТОЙ ХОЛБОГДУУЛАН БЭЛТГЭСЭН ХУУЛЬ ЗҮЙН ДҮГНЭЛТ**

Тус "Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН нь (цаашид "**МДСХ**" гэх) нь "ЛэндМН Актив ТЗК" ХХК (цаашид "**Компани**", эсхүл "**Үнэт цаас гаргагч**" гэх)-ийн цахим болон автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гарган нийтэд санал болгохтой холбогдуулан энэхүү хууль зүйн дүгнэлт (цаашид "**Дүгнэлт**" гэх)-ийг гаргаж байгаа болно. Энэхүү Дүгнэлт нь тухайлан зориулж гаргасан этгээдүүдээс бусад этгээдийн өмнө ямар нэгэн үүрэг хариуцлага бий болгохгүй. Дүгнэлт нь холбогдох хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэгдсэн бөгөөд аливаа гуравдагч этгээдэд ашигтай байх, эсхүл давуу байдлыг бий болгох мэдээлэл, баталгаа өгөх зорилгогүй болно.

Дүгнэлтийг боловсруулахад ирүүлсэн бүрдүүлбэр материал, баримтуудад агуулагдсан дараах асуудлаар МДСХ нь хариуцлага хүлээхгүй ба Дүгнэлт гаргаагүй болно. Үүнд:

1. Дүгнэлт нь зөвхөн хууль зүйн асуудлаар хийгдсэн бөгөөд аливаа бусад мэдээлэл, түүний дотор тоон мэдээллүүдийн талаар МДСХ нь нарийн мэдлэггүй, тэдгээрийн үнэн зөв байдлыг тогтоохгүй болно;
2. Дүгнэлтэд өөрөөр дурдсанаас бусад тохиолдолд МДСХ-ийн хийсэн ажил энэхүү Дүгнэлтийн тайлбар хэсгийн судалгаа шинжилгээний ажлын хүрээгээр хязгаарлагдаж байгаа болно;
3. Нотариатын гэрчилсэн, улсын бүртгэлд бүртгэгдсэн үйлдэл нь бодит эсэх;
4. Бусад улсын хууль тогтоомж буюу бусад эрх зүйн харьяаллын хүрээнд хийгдсэн, хуульд нийцсэн, хүчин төгөлдөр эсэх;
5. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсэгт "...санхүүгийн мэдээлэл нь үнэн зөв эсэхийг аудитын үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдээр тус тус хянуулж, дүгнэлт гаргуулна" гэж заасны дагуу санхүүгийн мэдээлэл, андеррайтерын судалгаа, дүгнэлт, таамаглал болон нийтэд илэрхий мэдээллийн талаар;
6. Эд хөрөнгө, эдийн бус баялгийн үнэлгээ, хувьцааны үнэ, ханшийн мэдээллийн талаар;
7. Дүгнэлтэд тусгайлан дурдсанаас бусад аливаа судалгаа, шинжилгээ, асуулга хийгдээгүй болно. Тийнхүү хийгдээгүй судалгаа, шинжилгээ, асуулгын үндэс болсон аливаа мэдээлэл, бүртгэл нь бүрэн биш, шинэчлэгдээгүй, жишээ нь, тухайн баримт бичиг нь

УЛААНБААТАР ХОТ
ЛЭНДМН АКТИВ ТЗК ХХК
9022030559

РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ

MDSKhanLex

холбогдох эрх бүхий байгууллагад бүртгэгдээгүй, хувийн хэргээс устсан, алга болсон эсхүл бусад байдлаар архив, хувийн хэрэгт байхгүй болсон байж болно;

8. Компанийн бүх баримт бичиг, гэрээ, төлөвлөгөө, харилцаа холбоо, зөвшөөрөл, хувийн хэрэгтэй танилцсан, тэдгээрийг судалсан гэх амлалтыг МДСХ нь энэхүү Дүгнэлттэй холбоотой гаргахгүй болно;
9. Дүгнэлт боловсруулах үед хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа Монгол Улсын хуулийн хүрээнд хийгдсэн бөгөөд МДСХ нь өөр бусад эрх зүйн тогтолцооны холбоо, хамаарал, нөлөөллийн талаар ямар нэгэн үзэл бодол илэрхийлээгүй болно.

Дор дурдсанаас бусад тохиолдолд бидний бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр энэхүү Дүгнэлтийг ашиглах, ишлэл авах, бусад баримт бичигт оруулан дурдах, бусдад хувилан хүргүүлэхийг хориглоно. Үүнд:

1. "ЛэндМН Актив ТЗК" ХХК-аас цахим болон автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргах (цаашид "Үнэт цаас" эсхүл "ХБҮЦ" гэх)-тай холбогдуулан Компани болон Компанитай гэрээгээр ажиллаж буй нягтлан бодогч, хуульч болон мэргэжлийн зөвлөхүүд;
2. Холбогдох хууль тогтоомжийн дагуу Компанийн мэдээлэл, тайлан гаргаж хүргүүлэх ёстой төрийн болон өөрийгөө зохицуулах байгууллага.

Дүгнэлтийг дээрх хаягласан этгээдэд хүргүүлсэн өдрөөс хойш хууль тогтоомжид өөрчлөлт орсон болон бусад үйл ажиллагаатай холбогдуулан МДСХ нэмэлт хууль зүйн дүгнэлт гаргах үүрэг хүлээхгүй болно.

Мөн Компанийн зүгээс ач холбогдол бүхий баримт, мэдээллийг нуусан, орхигдуулсан, Дүгнэлт гаргах явцад танилцуулаагүй, буруу, дутуу танилцуулсан нөхцөлд үүсэх асуудлаар МДСХ хариуцлага хүлээхгүй.

Энэхүү албан бичиг нь Дүгнэлтийн салшгүй хэсэг байна.

Хүндэтгэсэн,

"ӨМГӨӨЛЛИЙН ЭМ ДИ ЭС ЭНД ХААНЛЕКС" ХХН-ИЙН

ГИШҮҮН, ХУУЛЬЧ

Д.ДҮГЭРЖАВ



УЛААНБААТАР ХОТ
ЛЭНДМН АКТИВ ТЗК ХХК
9022080659
РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2022 .09 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ ...

МОНГОЛЫН ХӨРӨНГ...
MONGOLIAN STOCK E...
2022 -10- 07



**АГУУЛГА**

Удиртгал ........................................................................................................................ 5

Хангагдсанд тооцох нөхцөл........................................................................................... 5

**1. Компани хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдаж бүртгэгдсэн эсэх, Үнэт цаас гаргах шийдвэр нь хууль тогтоомжид нийцсэн эсэх ............................................ 8**

**2. Компанийн дүрэм, үндсэн үйл ажиллагаанд ашиглагдах журам, зааврууд нь хууль тогтоомжид нийцсэн эсэх ..................................................................................... 12**

**3. Баталгаат үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогч этгээдтэй байгуулсан гэрээ болон Компанийн үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой бусад гэрээ, хэлцэл нь хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх, үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дагавар байгаа эсэх ............................................................................................... 15**

**4. Үнэт цаас гаргагч нь үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогч бусад этгээдүүдтэй ашиг сонирхлын зөрчилтэй эсэх.................................................................. 18**

**5. Үнэт цаасны танилцуулга, түүнд тусгагдсан мэдээлэл нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, бусад холбогдох хууль журамд нийцэж буй эсэх, үнэн зөв, хүчин төгөлдөр эсэх .............. 20**

**6. Тухайн компанийн эрхэлдэг үйл ажиллагаатай холбоотойгоор хийсэн хууль зүйн нэмэлт судалгаа шинжилгээ..................................................................................... 22**



УЛААНБААТАР ХОТ
ЛЭНДМН АКТИВ ТЗК ХХК
9022080559
ХТҮ4977 С888896

РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
INVESTMENT
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5163855

СЗХ
2022.09.21 өдөр
БҮРТГЭВ
№

МОНГОЛЫН ХӨРӨ
MONGOLIAN STO
2022-10-07
БҮРТГЭВ





Өмгөөллийн "Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН (цаашид "**МДСХ**", эсхүл "**Бид**" гэх) нь Санхүүгийн Зохицуулах Хороо (цаашид "**СЗХ**" гэх)-ны 2014 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 25 тоот тогтоолоор Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 33.2.1-т заасны Үнэт цаасны зах зээлд хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа эрхлэх этгээдээр анх бүртгэгдсэн бөгөөд СЗХ-ны 2016 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 42 тоот тогтоолоор тус бүртгэлд өөрчлөлт оруулан шинэчлэн бүртгүүлсэн Үнэт цаасны зохицуулалттай этгээд (Хавсралт 1.1)-ийн хувьд энэхүү хууль зүйн үйлчилгээг үзүүлэх эрхтэй болно.

Монгол Улсын хуулийн этгээд болох "ЛэндМН Актив" ХХК (Регистрийн дугаар: 6888895) (цаашид "**Компани**", эсхүл "**Үнэт цаас гаргагч**" гэх) нь цахим болон автомашины зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас (цаашид "**ХБҮЦ**" гэх) гарган нийтэд санал болгох гэж буйтай холбогдуулан Хууль зүйн дүгнэлт гаргахыг Биднээс хүсч, улмаар 2022 оны 07 дугаар сарын 03-ны өдөр "Хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ" (Хавсралт 1.2) байгуулан, тус гэрээний дагуу энэхүү хууль зүйн дүгнэлтийг гаргаж байна.

Дүгнэлтийг зөвхөн Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн үндсэн дээр гаргаж байна. Тус Компани нь Компанийн тухай хуулийн 42 дугаар зүйл (Үнэт цаас гаргах тухай шийдвэр), Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйл (Үнэт цаас), 6 дугаар зүйл (Үнэт цаас гаргах) 7 дугаар зүйл (Үнэт цаас гаргагч), 8 дугаар зүйл (Нийтэд санал болгон үнэт цаас гаргах журам), 9 дүгээр зүйл (Үнэт цаас бүртгэх, нийтэд санал болгохыг зөвшөөрөх), 11 дүгээр зүйл (Үнэт цаасыг нийтэд санал болгох), Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 7 дугаар зүйл (Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах), Монголын хөрөнгийн бирж ТӨХК (цаашид "**МХБ**" гэх)-ийн 2020 оны 02-р сарын 07-ны өдрийн 2020/06 тоот тогтоолоор баталсан "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 2.5.5 дугаар зүйл (Хууль зүйн дүгнэлтийн агуулга), СЗХ-ны 2011 оны 09-р сарын 14-ний өдрийн 266 дугаар тогтоолоор баталсан "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам"-ын 2 дугаар зүйл (Баталгаат үнэт цаасыг бүртгэх шаардлага), 3 дугаар зүйл (Тусгай зориулалтын компанид тавигдах шаардлага), 4 дүгээр зүйл (Үйлчилгээ үзүүлэгчид тавигдах шаардлага)-д зүйлд тус тус заасны дагуу хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гарган СЗХ, МХБ-д бүртгүүлж, нийтэд санал болгон арилжихаар төлөвлөсөн байна.

**Хангагдсанд тооцох нөхцөл**

Энэхүү Дүгнэлтийг боловсруулахдаа Бид дараах нөхцөл хангагдсан гэж үзсэн болно. Үүнд:

1. Дүгнэлт гаргахад ашигласан Үнэт цаасны танилцуулга нь эцсийн хувилбар бөгөөд энэхүү Дүгнэлтийг гаргах үеийн байдлаар СЗХ-нд хүргэгдэж, ХБҮЦ-ны албан ёсны үнэт цаасны танилцуулга болж ашиглагдах;
2. Үнэт цаасны танилцуулгад тусгасан мэдээ, мэдээллийг оруулсан этгээд нь хууль тогтоомж буюу тухайн талын дүрэм, дотоод дүрэм журам, эрх бүхий этгээдтэй байгуулсан гэрээ, эрх бүхий этгээдээс авбал зохих хууль ёсны, хүчин төгөлдөр зөвшөөрөл, итгэмжлэл, эрхийг зохих ёсоор авсны үндсэн дээр үнэт цаасны танилцуулгад мэдээллийг үнэн зөв бүрэн гүйцэт байдлаар тусгасан;
3. Үнэт цаасны танилцуулгад тусгасан нөхцөл иргэдүйд хэрэгжих тохиолдолд тухайн нөхцөл нь хуулийн дагуу, зохих ёсоор, эрхийн болон биет байдлын доголдолгүй хэрэгжих;



УЛААНБААТАР ХОТ
ЛЭНДМН АКТИВ ТЗК ХХК
9022080658
ХТ74977 6888895

РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
RHINOS INVESTMENT UTsK LLC
УЛААНБААТАР ХОТ



УЛААНБААТАР ХОТ

4. Үнэт цаасны танилцуулгыг батлах, бүртгүүлэх үйлдэл нь хуульд нийцсэн, зохих ёсоор, хүчин төгөлдөр байдлаар хийгдэх;
5. Үнэт цаасны танилцуулгад дурдсан санхүүгийн тоо, мэдээ, баримт, үзүүлэлт, тооцоо, тайлан болон бусад үзүүлэлтийг аудитын үйлчилгээ эрхлэх эрх бүхий байгууллага хянан баталгаажуулсан, эдгээр мэдээ мэдээлэл нь үнэн зөв, бүрэн гүйцэт;
6. Үнэт цаасны танилцуулгад тусгасан хөрөнгийн багцад хийсэн судалгаа шинжилгээ үнэн зөв, бүрэн гүйцэт байх;
7. Үнэт цаасны танилцуулгад тусгасан хэлцэл хийх, гэрээ байгуулах, хэлцэл батлах талаарх үйлдэл нь хуульд нийцэж зохих ёсоор, хүчин төгөлдөр байдлаар хийгдэх;
8. Үнэт цаасны танилцуулгад тусгасан талуудын хооронд байгуулагдах гэрээ, хэлцлийг хууль тогтоомжид заасан шаардлагын дагуу зохих ёсоор байгуулах, гэрчлүүлэх, бүртгүүлэх;
9. Үнэт цаасны танилцуулгад тусгасан андеррайтер, аудитор, мэргэжлийн оролцогчдын хийсэн судалгаа, дүгнэлт, санхүүгийн мэдээлэл нь үнэн зөв;
10. Дүгнэлт гаргахад ашигласан гэрээ хэлцлийн төсөл нь эцсийн хувилбар бөгөөд энэхүү Дүгнэлтийг гаргах үеийн байдлаар байгуулагдах;
11. Дүгнэлт гаргахад ашиглагдсан (а) бидэнд ирүүлсэн бүх баримт бичигт дурдсан мэдээлэл үнэн, зөв, бүрэн гүйцэт; (б) тэдгээр баримт бичигт зурагдсан гарын үсэг, дарагдсан тамга, тэмдэг зохих ёсны бөгөөд үнэн зөв; (в) бидэнд ирүүлсэн бичиг баримтуудын хуулбар нь тэдгээрийн эх хувьтай нийцсэн, бүрэн; (г) бидэнд ирүүлсэн бичиг баримтууд нь хамгийн сүүлд батлагдсан хувилбар буюу тэдгээрт өөрчлөлт ороогүй, хүчингүй болоогүй;
12. МДСХ-ээс тавьсан асуулт, тодруулгад Үнэт цаас гаргагч, түүний хувьцаа эзэмшигч, бусад оролцогчоос амаар болон бичгээр өгсөн хариулт, тайлбар, түүнийг нотлох баримт бичиг үнэн зөв;
13. Бидний судлан шинжилсэн бүх баримт бичгийн хуулбар, эсхүл загвар, маягтууд нь үнэн зөв, тэдгээр дээрх аливаа тэмдэглэгээ, гарын үсэг, тамга тэмдэг нь үнэн;
14. Бүх баримт бичгүүд нь тэдгээрийг үйлдсэн талуудын бүрэн эрхийн хүрээнд үйлдэгдсэн;
15. Бидэнд олгогдсон баримт бичгийн дагуу үүсэх аливаа үүрэг нь Монгол Улсаас бусад эрх зүйн тогтолцоонд хүчин төгөлдөр байх ба тэдгээр үүргийн хэрэгжилт хууль бус, хүчин төгөлдөр бус, эсхүл хэрэгжих боломжгүй биш байна;
16. Монгол Улсаас өөр улсад үйлдэгдсэн аливаа баримт бичиг нь тийнхүү үйлдэгдсэн улсын хуулийн шаардлагыг хэлбэрийн болон агуулгын хувьд бүрэн хангасан, хүчин төгөлдөр баримт бичиг ба тэдгээрийн хэрэгжилт нь тийнхүү хэрэгжих улсын хуулийн шаардлагыг мөн хангасан;
17. Компани, түүний албан тушаалтан, ажилтнуудаас аливаа хэлбэрээр хүлээн авсан аливаа мэдээлэл нь үнэн зөв, бодитой;
18. Шүүх, төрийн эрх бүхий байгууллагаас авсан мэдээлэл, баримт бичиг нь үнэн зөв;
19. Бидний судалж ашигласан бичиг баримтыг бэлтгэсэн болон түүнд гарын үсэг зурсан этгээд нь тийнхүү уг баримт бичгийг бэлтгэх, гарын үсэг зурах бүрэн эрхтэй;

Энэхүү ХБҮЦ-ны бүртгэл болон арилжаа нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10.6, 10.7, СЗХ-ны 2011 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн 266 тоот тогтоолоор батлагдсан "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам", Хууль зүйн сайд, СЗХ-ны даргын хамтарсан 2013 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн А/167/203 тоот тушаалаар батлагдсан "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хөрөнгийн багцыг тусгай тэмдэглэл хийж бүртгэх тухай журам", МХБ-ийн ТУЗ-ийн 2020 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 2020/06 тоот тогтоолоор батлагдсан "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам" болон МХБ-ийн ТУЗ-ийн 2012 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 02 тоот тогтоолоор батлагдсан "МХБ-ийн Арилжааны журам"-д заасны дагуу явагдана гэж үзлээ.

СЗХ-ноос хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тусгай зөвшөөрөл олгохоос өмнө "ЛэндМН актив" ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрүүд нь тусгай зориулалтын компанийн хувьд хүчин төгөлдөр мөрдөгдөх бөгөөд компанийн нэр уг хугацаанаас өмнө ба дараа өөрөөр туссан болохыг анхаарна уу.

Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн үнэт цаасны танилцуулга, бусад холбогдох мэдээллүүдийг үндэслэн Дүгнэлт гаргах өдрийн байдлаар хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн дор дурдсан Дүгнэлтийг гаргаж байна:

"ЛэндМН актив" ХХК нь "ЛэндМН ББСБ" ХК-ийн 2022 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 22/17 тоот Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол (Хавсралт 1.3), "ЛэндМН актив" ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 2022 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 22/01 тоот шийдвэр (Хавсралт 1.4)-ийн үндсэн дээр Мэдээлэл технологийн үйл ажиллагаа явуулахаар байгуулагдаж, 2022 оны 07 дугаар сарын 03-ны өдөр Улсын бүртгэлд бүртгүүлсэн (Хавсралт 1.5, 1.6) байна. "ЛэндМН ББСБ" ХК-ийн 2022 оны 06-р сарын 16-ны өдрийн 22/17 тоот Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолоор "ЛэндМН ББСБ" ХК нь өөрийн 100 хувийн охин компани болох "ЛэндМН Актив" ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлэх бүрэн эрхийг Гүйцэтгэх захирал Б.Удвалд олгосон (Хавсралт 1.3), мөн Үнэт цаас гаргагчийн дүрмийн 4.1-т "Компанийн хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхийг толгой компанийн Гүйцэтгэх захирал хэрэгжүүлнэ" (Хавсралт 1.11, 2.1) гэж заасан. Иймхүү дүгнэлт гаргах өдрийн байдлаар уг "ЛэндМН ББСБ" ХК-ийн албан тушаалыг Б.Удвал хашиж байгаагийн хувьд Үнэт цаас гаргагчийн Хувьцаа эзэмшигчийн хурлын шийдвэрт Б.Удвал гарын үсэг зурсан байна.

"ЛэндМН Актив" ХХК нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлөө уг үнэт цаасаа бүртгүүлэхийн өмнө СЗХ-ноос авахаар төлөвлөж, 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 22/02 тоот "ЛэндМН Актив" ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тухай шийдвэрт үндэслэн (Хавсралт 1.7), холбогдох материалаа СЗХ-нд хүргүүлсэн. СЗХ-ны 2022 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай" 415 дугаар тогтоолоор Компани нь СЗХ-ноос хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл (Хавсралт 1.8, 1.9)-ийг авч "ЛэндМН Актив ТЗК" ХХК болж, оноосон нэр, эрхлэх үйл ажиллагааны төрөлд өөрчлөлт оруулан дүрмээ улсын бүртгэлд бүртгүүлсэн байна (Хавсралт 1.10, 2.1).

**Компанийн тухай мэдээлэл:**

*Улсын бүртгэлийн гэрчилгээ дугаар*: 000259538
*Улсын бүртгэлийн дугаар:* 9011841085;
*Регистрийн дугаар*: 6888895;
*Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр:* "ЛэндМН Актив ТЗК" Хязгаарлагдмал хариуцлагатай компани;
*Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл:* Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх;
*Хугацаа:* Хугацаагүй;
*Хувьцаа эзэмшигчдийн тоо:* 1;

| № | Хувьцаа эзэмшигчийн нэр | Гаргасан хувьцаа | | | Хувь нийлүүлсэн хөрөнгөд эзлэх хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Тоо ширхэг | Нэрлэсэн үнэ | | |
| | | | Нэг бүрийн үнэ | Бүгд | |

СЗХ
2022 .10 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨ...
MONGOLIAN S...
2022 -10- 07
БҮРТГ... 02





| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 1. | "ЛэндМН ББСБ" ХК | 80 | 1,000,000 | 80,000,000 | 100% |

*Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ:* 80,000,000 төгрөг;
*Хуулийн этгээдийн албан ёсны хаяг:* Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 3-р хороо, Жуулчны гудамж-34, Сувд төв 2 тоот;
*Гүйцэтгэх захирал:* Б.Оюунболд

**Компани үүсгэн байгуулагчийн тухай мэдээлэл:**

*Улсын бүртгэлийн гэрчилгээ дугаар:* 000166216
*Улсын бүртгэлийн дугаар:* 9010002001;
*Регистрийн дугаар:* 5039754;
*Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр:* "ЛэндМН ББСБ" Хувьцаат компани (Хавсралт 1.12);
*Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ:* СЗХ-ны 2015 оны 06-р сарын 24-ний өдрийн 293 тоот тогтоолын дагуу ТЗ 101/493 дугаар бүхий ББСБ-ын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй (Хавсралт 1.14)
*Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл:* Зээл, Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах, Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ, Факторингийн үйлчилгээ, Итгэлцлийн үйлчилгээ, Гадаад валютын арилжаа, Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл огох (Хавсралт 1.13, 1.14);
*Хугацаа:* Хугацаагүй;

ТЗК үүсгэн байгуулах этгээд нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.4 дэх хэсэгт зааснаар банк, банк бус санхүүгийн байгууллага, орон сууцны санхүүжилтийн компани болон СЗХ-ноос зөвшөөрсөн санхүүгийн бусад байгууллага байж болно. Компанийг үүсгэн байгуулагч нь "ЛэндМН ББСБ" ХК буюу "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай" хуулийн 10.1.1, 15.3.1, "Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай" хуулийн 6.1, 9.1-д тус тус заасны дагуу СЗХ-ны 2015 оны 06-р сарын 24-ний өдрийн 293 тоот тогтоол (Хавсралт 1.14)-оор Банк бус санхүүгийн байгууллагын зээлийн үйл ажиллагаа эрхлэх, 2018 оны 05-р сарын 23-ны өдрийн 193 тоот тогтоолоор төлбөр тооцооны хэрэгсэл гаргах, цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлэх, 2019 оны 03-р сарын 20-ны өдрийн 45 дугаар тогтоолоор факторинг, итгэлцлийн үйлчилгээ үзүүлэх, 2019 оны 05-р сарын 23-ны өдрийн 128 дугаар тогтоолоор гадаад валютын арилжаа эрхлэх, 2020 оны 03-р сарын 11-ний өдрийн 107 дугаар тогтоолоор хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа явуулж байна. Түүнчлэн Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 22900002002626 тоот лавлагаа (Хавсралт 7.1)-наас үзвэл "ЛэндМН ББСБ" ХК нь татан буугдсан, дампуурсан талаарх тэмдэглэлгүй ба Дүгнэлт гаргах өдрийн байдлаар идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа, эрх зүйн чадвар, чадамжтай хуулийн этгээд тул "ЛэндМН ББСБ" ХК нь тусгай зориулалтын компани үүсгэн байгуулах эрх бүхий этгээд болно.

Иймд, энэхүү улсын бүртгэлийн гэрчилгээ (Гэрчилгээний дугаар 000259538, Улсын бүртгэлийн дугаар 9011841085, Регистрийн дугаар 688895) бүхий "ЛэндМН Актив ТЗК" ХХК нь Монгол улсын хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдаж бүртгэгдсэн байна.



УЛААНБААТАР ХОТ
ЛЭНДМН АКТИВ ТЗК ХХК
ФАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
INVESTMENT UTsK

***Үнэт цаас гаргах шийдвэрийн тухай:***

СЗХ-ны журмын 2.9.11 дэх хэсэгт заасны дагуу зээлийн шинжилгээ хийж, 2022 оны 07 дугаар сарын 07-ны өдөр "Нийслэл Аудит" ХХК-аас гаргасан "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргахтай холбоотой зээлийн баталгаажуулалтын ажлын тайлан" болон "Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН-ийн 2022 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн "цахим болон автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас олон нийтэд нээлттэй санал болгох хүрээнд сонгогдсон зээлийн дансдын хуулийн шалгуур үзүүлэлтэд нийцсэн эсэх талаарх хуулийн хөндлөнгийн дүн шинжилгээний тайлан"-г тус тус үндэслэн дээрх Хөрөнгийн багцыг Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 9 дүгээр зүйл, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тухай 2022 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 22/07 тоот тогтоол (Хавсралт 1.15)-ын 1, 2, 3 дугаар хавсралтаар баталсан "Хөрөнгийн багцын шалгуур үзүүлэлт"-ийг хангасан болохыг баталгаажуулсан.

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон Үнэт цаас гаргагч нарын хооронд 2022 оны 08 дугаар сарын 16-ны өдөр байгуулсан Г/2022/05 тоот Хөрөнгө худалдах худалдан авах гэрээ (Хавсралт 3.1)-ний дагуу "ЛэндМН ББСБ" ХК-ийн багцалсан зээлийн хөрөнгийг Үнэт цаас гаргагчид шилжүүлэхээр тохиролцож, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тухай шийдвэр гаргасан байна.

***Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах шийдвэрийн тухай:***

Компанийн хувьцаа эзэмшигч "ЛэндМН ББСБ" ХК-ийн 2022 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 22/17 тоот ТУЗ-ийн тогтоол (Хавсралт 1.3)-ын дагуу Компанийн хувьцаа эзэмшигчийн ТУЗ нь ТЗК байгуулж, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргахаар шийдвэрлэсэн байна. Түүнчлэн СЗХ-ны 2022 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн 415 дугаар тогтоолоор ТЗ 315/47 тоот тусгай зөвшөөрөл (Хавсралт 1.8, 1.9) олгосныг үндэслэн Компанийн ТУЗ-ийн 2022 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн 22/15 дугаар Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргах тухай тогтоол (Хавсралт 1.10)-оор Компани Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 10 дугаар зүйлд заасны дагуу цахим болон автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас (цаашид "Үнэт цаас" гэх)-ыг дараах нөхцөлтэйгээр гаргахаар шийдвэрлэсэн. Үүнд:

| | |
|---|---|
| Үнэт цаасны төрөл | Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас |
| Анхны үүрэг гүйцэтгүүлэгч | "ЛэндМН ББСБ" ХК (MO:LEND) |
| Олон нийтэд санал болгох нийт дүн | 8,000,000,000 (найман тэрбум) төгрөг |
| Үнэт цаасны нэрлэсэн үнэ | 100,000 (нэг зуун мянга) төгрөг |
| Тоо ширхэг | 80,000 (наян мянга) ширхэг |
| Хүү | Жилийн 17% (арван долоон хувь) |
| Хугацаа | 2 (хоёр) жил буюу 24 (хорин дөрөв) сар |
| Хүү төлөх хугацаа, давтамж | Сар бүрийн 10-ны өдрийн дотор<br>(ТЗК нь ХБҮЦ гаргасан сарын хүүгийн төлбөр буюу эхний удаагийн хүүгийн төлбөрийг хуримтлуулан тооцож, ХБҮЦ-ны 2 дахь удаагийн хүүгийн төлбөртэй хамтад нь төлнө) |

| | |
|---|---|
| Эргэн төлөх нөхцөл | Хугацааны эцэст бүтнээр |
| Үндсэн төлбөр төлөх эх үүсвэр | Зээлийн багцын үндсэн болон хүүгийн төлбөрийн орлого |
| Үнэт цаасыг баталгаажуулж буй хөрөнгийн багц (зээлийн багц) | Компанийн ТУЗ-өөс баталсан шаардлагыг хангасан бөгөөд Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээнд заасан жагсаалтын дагуу шилжүүлэн авах 8,000,000,000 (найман тэрбум) төгрөгийн үнийн дүн бүхий хөрөнгийн багц (зээлийн багц) |
| Үнэт цаасыг баталгаажуулж буй хөрөнгийн багц (зээлийн багц)-ын чанар | 100 хувь хэвийн зээл |
| Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт | Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн зээлийн эх үүсвэрт |
| Үнэт цаасны хадгалалт | Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв |
| Анхдагч зах зээлийн захиалга | Андеррайтер төвтэй |
| Арилжаа эрхлэх байгууллага | Монголын Хөрөнгийн Бирж |

Энэхүү тогтоол нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйл, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журмын холбогдох зүйл заалтад нийцсэн байна.

Нэгтгэн дүгнэвэл, Үнэт цаас гаргагчийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргах тухай шийдвэр нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.



УЛААНБААТАР ХОТ ЛЭНДМН АКТИВ ТЗК ХХК 9072000559

РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК RHINOS INVESTMENT UTsK LLC

УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2022 он 09 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01



***"ЛэндМН актив ТЗК" ХХК-ийн дүрэм.*** Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 22/04 тоот шийдвэр (Хавсралт 1.11)-ийн хавсралтаар Дүрмийн төсөл, Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 2022 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн 22/05 дугаар шийдвэр (Хавсралт 2.1)-ийн хавсралтаар тус тус "ЛэндМН актив ТЗК" ХХК-ийн дүрмийг баталсан байна. Энэхүү дүрэм нь нийт 8 бүлэгтэй бөгөөд Компанийн оноосон нэр, оршин байгаа хаяг, Компанийн зорилго, үйл ажиллагааны үндсэн чиглэл, Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө, гаргасан, зарласан хувьцаа, Компанийн үндсэн эрх, үүрэг, хариуцлага, хувьцаа эзэмшигч, хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл, түүний гишүүдийн тоо, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гүйцэтгэх удирдлага, тэдний эрх, үүрэг хариуцлагыг тодорхойлж, Компанийн санхүүгийн үйл ажиллагаа, Компанийг татан буулгах, Компанийн дүрэм хүчин төгөлдөр болохтой холбогдсон харилцааг зохицуулсан байна. СЗХ-оос 2022 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн 415 тоот тогтоол (Хавсралт 1.8)-оор хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Компанид олгосноор (Хавсралт 1.11) дүрэм нь хүчин төгөлдөр мөрдөгдөх үндэслэл бий болж, 2022 оны 08 дугаар сарын 14-ний өдөр улсын бүртгэлд бүртгэгдсэн байна (Хавсралт 1.10). Энэхүү дүрэмд Компанийн оноосон нэрэнд "ТЗК" болохыг болон хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэхээр тусгасан нь Компанийн тухай хуулийн 16 дугаар зүйл, 17 дугаар зүйлийн 17.9 болон Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.9, 12.11, 12.12 дугаар зүйлүүд болон бусад холбогдох зохицуулалтад нийцсэн байна.

*Компанийн дотоод үйл ажиллагааны журмууд:*

***ТУЗ-ийн үйл ажиллагааны журам.*** Компанийн ТУЗ-ийн 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 22/03 тоот тогтоол (Хавсралт 2.2)-ын хавсралтаар Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам (Хавсралт 2.3)-ыг баталсан байна. Журмаар нийтлэг үндэслэл, төлөөлөн удирдах зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, ТУЗ-ийн бүрэн эрх, зохион байгуулалт, ТУЗ-ийн дарга, гишүүдийг сонгох, бүрдүүлэх баримт бичиг, бүрэн эрхийн хугацаа, бүрэн эрхийг хугацаанаас өмнө дуусгавар болгох үндэслэл, ТУЗ-ийн энгийн болон хараат бус гишүүний эрх үүрэг, ТУЗ-ийн зохион байгуулалт, ажиллах нөхцөл, хангамж, ТУЗ-ийн хурал, хариуцлагатай холбоотой харилцааг зохицуулсан байна. ТУЗ-ийн үйл ажиллагааны журам нь Компанийн тухай хуулийн 76.1, 80.1, 80.5, 80.6, 80.9, 82 дугаар зүйл, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.8, СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журмын 3.12-3.16 дахь хэсэг холбогдох шаардлагыг тус тус хангасан байхаас гадна болон Компанийн дүрэмд нийцсэн байна.

***Хөндлөнгийн аудитор, үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгох, солих тухай журам.*** Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 22/04 тоот тогтоол (Хавсралт 2.4)-ын 1 дүгээр хавсралтаар Хөндлөнгийн аудитор, үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгох, солих тухай журам (Хавсралт 2.5)-ыг баталжээ. Энэхүү журам нь нийт 8 бүлэгтэй бөгөөд хөндлөнгийн аудитор, үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагчид тавигдах шаардлага, тэдгээрийг сонгох, гэрээ байгуулах, хөндлөнгийн аудитор, үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагчийг солихтой холбогдсон харилцааг зохицуулсан байна. Уг журам нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 33.2 дахь хэсэг, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.11.4, 19.1, 19.8,



УЛААНБААТАР ХОТ
ЛЭНДМН АКТИВ ТЗК ХХК

19.10, 20.1, 20.3, 40.1, дэх хэсэг, СЗХ-ноос баталсан Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журмын 4.1, 4.2. 4.3, 4.4, 8.1 дэх хэсэг, Монголын хөрөнгийн биржээс баталсан Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 9.4 дэх хэсэг болон бусад холбогдох зохицуулалттай нийцсэн байна.

***Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргэх журам.*** Компанийн хөрөнгө оруулагч, үнэт цаас эзэмшигчид Компанийн үйл ажиллагааны талаар болон хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг тогтмол хүргэх, уг мэдээллийн төрөл, хэлбэр, давтамж, мэдээллийн ил тод байдлыг хангах, нийтэд хүргэх, нэгдсэн нэг мэдээллийн урсгалтай байх, түүнийг хэрэгжүүлэх, хяналт тавих зорилгоор нийт 4 бүлэг бүхий зохицуулалттай энэхүү журам (Хавсралт 2.7)-ыг ТУЗ-ийн 2022 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн 22/11 тоот тогтоол (Хавсралт 2.6)-ын 3 дугаар хавсралтаар баталсан байна. Энэхүү журмаар Компанийн хугацаат тайланг нийтэд мэдээлэх, тогтмол мэдээлэх, тухай бүр нэлттэй мэдээлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх, мэдээллийг үнэт цаас эзэмшигчид хүргэхэд баримтлах зарчмыг тодорхойлж, мэдээллийг хадгалах, архивлахтай холбогдсон харилцааг зохицуулсан байна. Компанийн тухай хуулийн 98 дугаар зүйл, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20.1, 79.1 дэх хэсэг, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20.2.3, 39 дүгээр зүйл, СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журмын 3.14.5, 3.19, 3.21, 3.22, 3.23, 3.24 дэх хэсэг, Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам, Үнэт цаас гаргагчаас мэдээллийг нийтэд тогтмол хүргэх тухай журам, Монголын Хөрөнгийн Биржийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 9.5-9.7 дах хэсэгт заасан шаардлагыг хангасан байна.

***Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх тухай журам.*** Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн 22/11 тоот тогтоол (Хавсралт 2.6)-ын 4 дүгээр хавсралтаар Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх тухай журам (Хавсралт 2.8)-ыг баталжээ. Журмаар ТЗК-ийн гаргах хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны төлбөрийг Зээлдэгчид болон Үйлчилгээ үзүүлэгчдээс цуглуулах, цуглуулсан төлбөрөөр үнэт цаас эзэмшигчдэд үнэт цаасны төлбөр төлөхтэй холбогдсон Компанийн үйл ажиллагаа болон Компанийн Үйлчилгээ үзүүлэгч, Хөрөнгө итгэмжлэн удирдагч болон бусад холбогдох этгээдүүдийн үйл ажиллагаа, хариуцлагатай холбоотой харилцааг зохицуулсан байна. Журам нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцсэн байна.

***Эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын журам.*** Компанийн ТУЗ-ийн 2022 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн 22/11 тоот тогтоол (Хавсралт 2.6)-ын 5 дугаар хавсралтаар энэхүү журам (Хавсралт 2.9)-ыг баталсан байна. Журмаар нийтлэг үндэслэл, эрсдэлийн ангилал, эрсдэлийг удирдах арга хэмжээ, эргэн төлөлтийг сайжруулах, журам зөрчсөн ажилтанд хариуцлага тооцохтой холбоотой харилцааг зохицуулсан байна. Журам нь холбогдох хууль тогтоомжийн зөрчилгүй байна.

***Хөрөнгийн багцад өөрчлөлт оруулах журам.*** Компанийн ТУЗ-ийн 2022 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн 22/11 тоот тогтоол (Хавсралт 2.6)-ын 2 дугаар хавсралтаар энэхүү журам (Хавсралт 2.10)-ыг баталсан байна. Журмаар нийтлэг үндэслэл, хөрөнгийн багцад өөрчлөлт



СЗХ 2022 он 09 сар 21 өдөр БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГ... MONGOLIAN STO... 2022-10-07
УЛААНБААТАР ХОТ ЛЭНДМН АКТИВ ТЭК ХХК
РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2022 .09 сар 21 . өдөр
БҮРТГЭВ
№ 01



МОНГОЛЫН ... ЧИРЭЖ
MONGOLIAN ... NGE
2022 -09- 07
БҮРТ...ЭВ -02



оруулах, хөрөнгийн багцад өөрчлөлт оруулах дараалал, үндэслэлийг тодорхойлж, журмыг зөрчсөн тохиолдолд хариуцлага тооцохтой холбоотой харилцааг зохицуулсан байна. Журам нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 9 дүгээр зүйл, 15 дугаар зүйл, СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журмын 3.18 болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцсэн байна.

***Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам.*** Компанийн ТУЗ-ийн 2022 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн 22/11 тоот тогтоол (Хавсралт 2.6)-ын 1 дүгээр хавсралтаар энэхүү журам (Хавсралт 2.11)-ыг баталсан байна. Журмаар мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, холбогдох хууль тогтоомж, зохицуулалтын байгууллагаас баталсан дүрэм, журам, стандартуудыг дагаж мөрдөх, үүсэж болох эрсдэлээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон харилцааг зохицуулсан байна. Журам нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, СЗХ-ны 2019 оны 01-р сарын 21-ний өдрийн А-26 дугаар тушаалаар баталсан Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журамд нийцсэн байна.

Компанийн ТУЗ нь Компанийн үйл ажиллагааны журмуудыг Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13, 76.1.18 дахь хэсэг, ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын 3 дугаар зүйлийн 3.3-т заасан бүрэн эрхийн хүрээнд баталсан, ТУЗ-ийн хурал нь Компанийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.5-д заасны дагуу хүчин төгөлдөр байх ба ТУЗ-ийн тогтоол нь Компанийн тухай хуулийн 80.6-д заасны саналын эрхийн хэмжээнд хүрсэн байх тул дээр дурдсан журмуудыг баталсан ТУЗ-ийн 2022 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн 22/11 тоот тогтоол (Хавсралт 2.6), ТУЗ-ийн 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 22/04 тоот тогтоол (Хавсралт 2.2) тус бүр нь хуулийн хүчин төгөлдөр байна. Түүнчлэн 22/11 тоот тогтоолын 2 дугаар зүйлд "энэхүү тогтоол нь компанийн эрх залгамжлагчийн хувьд хүчин төгөлдөр мөрдөгдөх учрыг дурдсугай" гэж заасны дагуу "ЛэндМН Актив" ХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан дүрэм, журам нь "ЛэндМН Актив ТЗК" ХХК-д нэгэн адил хүчин төгөлдөр үйлчлэхээр зохицуулсан байна.

Дээр дурдсан Компанийн дүрэм, журмууд нь хуулийн хүчин төгөлдөр, хууль тогтоомжид нийцсэн байна.



УЛААНБААТАР ХОТ
ЛЭНДМН АКТИВ ТЗК ХХК
РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
RHINOS INVESTMENT UTsK
УЛААНБААТАР ХОТ

Бид тус Компаниас ирүүлсэн Компанийн үйл ажиллагаанд голлох ач холбогдол бүхий дор дурдсан гэрээг хянасан болно.

*Үндсэн үйл ажиллагаатай холбоотой гэрээний тосгууд:*

***Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ.*** Компанийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргахтай холбоотой "ЛэндМН ББСБ" ХК, "ЛэндМН Актив ТЗК" ХХК нарын хооронд 2022 оны 08-р сарын 16-ны өдөр Г/2022/05 тоот "Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ" (Хавсралт 3.1) байгуулагдсан байна. Тус гэрээ нь нийт 14 бүлгээс бүрдсэн бөгөөд тус гэрээний дагуу Үнэт цаас гаргагч нь зээлийн багц хөрөнгө болон түүнд холбогдох эрхийг худалдан авч, гэрээнд заасан үнийг төлөх, анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь хөрөнгийн багцыг худалдах, зээлийн хөрөнгийг солихтой холбоотой харилцааг зохицуулж байна. Энэхүү гэрээ нь Иргэний хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.

***Төлбөр цуглуулах, үйлчилгээ үзүүлэх гэрээ.*** Компанийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргахтай холбоотой "ЛэндМН Актив ТЗК" ХХК, "ЛэндМН ББСБ" ХК, "Юнайтед Айр Файнэнс" ХХК нарын хооронд 2022 оны 08-р сарын 16-ны өдөр Г/2022/07 тоот "Төлбөр цуглуулах, үйлчилгээ үзүүлэх гэрээ" (Хавсралт 3.2) байгуулагдсан байна. Тус гэрээ нь нийт 9 бүлгээс бүрдсэн бөгөөд тус гэрээний дагуу Үйлчилгээ үзүүлэгч нь Үнэт цаас гаргагчаас гаргах хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны төлбөрийг цаг хугацаанд нь цуглуулан, шилжүүлэх, бүртгэлийг хөтлөх, тайлагнах, зээлд хяналт тавьж, зээл төлүүлэх ажиллагаа явуулах, Хөрөнгө итгэмжлэн удирдагчаас төлбөр цуглуулах үйл ажиллагаанд хяналт тавих, Үнэт цаас гаргагч нь үйлчилгээний төлбөрийг төлөхтэй холбогдох харилцааг зохицуулсан байна. Энэхүү гэрээ нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.

***Барьцааны гэрээ.*** "ЛэндМН Актив ТЗК" ХХК, "ЛэндМН ББСБ" ХК нарын хооронд 2022 оны 08-р сарын 16-ны өдөр Г/2022/04 тоот "Барьцааны гэрээ" (Хавсралт 3.3) байгуулагдсан байна. Тус гэрээ нь нийт 8 бүлгээс бүрдсэн бөгөөд тус гэрээгээр Хөрөнгө худалдах худалдан авах гэрээний дагуу шилжүүлэх Хөрөнгийн багц, уг багцад буй автомашины зээлийн хөрөнгө, цахим хэрэглээний зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны эргэн төлөлтийн үүргийн гүйцэтгэлийг хангуулах зорилгоор фидуцийн зүйлийн өмчлөх эрх, цахим зээлийн эрхийг барьцаалагчид барьцаалуулахтай холбоотой харилцааг зохицуулсан байна. Энэхүү гэрээ нь Иргэний хууль, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.

***Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ.*** "ЛэндМН Актив ТЗК" ХХК, "Юнайтед Айр Файнэнс" ХХК нарын хооронд 08-р сарын 16-ны Г/2022/06 тоот "Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ" (Хавсралт 3.4) байгуулагдсан байна. Тус гэрээ нь гэрээний тусгай нөхцөл, гэрээний ерөнхий нөхцөл, хавсралтаас бүрдсэн байна. Гэрээний дагуу Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т заасан үйлчилгээ үзүүлэх буюу Үнэт цаас гаргагчийн Хөрөнгийн багцыг итгэмжлэн удирдах, Үнэт цаас эзэмшигчдэд



УЛААНБААТАР ХОТ
ЛЭНДМН АКТИВ ТЗК ХХК
9022020559
РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
RHINOS INVESTMENT UTsK LLC
УЛААНБААТАР ХОТ

төлбөр төлөх, Үнэт цаас гаргагч нь Хөрөнгө итгэмжлэн удирдагчид үйлчилгээний хөлс төлөх холбоотой харилцааг зохицуулсан байна. Энэхүү гэрээ нь Иргэний хууль, СЗХ-ны "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам"-ын 4.9 дүгээр зүйлд заасан мэдээллийг тусгасан, холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна. Хөрөнгө итгэмжлэн удирдагч "Юнайтед Айр Файнэнс" ХХК нь СЗХ-ны 2021 оны 10 сарын 28-ны өдрийн 473 дугаар тогтоолын дагуу ТЗ 316/18 тоот үнэт цаасны зах зээлд хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөлтэй тул зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа явуулах эрх бүхий этгээд байна.

***Зээлийн эргэн төлөлтийн дансны барьцааны гэрээ.*** Компанийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргахтай холбоотой "ЛэндМН Актив ТЗК" ХХК, "ЛэндМН ББСБ" ХК, "Юнайтед Айр Файнэнс" ХХК нарын хооронд 2022 оны 08-р сарын 16-ны өдөр Г/2022/09 тоот "Зээлийн эргэн төлөлтийн дансны барьцааны гэрээ" (Хавсралт 3.5) байгуулагдсан байна. Тус гэрээ нь нийт 13 бүлгээс бүрдсэн бөгөөд тус гэрээний дагуу Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь үйлчилгээ үзүүлэгчийн нэр дээр банканд нээлгэсэн зээлийн эргэн төлөлтийн мөнгөн хөрөнгийг цуглуулах данс дахь Үнэт цаас гаргагчийн өмчлөлийн мөнгөн хөрөнгийг барьцаалах, түүний захиран зарцуулалтыг хязгаарлахтай холбоотой харилцааг зохицуулж байна. Энэхүү гэрээ нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.

***Захиргааны үйлчилгээ үзүүлэх гэрээ.*** Компанийн ХЭХ, ТУЗ-ийн хурлын бэлтгэлийг хангах, албан бичиг хэргийн ажил гүйцэтгэх, Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай хамтран нягтлан бодох бүртгэл хөтлөх, ТЗК-ийн мөнгөн хөрөнгөөс шаардлагатай мөнгөн гүйлгээг ХИУ-ийн хяналт доор хамтран гүйцэтгэх, хүүгийн орлогын албан татвар төлөх, компанийн цахим хуудас хөтлөх зэрэг Үнэт цаас гаргагчийн өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулахтай холбоотойгоор Г/2022/08 тоот "Захиргааны үйлчилгээ үзүүлэх гэрээ" (Хавсралт 3.6)-г Үнэт цаас гаргагч нь "ЛэндМН ББСБ" ХК-тай 2022 оны 08-р сарын 16-ны өдөр байгуулсан байна. Гэрээ нь нийтлэг үндэслэл, үзүүлэх үйлчилгээ, үйлчилгээний хөлс, баталгаа, мэдэгдэл, гэрээ дуусгавар болох, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл, нууц мэдээлэл, маргаан шийдвэрлэх, бусад зүйл гэсэн 9 бүлэг бүхий зохицуулалттай байна. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.12.5-д заасны дагуу Тусгай зориулалтын компани нь хөдөлмөрийн гэрээ болон бусад гэрээний үндсэн дээр ажилтан авч ажиллуулахыг хориглодог тул компанийн захиргааны шинжтэй ажлуудыг бие даасан хуулийн этгээдээр гүйцэтгүүлэхээр тохиролцсон энэхүү гэрээ нь хуулийн хүчин төгөлдөр байна.

*Үнэт цаас гаргахтай холбоотойгоор байгуулсан гэрээнүүд:*

***Хөндлөнгийн аудитор.*** Үнэт цаас гаргагчийн 2022 оны санхүүгийн тайланд аудитын шалгалт хийж, дүгнэлт гаргах ажлыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд (СТОУС) болон Аудитын тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн актыг удирдлага болгон гүйцэтгүүлэхээр Компанийн ТУЗ-ийн 2022 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн 22/13 тоот тогтоолоор хөндлөнгийн аудитоор "Нийслэл аудит" ХХК-г сонгохоор (Хавсралт 3.7) шийдвэрлэсэн байна.

***Санхүүгийн шинжилгээний аудитын гэрээ.*** Сонгогдсон зээлийн дансдууд санхүүгийн шалгуур үзүүлэлт хангасан эсэх талаарх дүгнэлт гаргуулахаар "Нийслэл аудит" ХХК-тай Санхүүгийн шинжилгээний аудитын гэрээ (Хавсралт 3.8)-г 2022 оны 06-р сарын 22-ны өдөр байгуулсан



УЛААНБААТАР ХОТ
ЛЭНДМН АКТИВ ТЗК ХХК
9022080559
РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК

байна. Энэхүү гэрээгээр ажлын хамрах хүрээ, зээлийн шалгуур, цаг хугацаа болон үйлчилгээний хөлс, талуудын эрх, үүрэг, хариуцлага, нууцлал харилцааг зохицуулсан байна. Гэрээ нь Аудитын тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 40.1, СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журмын 8.2 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна. "Нийслэл Аудит" ХХК нь үнэт цаасны зохицуулалттай этгээдэд аудитын үйлчилгээ үзүүлэх эрх олгогдсон этгээд байна.

***Андеррайтер болон зөвлөх үйлчилгээний гэрээ.*** Үнэт цаас гаргагчийн нийтэд нээлттэй хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах ажлыг зохион байгуулах, мэргэжлийн андеррайтераар ажиллуулахаар "Райнос инвестмент ҮЦК" ХХК болон "Өлзий энд Ко Капитал ҮЦК" ХХК-тай Г/22/01 тоот "Андеррайтер болон зөвлөх үйлчилгээний гэрээ" (Хавсралт 3.9)-г 2022 оны 07 сарын 08-ны өдөр байгуулсан байна. Гэрээ нь нийтлэг үндэслэл, андеррайтерийн үйлчилгээний цар хүрээ, гэрээний хугацаа, үйлчилгээний төлбөр, талуудын эрх, үүрэг, дотоод мэдээлэл эзэмшигч, түүний үүрэг, хариуцлага, маргаан шийдвэрлэх, бусад гэсэн 8 бүлэг бүхий зохицуулалттай байна. Энэхүү гэрээгээр андеррайтер нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 41.4.1-т заасан үнэт цаасны танилцуулга бэлтгэх, 41.4.3-т заасан хөрөнгө оруулагчид тухайн үнэт цаасыг танилцуулах замаар түүнийг худалдахад шаардлагатай бүх хүчин чармайлт гаргахаар тохиролцсон байна. Гэрээ нь Иргэний хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцсэн байна. Андеррайтер нь үнэт цаасны зах зээлд андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл (Хавсралт 3.9)-тэй тул тус гэрээг байгуулах эрх бүхий этгээд болно.

***Зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ*** (Хавсралт 3.10) Үнэт цаас гаргагчийн нийтэд нээлттэй хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах ажилд үнэт цаасны танилцуулга материалыг мэргэжлийн өндөр түвшинд хийж гүйцэтгэхээр "Райнос инвестмент ҮЦК" ХХК-тай RA22/02 тоот Зөвлөх үйлчилгээний гэрээг 2022 оны 07 дугаар сарын 08-ны өдөр байгуулсан байна. Энэхүү гэрээ нь нийтлэг үндэслэл, ажлын цар хүрээ, талуудын эрх, үүрэг, хариуцлагын хязгаарлалт, төлбөрийн нөхцөл, зардлын нөхөн төлбөр, хариуцлагын харилцааг зохицуулсан байх ба иргэний хуульд нийцсэн байна.

***Программ болон эд хөрөнгө ашиглуулах гэрээ*** (Хавсралт 3.11). СЗХ-ны "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам"-ын 3.20-д заасны дагуу ТЗК нь хөрөнгөтэй холбоотой мэдээллийг хадгалах нэгдсэн системтэй байх шаардлага тавигдсан. Үүнтэй холбоотойгоор "ЛэндМН Актив ТЗК" ХХК болон "ЛэндМН ББСБ" ХК нарын хооронд Г/2022/03 тоот 2022 оны 08 дугаар сарын 16-ны өдөр "Программ болон эд хөрөнгө ашиглуулах" байгуулсан байна. Уг гэрээгээр "ЛэндМН ББСБ" ХК нь "Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ"-ний дагуу ББСБ-аас ТЗК-д шилжүүлсэн Зээлийн хөрөнгийн багцад багтсан аливаа хөрөнгийн мэдээллийг бүртгэх, хадгалах, тайлагнах, Зээлийн хөрөнгийн багцад багтсан аливаа зээлийн эргэн төлөлт, хугацаа хэтрэлт, сунгалт (үүгээр хязгаарлагдахгүй) зэргийн талаар мэдээллийг хянах, баталгаажуулах, дамжуулах, тайлан мэдээлэл гаргах, ТЗК-ийн үйл ажиллагаанд шаардлагатай бусад үйлдлийг бүрэн хийх боломжтой программ хангамж, эд хөрөнгийг ашиглуулах, түүнтэй холбогдсон засвар үйлчилгээг үзүүлэх харилцааг зохицуулсан байна.

Баталгаат үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогч этгээдтэй байгуулсан гэрээ, Компанийн үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой бусад гэрээ, хэлцэл нь хууль тогтоомжид нийцсэн, үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дагавар үүсгээгүй байна.

СЗХ
2022 он 09 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ... БИРЖ
MONGOLIA... EXCHANGE
2022 -  - 07
... 02





***Оролцогч байгууллагууд:***

Үнэт цаас гаргагчийн үнэт цаас гаргах ажиллагаанд

i. Үйлчилгээ үзүүлэгч болон Захиргааны ажил гүйцэтгэгчээр "ЛэндМН ББСБ" ХК (Хавсралт 4.1),
ii. Хөндлөнгийн хуулийн шинжээч, хуулийн зөвлөхөөр "Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН (Хавсралт 4.2),
iii. Санхүүгийн шинжээчээр "Нийслэл Аудит" ХХК (Хавсралт 3.7),
iv. Андеррайтераар "Райнос Инвестмент ҮЦК" ХХК, Синдикатаар "Өлзий Энд Ко Капитал ҮЦК" ХХК (Хавсралт 4.3),
v. Хэлцлийн зөвлөх болон Хөрөнгө итгэмжлэн удирдагчаар "Юнайтед Айр Файнэнс" ХХК (Хавсралт 4.4),
vi. Хөндлөнгийн аудитороор Нийслэл аудит ХХК нар тус тус ажиллаж байгаа болно (Хавсралт 3.7).

***Сонирхлын зөрчилтэй хэлцлийн тухай***. ТУЗ-ийн 2022 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн 22/12 тоот "Гэрээ байгуулах тухай" тогтоол (Хавсралт 4.5), 2022 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн Т-22/14 тоот тогтоол (Хавсралт 4.6)-оор "ЛэндМН ББСБ" ХК-тай дараах гэрээг байгуулахыг зөвшөөрсөн байна. Үүнд:

- Захиргааны үйлчилгээ үзүүлэх гэрээ
- Зээлийн эргэн төлөлтийн дансны барьцааны гэрээ
- Төлбөр цуглуулах, үйлчилгээ үзүүлэх гэрээ
- Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ
- Барьцааны гэрээ

Үйлчилгээ үзүүлэгч ЛэндМН ББСБ нь Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч байх тул хуульд заасны дагуу холбогдох этгээдүүд хэдий ч Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 19.8 болон СЗХ-ноос баталсан журамд заасны дагуу анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь үйлчилгээ үзүүлэгчийн үүргийг гүйцэтгэж болохоор байна. Түүнчлэн Компанийн тухай хуулийн 12 дугаар бүлэг, Компанийн тухай хуулийн 89.3.1-т заасанд нийцсэн гэж дүгнэж байна.

Мөн, Хөрөнгө итгэмжлэн удирдагчаас МДСХ-д ирүүлсэн 2022 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн 08-05 тоот "Баталгаа гаргах тухай" албан бичиг (Хавсралт 4.7)-т Үнэт цаас гаргагч, түүний үүсгэн байгуулагч, хөндлөнгийн аудитор, андеррайтер, хуулийн зөвлөх нартай аливаа ашиг сонирхлын зөрчилгүй. Компанийн ТУЗ-ийн 2022 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн 22/13 тоот "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах ажиллагаанд хамтран ажиллаж буй оролцогч этгээдүүдтэй ашиг сонирхлын зөрчилтэй эсэх талаар мэдэгдэл гаргах тухай" тогтоол (Хавсралт 4.8), Үнэт цаас гаргагчийн 2022 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн 2022/04 тоот албан бичиг (Хавсралт 4.9) зэргээс үзвэл Үнэт цаас гаргагч нь энэхүү үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогч



УЛААНБААТАР ХОТ
ЛЭНДМН АКТИВ ТЗК ХХК
2022080559
...988895

РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
RHINOS
УЛААНБААТАР ХОТ



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855

андеррайтер, хөрөнгө итгэмжлэн удирдагч, хөндлөнгийн хуулийн шинжээч, санхүүгийн шинжээч байгууллагуудтай аливаа сонирхлын зөрчилгүй байна.



УЛААНБААТАР ХОТ
ЛЭНДМН АКТИВ ТЗК ХХК
9022080559
ХТҮ4977 ⊕ 6888895

РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
RHINOS INVESTMENT UTsK LLC
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
ХХК

СЗХ
2022.09сар21. өдөр
БҮРТГЭВ
№ 01

MDSKhanLex

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсэгт "Үнэт цаасны танилцуулгад тусгасан мэдээллийн үнэн зөв, хүчин төгөлдөр эсэхийг энэ хуулийн 33.2.1-д заасан хууль зүйн зөвлөгөө үзүүлэх үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдээр, санхүүгийн мэдээлэл нь үнэн зөв эсэхийг энэ хуулийн 33.2.3-т заасан аудитын үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдээр тус тус хянуулж, дүгнэлт гаргуулна" гэж заасны дагуу тус Хуулийн фирм нь Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан мэдээллүүдийг нягталж нийтэд ил болсон мэдээлэл, төрийн болон эрх бүхий байгууллага, Үнэт цаас гаргагчийн зүгээс гаргаж өгсөн баримт бичигт харьцуулсан дүн шинжилгээний үндсэн дээр Үнэт цаасны танилцуулгад тусгасан хууль зүйн мэдээлэл нь үнэн зөв, хууль зүйн хувьд хүчин төгөлдөр эсэхийг дүгнэв. МДСХ нь Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан хууль зүйн ач холбогдол бүхий дараах мэдээлэл Үнэт цаас гаргагч, төрийн болон бусад эрх бүхий байгууллагаас гаргуулсан гаргаж өгсөн баримттай нийцэж байх тул үнэн зөв тусгагдсан байна гэж үзлээ. Үүнд:

- Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагдсан огноо, оноосон нэр, оршин байгаа газрын шуудангийн болон холбоо барих хаяг, эрхэлж байгаа үйл ажиллагаа;
- Үнэт цаас гаргагч хуулийн этгээдийн улсын бүртгэлийн болон регистрийн дугаар, бүртгэсэн огноо;
- Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, түүнд хувьцаа эзэмшигч нарын эзлэх хувь, зарласан болон гаргасан үнэт цаасны тоо, төрөл, нэрлэсэн үнэ болон өөрийн хөрөнгийн хэмжээ;
- Үнэт цаас гаргагчийн холбогдох этгээдийн тухай;
- Үнэт цаас гаргагчийн бүтэц, зохион байгуулалт, эрх бүхий албан тушаалтны талаарх мэдээлэл, тэдгээрийн өмчлөл дэх хувьцааны тоо, хувь хэмжээний талаарх мэдээлэл;
- Үнэт цаас гаргах шийдвэр;
- Тухайн үнэт цаасыг нээлттэй хүрээнд санал болгох ажиллагаанд хамтран оролцож байгаа зохицуулалттай этгээд болон бусад мэргэжлийн үйлчилгээ үзүүлж байгаа этгээдийн тухай, тэдгээртэй байгуулсан гэрээгээр хүлээсэн эрх, үүрэг, хариуцлагын тухай талаарх
- Үнэт цаасны эргэн төлөлт, хүү, хүүг тооцох аргачлал, төлбөрийн хуваарь, үнэт цаас гаргагч гаргасан үнэт цаасаа буцаан худалдаж авах нөхцөл, үүсгэн байгуулагч, анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн тухай мэдээлэл;
- Нээлттэй хүрээнд санал болгож байгаа үнэт цаасаар гэрчлэгдэх эрх, үүрэг;
- Үүсгэн байгуулагч, анхны үүрэг гүйцэтгүүлэгч, тэдгээрийн холбоотой этгээд, зээлийн шинжилгээ гаргагч, хөндлөнгийн аудиторууд болон хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны ажиллагаанд оролцогч бусад этгээдийн талаарх мэдээлэл;
- Хөрөнгийн багцад байгаа хөрөнгийн 10-аас дээш хувьд үйлчилгээ үзүүлж буй хөрөнгө итгэмжлэн удирдагчийн талаарх мэдээлэл;
- Хөрөнгийн багцын хуулийн болон санхүүгийн шалгуур үзүүлэлт;
- Төлбөрийн чадваргүй байдалд орсон хөрөнгийг цуглуулах, худалдан борлуулах, хөрөнгийг итгэмжлэн удирдагчийн гүйцэтгэлийг хянах, түүнийг солих зохицуулалт;



УЛААНБААТАР ХОТ
ЛЭНДМН АКТИВ ТЗК ХХК
9022080559
ХТҮ4977 С888895

РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ

- Баталгаат үнэт цаасны төлбөр хугацаандаа төлөгдөхгүй нөхцөлд авах арга хэмжээ;
- Хөрөнгө итгэмжлэн удирдагч болон бусад үйлчилгээ үзүүлэгч төлбөрийн чадваргүй болсон тохиолдолд авах арга хэмжээ;
- ТЗК-ийн хөндлөнгийн аудиторыг сонгох, солих журам;
- Хөрөнгө оруулагчдад хуваарилахаас өмнө хөрөнгийн орлогоос төлөгдөх зардал, төлбөр, хураамжийн талаарх мэдээлэл;
- ТЗК байгуулах данс, уг дансны орлого зарлагын урсгалын тодорхойлолт, тэдгээрийг захиран зарцуулах эрхтэй этгээдийн талаарх мэдээлэл;
- Хөрөнгийн багцад хөрөнгө нэмж оруулах, хасах үйл явц, нөхцөл, түүний зохицуулалт;
- Хөрөнгийн багц дахь хөрөнгийн онцлог, түүнд тавигдах шаардлага;
- ТЗК-ийг татан буулгах нөхцөл, журам;
- Хөрөнгө оруулагчдад танилцуулах мэдээллүүд, тэдгээрийг тайлагнах хугацаа, тайлангийн агуулга.

Дээр дурдсан хууль зүйн ач холбогдолтой мэдээллээс бусад Үнэт цаас гаргагчийн санхүүгийн үзүүлэлт, бүтээгдэхүүн, үйлчилгээ, ээлжих зэрэглэл, борлуулалтын хэмжээ, ашиг, алдагдал зэрэг бизнесийн үйл ажиллагаа, Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны үндсэн чиглэлд хамаарах зах зээлд эзэлж буй байр суурь, өрсөлдөгч байгууллагуудын тухай мэдээлэл, Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны тухай болон Үнэт цаас гаргагчийн зах зээлийн төлөвлөгөө зэрэг агуулагдсан эдийн засгийн ерөнхий мэдээлэл, салбарын үзүүлэлт, санхүүгийн төсөөлөл, Үнэт цаас гаргагчийн талаар олон нийтэд ил, тодорхой үйл баримт, үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд тусгагдсан баталгаажуулах боломжгүй тоон үзүүлэлт болон хараат бус байгууллагуудын хийсэн дүн шинжилгээ, санхүүгийн тооцоолол, үнэлгээ, Үнэт цаас гаргаж хуримтлуулсан хөрөнгийг зарцуулах бизнесийн төлөвлөгөө, дунд хугацааны бизнес төлөвлөгөөний тойм, Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд учирч болох эрсдэл, эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө зэрэг мэдээлэлд МДСХ нь дүн шинжилгээ хийгээгүй болохыг дурдаж байна.

Нэгтгэн дүгнэж үзвэл Үнэт цаас гаргагчийн үнэт цаасны танилцуулгад тусгагдсан хууль зүйн ач холбогдол бүхий мэдээлэл нь үнэн зөв, хүчин төгөлдөр байна гэж Хуулийн фирм дүгнэж байна

СЗХ
2022 .09 сар 21. өдөр
БҮРТГЭВ
№ 01



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2022-10-07
БҮРТГЭВ-02



**Компанийн төлөөлөн удирдах зөвлөл**

Компанийн ТУЗ-ийг Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 22/03 дугаартай шийдвэрээр дараах бүрэлдэхүүнтэйгээр сонгож, ТУЗ-ийн 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн хурлын 22/01 тоот тогтоолоор ТУЗ-ийн даргаар Л.Ганбатыг сонгож, ТУЗ-ийн 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн хурлын 22/02 тоот тогтоолоор ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар Б.Оюунболдыг томилсон байна. Дүгнэлт гаргах өдрийн байдлаар ТУЗ нь дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

| № | Нэр | Боловсрол | Ажлын туршлага |
|---|---|---|---|
| Ердийн гишүүд: | | | |
| 1. | Бүлтэнгийн Удвал | 1994 – 1995 онд Монгол Улсын Их Сургуулийн математикийн факультет; 1995-2000 онд Турк Улсын Анкарагийн Их Сургуулийн эдийн засагч мэргэжлээр бакалавр; 2000-2003 онд Турк Улсын Анкарагийн Их Сургуулийн эдийн засагч мэргэжлээр магистр. | 2004-2009 онд М-Си-Эс групп, Анунгоо ХХК-д Хангамжийн албаны дарга; 2009-2010 онд М-Си-Эс Менежментэд дотоод аудитор; 2010-2013 онд Грандхаан Холдинг ХХК, Грандхаан группт худалдан авалт, хангамж хариуцсан захирал; 2015-2018 он Анунгоо ХХК-д Бизнес хөгжил, хангамж хариуцсан захирал, Маркетинг хариуцсан захирал; 2018-2020 онд М-Си-Эс групп, М төсөл, М ХХК-д Бизнес хөгжил, дата судалгааны багийн ахлагч; 2020.03-2020.09 сард Ашид капитал ББСБ-д Дата хэлтсийн дарга; 2020.10 сараас одоог хүртэл ЛэндМН ББСБ ХК-д дэд захирал, Гүйцэтгэх захирал. |
| Хараат бус гишүүд: | | | |
| 2. | Өлзийбатын Болортуяа | 2012 онд Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуульд олон улсын эрх зүйн чиглэлээр бакалавр; 2017 онд Монгол Улсын Их Сургуулийн Хууль | 2012 онд "Боналекс" ХХК-д Туслах хуульч; 2012-2015 онд "Алтайн хүдэр" ХХК-д туслах хууль, хуулийн мэргэжилтэн; 2015-2021 онд "Өмгөөллийн Цогт энд Нандин" ХХН-д хуульч, ахлах хуульч, нөхөрлөлийн гишүүн; |



УЛААНБААТАР ХОТ
ЛЭНДМН АКТИВ ТЗК ХХК
9022080559
РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
RHINOS INVESTMENT LLC
130
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2022.10.21 өдөр
БҮРТГЭВ
№ 01



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-07
...ГЭВ-02



| | | | |
|---|---|---|---|
| | | зүйн сургуульд хууль зүйн ухааны чиглэлээр магистр. | 2021 оноос одоог хүртэл "Өмгөөллийн Цогт энд Нандин" ХХН-д Гүйцэтгэх захирал. |
| 3. | Атарсайхангийн Ганбат* | 2004-2008 онд Монгол Улсын Их Сургуулийн Математик компьютерын сургуулийг математикийн ухааны бакалавр;<br>2019-2021 онд Их Британи Умард Ирландын нэгдсэн Вант Улсын Стратклайдын Их Сургуулийг Хөрөнгө оруулалт болон санхүүгийн чиглэлээр магистр;<br>2009-2014 онд Япон Улсын Киото их сургуулийн Шинжлэх ухааны их сургуулийг Математик болон математикийн ухааны доктор. | 2014-2017 онд Монгол Улсын Их Сургуулийн Математик, тоон технологийн хүрээлэнд эрдэм шинжилгээний ажилтан;<br>2014-2016 онд Монгол Улсын Их Сургуульд ахлах багш;<br>2016-2018 онд Монголбанкинд эдийн засагч;<br>2017-2019 онд "Мөнгө, Санхүү, Баялаг" сэтгүүлд нарийн бичгийн дарга болон Сэтгүүлийн зөвлөлийн гишүүн;<br>2018-2019 онд Монголбанкинд Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн ажлын албаны дарга;<br>2021 оноос "Мирэ Эссет Секьюритис Монгол ҮЦК" ХХК-д хөрөнгө оруулалтын менежер. |

**ТУЗ-ийн дарга*

Компанийн ТУЗ-ийн дарга, гишүүд нь Компанийн тухай хуульд заасан эрх бүхий албан тушаалтны шаардлагыг хангаж байгаа эсэхийг дараах хүснэгтээр харуулав:

| **КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАНД ТАВИГДАХ ШААРДЛАГА** | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **№** | **Нэрс/Шаардлага** | **Төрийн болон орон нутгийн захиргааны байгууллага, цэрэг, цагдаа, прокурорын байгууллагад удирдах албан тушаал хашдаг эсэх** | **Ял шийтгэл эдэлж байгаа эсэх (КтХ-ийн 84.3.2)*** | **Компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан эсэх (КтХ-ийн 75.8)** | **Хувь хүн байх (КтХ-ийн 77.3, 83.2, 83.3)** |



УЛААНБААТАР ХОТ
ЛЭНДМН АКТИВ ТЗК ХХК
9022080569
ХТУ4977 Ф С888395
РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
RHINOS INVESTMENT ҮЦК
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2022 .09 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№

МОНГОЛЫН ҮНЭТ ЦААСНЫ БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -10- 07
БҮРТГЭВ-02

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 1. | **А.Ганбат** (ТУЗ-ийн дарга ТУЗ-ийн хараат бус гишүүн) | Үгүй | Үгүй* | Тийм /2022.06.06-ны өдөр, Дугаар 0132060/ | Тийм |
| 2. | **Б.Удвал** (ТУЗ-ийн ердийн гишүүн) | Үгүй | Үгүй* | Тийм /2022.03.15-ны өдөр, Дугаар 0131895/ | Тийм |
| 3. | **Ө.Болортуяа** (ТУЗ-ийн хараат бус гишүүн) | Үгүй | Үгүй* | Тийм /2022.06.27-ны өдөр, Дугаар 0132077/ | Тийм |

**Монгол Улсын Хууль зүйн сайдын 2017 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн А/195 тоот тушаалын 6 дугаар зүйлд заасны дагуу Ял шийтгэлтэй эсэх лавлагааг өмгөөллийн нөхөрлөлд олгодоггүй тул Компанийн тухай хуулийн 84.3.2-т заасан шийтгэл эдлээгүй байх шаардлагыг ТУЗ-ийн гишүүд хангаж байгаа эсэхийг СЗХ-ны "Банкнаас бусад санхүүгийн болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх тохиромжтой этгээдийг тодорхойлох журам"-ын дагуу бөглөсөн асуулгын хуудас болон ТУЗ-ийн гишүүний мэдүүлэг, баталгааг үндэслэж дүгнэв.*

Компанийн ТУЗ-ийн гишүүд нь Компанийн тухай хууль болон Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасан ТУЗ-ийн гишүүнд тавих нэмэлт шаардлагыг хангаж байгаа эсэхийг дараах хүснэгтээр харуулав:

| **ТУЗ-ийн гишүүнд тавигдах нэмэлт шаардлага** | | | | |
|---|---|---|---|---|
| **№** | **Шаардлага** | **ТУЗ-ийн гишүүдийн нэрс** | | |
| | | **Ердийн гишүүн Б.Удвал** | **Хараат бус гишүүн А.Ганбат** | **Хараат бус гишүүн Ө.Болортуяа** |
| 1. | Өөрөө эсхүл компанийн нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн энгийн хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшдэггүй байх (КтХ-ийн 79.1.1) | Тийм** | Тийм** | Тийм** |



УЛААНБААТАР ХОТ
ЛЭНДМН АКТИВ ТЭЗК ХХК
9022080559
ХТҮ4977 ⊕ С888895

РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
RHINOS INVESTMENT ÜTsK

132

УЛААНБААТАР ХОТ

| | | | | |
|---|---|---|---|---|
| 2. | Төрийн үйлчилгээнийхээс бусад төрийн алба хашдаггүй байх (КтХ-ийн 79.1.3) | Тийм** | Тийм** | Тийм** |
| 3. | Компанитай бизнесийн гэрээ хэлцэл байгуулаагүй байх, тийм холбоогүй байх (КтХ-ийн 79.1.4) | *Ердийн гишүүнд хамааралгүй* | Тийм** | Тийм** |
| 4. | Анхны үүрэг гүйцэтгүүлэгч, үүсгэн байгуулагч, худалдагч, тэдгээрийн хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан болон тэдгээрийн гэр бүлийн гишүүн биш байх (ХБҮЦтХ-ийн 12.8) | *Ердийн гишүүнд хамааралгүй* | Тийм** | Тийм** |
| 5. | Бүрэн эрхээ хэрэгжүүлэх үед хувийн ашиг сонирхол нийтийн ашиг сонирхолтой зөрчилдөх болон албан үүргээ тэгш, шударгаар хэрэгжүүлэхэд харшаар нөлөөлж болохуйц нөхцөл байдал бий болоогүй. | - | Тийм** | Тийм** |
| 6. | Төрийн үйлчилгээнийхээс бусад төрийн алба хашдаггүй (КтХ-ийн 79.1.3) | Тийм** | Тийм** | Тийм** |
| 7. | Төрийн болон нутгийн захиргааны байгууллага, цэрэг, цагдаа, шүүх, прокурорын байгууллагад удирдах албан тушаал хашдаггүй (КтХ-ийн 84.3.1) | Тийм** | Тийм** | Тийм** |
| 8. | Компанийн засаглалын чиглэлээр сургалтанд хамрагдаж гэрчилгээ авсан (КтХ-ийн 75.8) | Тийм** | Тийм** | Тийм** |
| 9. | Ял шийтгэл эдлээгүй ( КтХ-ийн 84.3.2) | Тийм** | Тийм** | Тийм** |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 10. | Албан татварын болон хугацаа хэтэрсэн их хэмжээний зээлийн өргүй (МХБ-ийн Үнэт цаасны бүртгэлийн журмын 10.5.1) | Тийм** | Тийм** | Тийм** |
| 11. | Мэргэжил, боловсрол, ажлын туршлагын хувьд "ЛэндМН Актив ТЗК" ХХК-ийн ТУЗ-ийн гишүүнээр ажиллахад шаардагдах туршлагатай (СЗХ-ны ХБҮЦ гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журмын 3.13) | Тийм** | Тийм** | Тийм** |

***Компанийн тухай хууль, Хөрөнгөөр баталгааж үнэт цаасны тухай хууль, СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам, МХБ-ийн Үнэт цаасны бүртгэлийн журмуудад заасан ТУЗ-ийн гишүүнд тавигдах шаардлагыг тус компанийн ТУЗ-ийн гишүүд хангаж байгаа эсэхийг тэдний гаргаж өгсөн мэдүүлэг, баталгааг үндэслэж дүгнэв.*

Компанийн ТУЗ-ийн гишүүд нь холбогдох хууль, журмуудад заасан ТУЗ-ийн гишүүний шаардлагыг хангаж байгаа бөгөөд тэдгээр нь Компанийг удирдах чадвар, дадлага туршлагатай гэж дүгнэв.

**Бусад нэмэлт судалгаа:**

Бид Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, СЗХ-ны "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам" болон МХБ-ийн "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам"-ын зохицуулалтаас гадна хөрөнго оруулагчид шийдвэр гаргахад ач холбогдолтой гэж үзэн хөндлөнгийн мэдээлэл цуглуулж, тус Компанитай холбоотой дараах нөхцөл байдлуудыг тогтоосон болно. Үүнд:

- Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Монголын олон улсын арбитрын 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 4/1038 тоот тодорхойлолт (Хавсралт 6.1)-д тусгаснаар "ЛэндМН ББСБ" ХК нь 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн байдлаар тус арбитраар хянан шийдвэрлэгдсэн болон арбитрын ажиллагаа явагдаж байгаа хэрэгт нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдээр оролцоогүй байна;
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Шийдвэр гүйцэтгэх албанаас 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 0000020 тоот Тодорхойлолт (Хавсралт 6.2)-д "ЛэндМН ББСБ" ХК нь шүүхийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд өр төлбөргүй байна;
- Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн тусгай архиваас 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдөр гаргасан 1/1633 тоот тодорхойлолт (Хавсралт 6.3)-д тусгаснаас үзвэл "ЛэндМН ББСБ" ХК нь сүүлийн 3 жилийн байдлаар нь Баянзүрх дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх, Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх, Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх, Баянгол дүүргийн иргэний хэргийн анхан

шатны шүүх, Хан-Уул дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх, Сонгинохайрхан дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн иргэний хэрэгт хариуцагчаар оролцож байгаагүй байна;

- Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны Шүүхийн тамгын газраас 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 1960 тоот тодорхойлолт (Хавсралт 6.4)-д тусгаснаар "ЛэндМН ББСБ" ХК нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.4 дэх заалтад хамаарах асуудлаар нэхэмжлэгч болон гуравдагч этгээдээр сүүлийн 3 жилд оролцож байгаагүй байна;
- Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газраас 2022 оны 06 дүгээр сарын 20-ний өдөр гаргасан 01/1092 тоот албан бичиг (Хавсралт 6.5)-т тусгаснаар "ЛэндМН ББСБ" ХК нь тодорхойлолт огсон одрийн байдлаар Өрсөлдөөний тухай хууль тогтоомжийг зөрчсөн үндэслэлээр захиргааны шийтгэл хүлээж байгаагүй бөгөөд Өрсөлдөөний тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д заасны дагуу давамгай байдалтай аж ахуйн нэгжээр тогтоогдоогүй байна;
- "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ТӨХК-аас 2022 оны 06 дугаар сарын 21-ны өдөр ирүүлсэн 01/888 тоот албан бичиг (Хавсралт 6.5)-т тусгаснаар "Лэндмн ББСБ" ХК нь "3020-ЛЭНД БОНД", "3027-ЛЭНД БОНД ТРАНЧ-1", "3029-ЛЭНД БОНД ТРАНЧ-2" нэртэй өрийн хэрэгслүүд тус тус гаргасан, гуравдагч компанийн үнэт цаас, өрийн хэрэгсэл эзэмшээгүй, тус өдрийн байдлаар гэрээний үүргийн хэрэгжилтийн зөрчилгүй, өр төлбөрийн тооцоогүй байна;
- "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-аас 2022 оны 06 дүгээр сарын 22-ны өдрийн 01/324 тоот албан бичиг (Хавсралт 6.7)-т тусгаснаар "Лэндмн ББСБ" хувьцаат компани нь "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-д 2018 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр бүртгэгдсэн бөгөөд ямар нэгэн өр төлбөргүй, гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлэн ажиллаж байна;
- Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбооноос 2022 оны 07 дүгээр сарын 06-ны өдрийн 2022/019 тоот тодорхойлолт (Хавсралт 6.8)-д тусгаснаар "Лэндмн ББСБ" /5039754/ нь Монголын ББСБ-уудын Холбооны гишүүн байгууллага бөгөөд гишүүний ёс зүйн дүрэм зөрчсөн үйлдэл гаргаж, хариуцлага хүлээж байгаагүй байна;
- Санхүүгийн Зохицуулах Хорооноос 2022 оны 06 дүгээр сарын 27-ны өдөр ирүүлсэн 9/2651 тоот албан бичиг (Хавсралт 6.9)-т тусгаснаар "Лэндмн ББСБ" ХК нь СЗХ-ны 2015 оны 293 дугаар тогтоолоор банк бус санхүүгийн байгууллагын зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, Хорооны даргын 2016 оны 236 дугаар тушаалаар ББСБ-ын оноосон нэрийг "Дуусашгүй ундарга ББСБ" байсныг "Лэндмн ББСБ" болгон өөрчлөх зөвшөөрсөн ба 2018 оны 193 дугаар тогтоолоор банк бус санхүүгийн төлбөр тооцооны хэрэгсэл гаргах, цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулга, 2019 оны 45 дугаар тогтоолоор факторинг, итгэлцэл, 2019 оны 128 дугаар тогтоолоор гадаад валютын арилжаа, 2020 оны 107 дугаар тогтоолоор хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх нэмэлт тусгай зөвшөөрлүүдийг тус тус олгосон байна. Лавлагаа гаргах өдрийн байдлаар тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох нөхцөл бүрдээгүй байна. Тус банк бус санхүүгийн байгууллагаас тайлан мэдээг хугацаанд нт ирүүлдэг ба 2022 оны 01 дүгээр улирлын байдлаар хангаж ажиллавал зохих зохистой харьцааг бүрэн хангаж ажилласан байна.

Хорооны даргын 160 дугаар тушаалаар баталсан удирдамжийн хүрээнд газар дээр хийсэн хэсэгчилсэн шалгалтаар илэрсэн зөрчилд Улсын байцаагчийн албан шаардлагаар хугацаатай үүрэг даалгавар өгсөн ба биелэлтийг хугацаанд нь бүрэн илрүүлж, зөрчлийг арилгасан. Хорооны 2018 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 60 тогтоолоор Компанийн нийтэд санал болгон гаргаж буй үнэт цаасыг бүртгэсэн бөгөөд Хорооноос 2019 оны 10 дугаар сард Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийг зөрчсөн зөрчилд Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтыг үндэслэн торгууль ногдуулсныг бүрэн төвлөрүүлсэн. "ЛэндМН ББСБ" ХК нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээний асуулгыг тогтмол ирүүлдэг бөгөөд 2021 оны жилийн эцсийн эрсдэлийн үнэлгээ "бага" буюу 2.65 гэж үнэлэгдсэн байна;

- Цагдаагийн ерөнхий газар Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаас 2022 оны 07 дугаар сарын 07-ны өдөр ирүүлсэн 13б/1406 тоот Тодорхойлолт (Хавсралт 6.10)-д "ЛэндМН ББСБ" ХК-ийн эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэхийг цагдаагийн байгууллагын ял шийтгэлийн мэдээллийн сангаас тус тус шалгахад ямар нэг мэдээлэл бүртгэгдээгүй байна;
- Монголын татварын албанаас 2022 оны 07 дугаар сарын 20-ны өдөр ирүүлсэн Аж ахуйн нэгж байгууллагын тодорхойлолт (Хавсралт 6.11)-д тусгаснаар "ЛэндМН ББСБ" ХК нь 12,131,778.00 төгрөгийн дутуу төлөлттэй, 2,118,660.74 төгрөгийн илүү төлөлттэйгээр бүртгэгдсэн байна;
- Монголын татварын албанаас 2022 оны 07 дугаар сарын 28-ны өдөр ирүүлсэн Аж ахуйн нэгж байгууллагын тодорхойлолт (Хавсралт 6.12)-д тусгаснаар "ЛэндМН Актив" ХХК нь татвар төлөлтийн аливаа мэдээлэл бүртгэгдээгүй, татварын үлдэгдэлгүй байна;
- Гаалийн ерөнхий газрын 2022 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн тодорхойлолт (Хавсралт 6.13)-д тусгаснаар "ЛэндМН ББСБ" ХК нь гаалийн байгууллагад татварын өргүй байна;
- Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн 2022 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн хайлт (Хавсралт 6.14)-аас үзвэл "ЛэндМН Актив" ХХК нь аливаа бүртгэлгүй байна;
- Улсын газрын кадастрын мэдээллийн сангийн нэгдсэн систем (Хавсралт 6.15)-ийн 2022 оны 07 дугаар сарын 20-ны хайлтаас үзвэл "ЛэндМН ББСБ" ХК нь Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд зааснаар газар нэг удаа үнэгүй өмчлөөгүй байна;
- Газар зохион байгуулалт, геодизи, зураг зүйн газрын 2022 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн Хамтран өмчлөгчийн лавлагаа (Хавсралт 6.16)-наас үзвэл өмчлөлийн газрыг хамтран өмчлөөгүй байна.
- Барьцааны мэдэгдэл бүртгэх цахим мэдээллийн сан (Хавсралт 6.17)-ийн 2022 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн хайлтаас үзвэл "ЛэндМН ББСБ" ХК нь банк, банк бус санхүүгийн байгууллагад барьцаалсан 4 бүртгэл байна.
- Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн Эд хөрөнгө бүртгэлтэй эсэх лавлагаа (Хавсралт 6.18)-наас үзвэл "ЛэндМН ББСБ" ХК-ийн өмчлөлд 2 үл хөдлөх эд хөрөнгө бүртгэлтэй байна.

MDSKhanLex

- Авто тээврийн үндэсний төв (Хавсралт 6.19)-ийн 2022 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн Тээврийн хэрэгслийн лавлагаанаас үзвэл "ЛэндМН ББСБ" ХК-ийн өмчлөлд 234 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байна.
- Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн лавлагаа (Хавсралт 6.20)-аар "ЛэндМН ББСБ" ХК нь 2022 оны 08-р сарын 12-ны өдрийн байдлаар 2022 оны 05-р сарын 27-ны өдрийн 2023 оны 12-р сарын 17-ны өдөр төлөгдөж дуусах нөхцөлтэй 1,000,000,000 төгрөгийн үнийн дүн бүхий зээлээс 1 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй, бусад зээлийн үлдэгдэл 0 төгрөг байна. Эдгээр зээлүүд нь "хэвийн" ангилагдаж байна.

**ХҮНДЭТГЭСЭН,**

"ӨМГӨӨЛЛИЙН ЭМ ДИ ЭС ЭНД ХААНЛЕКС" ХХН-ИЙН

ГИШҮҮН, ХУУЛЬЧ

Д.ДУГЭРЖАВ

# ХУУЛИЙН НЭМЭЛТ ДҮГНЭЛТ

MDSKhanLex

2022.09.13 Д- 22/242

**"ЛЭНДМН АКТИВ ТЗК" ХХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ ТАНАА**

***Хууль зүйн нэмэлт дүгнэлт хүргүүлэх тухай***

Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны хэмжээ, хөрөнгийн багцын дүнд өөрчлөлт оруулж буйтай холбогдуулан энэхүү нэмэлт дүгнэлтийг гаргаж байна.

***Нэг. Үнэт цаасны нөхцөлд өөрчлөлт оруулах шийдвэр нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх талаар.***

Компанийн цор ганц хувьцаа эзэмшигч "ЛэндМН ББСБ" ХК-ийн ТУЗ 2022 оны 09 дүгээр сарын 13-ны өдөр хуралдаж, 22/24 тоот тогтоолоор 2022 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн 22/18 дугаартай тогтоолдоо өөрчлөлт оруулж, мөн "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах ажиллагаатай холбогдуулан гэрээ, хэлцэл шинэчлэн байгуулах тухай" 22/25 тоот тогтоол гаргасан (Хавсралт 1.2, Хавсралт 1.3) байна. Ингэхдээ "ЛэндМН ББСБ" ХК нь хөрөнгийн багцыг зөвхөн Автомашины фидуци бүхий зээлээр бүрдүүлэхээр шийдвэрлэжээ. Энэхүү өөрчлөлттэй холбоотойгоор Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргах тухай Компанийн ТУЗ-ийн 2022 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 22/16 тоот тогтоол (Хавсралт 1.1)-оор 2022 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн 22/15 дугаар тогтоолоор баталсан Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны нөхцөлийг тодорхойлсон хавсралтад дараах өөрчлөлт оруулжээ. Үүнд:

1. "Компанийн гаргах хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны дүн өөрчлөгдсөнтэй холбогдуулан Компанийн ТУЗ-ийн 2022 оны 08 сарын 16-ны өдрийн 22/15 тоот "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тухай" тогтоолын хавсралтаар батлагдсан үнэт цаасны нөхцөлийн 3 дахь хэсгийн "8,000,000,000 (найман тэрбум)" гэснийг "4,850,000,000 (дөрвөн тэрбум найман зуун тавин сая)" гэж, 5 дахь хэсгийн "80,000 ширхэг" гэснийг "48,500 ширхэг" гэж, 11 дэх хэсгийн "8,000,000,000 (найман тэрбум)" гэснийг "5,335,006,689 (таван тэрбум гурван зуун гучин таван сая зургаан мянга зургаан зуун наян ес)" гэж тус тус өөрчилсүгэй.
2. Энэхүү тогтоолын 1-т заасан өөрчлөлтийг тусгасан үнэт цаасны нөхцөлийг Хавсралт 1-ээр баталгаажуулсугай.
3. Үнэт цаасны нөхцөлд өөрчлөлт оруулсантай холбогдуулан "Үнэт цаасны танилцуулга"-д холбогдох өөрчлөлтийг тусган энэхүү тогтоолын Хавсралт 2-оор батлсугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангах арга хэмжээ авч Компанийн ТУЗ-д тухай бүр тайлагнахыг ТУЗ-ийн гишүүн (Б.Удвал)-д үүрэг болгосугай" гэжээ.

Уг тогтоол нь Компанийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх эхсэг, 76 дугаар зүйлийн 76.1.5, 76.1.18 дахь хэсэг, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн холбогдох хэсэг, "ЛэндМН Актив ТЗК" ХХК-ийн

дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.4.4.11 дэх заалтад нийцэж байна. Уг тогтоолыг Төлөөлөн удирдах зөвлөл нь Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйл, "ЛэндМН Актив ТЗК" ХХК-ийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.4.4.11-д тус тус заасан бүрэн эрхийнхээ хүрээнд гаргасан байна.

Нэгтгэн дүгнэвэл, Үнэт цаасны нөхцөлд өөрчлөлт оруулсан "ЛэндМН ББСБ" ХК, "ЛэндМН Актив ТЗК" ХХК-ийн дээр дурдсан ТУЗ-ийн тогтоолууд нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.

***Хоёр. Компанийн үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой гэрээ, хэлцэл нь холбогдох хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх***

Үнэт цаасны хэмжээ, хөрөнгийн багцын дүнд өөрчлөлт орж буйтай холбогдуулан "ЛэндМН Актив ТЗК" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн "Хөрөнгийн багц нэмж бүрдүүлэх, түүнтэй холбоотой гэрээ хэлцэл хийх тухай" 22/17 тоот тогтоол (Хавсралт 1.4)-оор гэрээ хэлцэлд өөрчлөлт оруулан шинэчлэн батлахаар шийдвэрлэсэн байна. Үүнд:

> "1. Компаниас гаргах хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасыг Санхүүгийн зохицуулах хорооноос бүртгэсэн тохиолдолд Компанийн ТУЗ-ийн 2022 оны 7 сарын 6-ны өдрийн 22/07 тоот тогтоолоор батлагдсан шалгуур үзүүлэлтүүдийн дагуу сонгогдсон, зээлийн үндсэн төлбөрийн үлдэгдлийн нийлбэр нь 5,335,006,689 (таван тэрбум гурван зуун гучин таван сая зургаан мянга зургаан зуун наян ес) төгрөгийн үнийн дүнтэй автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс шилжүүлэн авахтай холбогдуулан дор дурдсан гэрээнүүдийг байгуулахаар шийдвэрлэж, гэрээний төслийг энэхүү тогтоолын хавсралтаар шинэчлэн баталсугай. Үүнд:
>
> 1.1 Анхны үүрэг гүйцэтгүүлэгч "ЛэндМН ББСБ" ХК-тай байгуулах "Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ"-ний төслийг энэхүү тогтоолын Хавсралт 1;
>
> 1.2 Барьцаалуулагч "ЛэндМН ББСБ" ХК-тай байгуулах "Фидуцийн барьцааны гэрээ"-ний төслийг энэхүү тогтоолын Хавсралт 2-оор тус тус шинэчлэн баталсугай" гэжээ.

"ЛэндМН ББСБ" ХК-тай байгуулах Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ, Фидуцийн барьцааны гэрээнүүдэд хөрөнгийн багцын өөрчлөлттэй холбоотой зохицуулалтыг тусгаж 2022 оны 09 дүгээр сарын 13-ны өдөр холбогдох гэрээнүүдийг шинэчлэн байгуулсан байна (Хавсралт 1.5, 1.6).

Баталгаат үнэт цаас гаргах ажиллагаатай холбогдуулан байгуулсан Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ, Фидуцийн барьцааны гэрээ нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.

***Гурав. Үнэт цаасны нөхцөлд өөрчлөлт оруулах шийдвэр, түүнийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Үнэт цаасны танилцуулгад өөрчлөлт оруулсан нь хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдийн хууль ёсны эрх ашигт нийцсэн эсэх, өөрчлөлтөд орсон хууль зүйн мэдээлэл нь үнэн зөв эсэх талаар.***

Үнэт цаас гаргагч нь хөрөнгийн багцыг зөвхөн автомашины фидуци бүхий зээлээр бүрдүүлж, цахим зээлүүдийг хөрөнгийн багцад оруулахгүй байхаар шийдвэрлэсэнтэй холбоотой зохих өөрчлөлтийг үнэт цаасны танилцуулгад тусгасан нь хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдийн хууль ёсны эрх ашигт нийцсэн байна. Үнэт цаасны танилцуулгад орсон хууль зүйн мэдээлэл нь үнэн зөв болно.

Дээр дурдсан өөрчлөлтийн дагуу Хөрөнгийн багцыг автомашины фидуци бүхий 306 зээлийн дансдаас бүрдүүлсний 15.3 хувь буюу автомашины фидуци бүхий 5 зээлийг Зөвлөхийн зүгээс сонгож дүн шинжилгээ хийхэд Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн хуулийн шалгуур үзүүлэлтийг бүрэн хангасан талаар манай дүн шинжилгээний тайланд тусгагдсан билээ. Өөрөөр хэлбэл, Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс худалдахаар санал болгосон зээлийн хөрөнгийн нэгдсэн багцаас 95%-ийн итгэлцлийн түвшин буюу 5%-ийн хүлээгдэж буй алдааны дээд хязгаарын шаардлагыг хангаж байна гэж үзэв. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь автомашины зээлийн гэрээ, үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар эд хөрөнгө өмчлөлд шилжүүлэх (фидуци) гэрээг нэгдсэн загварын дагуу, зээлийн үйл ажиллагааны журмаар байгуулж, баримт бичгийн бүрдүүлэлт, зээлд тавигдах шаардлага, хяналт судалгааг нэгдсэн арга зүйгээр хэвшүүлж буй гэж Зөвлөхийн зүгээс тооцож, дүн шинжилгээнд зохих төлөөллийг хамруулсан гэж үзэж байна.

НӨХӨРЛӨЛИЙН ГИШҮҮН, ХУУЛЬЧ Д.ДҮГЭРЖАВ

ХХ 2022 .09.21 өдөр БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2022-10-07 БҮРТГЭВ-02

"Өмгөөллийн Эм Ди Эс Энд Хаанлекс" ХХН-ийн 2022 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн Д-22/242 тоот Хууль зүйн нэмэлт дүгнэлтэд ашигласан баримт бичиг

**Хавсралт 1.**

| No. | Баримт бичгийн нэр | Дугаар | Огноо | Олгосон байгууллага/ Гэрээний нөгөө тал |
|---|---|---|---|---|
| 1.1 | Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны нөхцөлд өөрчлөлт оруулж, шинэчлэн батлах тухай тогтоол, тэмдэглэл | 22/16 | 2022.09.13 | "Лэндмн Актив ТЗК" ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл |
| 1.2 | 2022 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн 22/18 тоот ТУЗ-ийн тогтоолд өөрчлөлт оруулах тухай | 22/24 | 2022.09.13 | "Лэндмн ББСБ" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл |
| 1.3 | Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах ажиллагаатай холбогдуулан гэрээ, хэлцэл шинэчлэн байгуулах тухай | 22/25 | 2022.09.13 | "Лэндмн ББСБ" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл |
| 1.4 | Хөрөнгийн багц нэмж бүрдүүлэх, түүнтэй холбоотой хэлцэл хийх тухай | 22/17 | 2022.09.13 | "Лэндмн Актив ТЗК" ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл |
| 1.5 | Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ | Г/2022/10 | 2022.09.13 | "Лэндмн Актив ТЗК" ХХК, "Лэндмн ББСБ" ХК |
| 1.6 | Фидуцийн барьцааны гэрээ | Г/2022/11 | 2022.09.13 | "Лэндмн Актив ТЗК" ХХК, "Лэндмн ББСБ" ХК |

~oOo~

УЛААНБААТАР ХОТ ЛЭНДМН АКТИВ ТЗК ХХК 9022080559 ХТҮ4977 6888395
РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК INVESTMENT LLC УЛААНБААТАР ХОТ

2022.09.21

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-07
БҮРТГЭВ-02

lendmn

# ЕС. ХАВСРАЛТ



## 9.1 Үнэт цаас гаргагчийн улсын бүртгэлийн гэрчилгээ

МОНГОЛ УЛС

ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

000259538

2022.07.03
/ Бүртгэсэн он,сар,өдөр /

9011841085
/ Хувийн хэргийн дугаар /

6888895
/ Регистрийн дугаар /

ЛэндМН актив — Хязгаарлагдмал хариуцлагатай компани
/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм
/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

Шийдвэр
/ шийдвэрийн нэр /

01
/ дугаар /

2022.06.16
/ он, сар, өдөр /

62090 — Мэдээллийн технологийн үйл ажиллагаа
/ Код / — / Үйл ажиллагааны чиглэл /

Хугацаагүй
/ хугацаа /

1
/ гишүүдийн тоо /

80,000.00
/ хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /

Улаанбаатар, Чингэлтэй, 3-р хороо, жуулчны, гудамж-34 Сувд тев 2 тоот, Утас1: 77222992, Утас2: , Факс:
/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг/

ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГАЗАР
/ бүртгэсэн байгууллагын нэр /

УЛСЫН БҮРТГЭГЧ — Ш.ОЧИРПҮРЭН
/тамга/ /гарын үсэг/

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-07
БҮРТГЭВ-02

2022.09.21 өдөр
БҮРТГЭВ

УЛААНБААТАР ХОТ
ЛЭНДМН АКТИВ ТЭК ХХК
9022080559
ХТҮ4977 ⊕ 6888895

РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК

ЛЭНДМН АКТИВ ТЗК ХХК

lendmn

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-07
БҮРТГЭВ-02

**Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл**

| Д/д | Нэмэлт өөрчлөлтийн агуулга | Бүртгэсэн | |
|---|---|---|---|
| | | Огноо | Ажилтан тэмдэг |
| 1 | Батсүлд овогтой Оюунболд-г Гүйцэтгэх захирал -р сонгосон(томилсон)-ыг бүртгэв. | 2022.07.03 | Ш.Очирсүрэн |
| 2 | ЛэндМН актив оноосон нэр ЛэндМН активТЗК болж өөрчлөгдсөнийг бүртгэв. | 2022.08.14 | Н.Энхцэцэг |
| 3 | Атарсайхан овогтой Ганбат-г ТУЗ-ийн дарга-р сонгосон(томилсон)-ыг бүртгэв. | 2022.08.14 | Н.Энхцэцэг |
| 4 | Гишүүн 2 нэмэгдсэн болж өөрчлөгдсөнийг бүртгэв. | 2022.08.14 | Н.Энхцэцэг |
| 5 | 66120 Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах /2022.08.10-/ үйл ажиллагаа шинээр бүртгэв.<br>62090 Мэдээлэл технологийн үйл ажиллагаа үйл ажиллагааг хассаныг бүртгэв. | 2022.08.16 | Н.Энхцэцэг |

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.

000259538

УЛААНБААТАР ХОТ
ЛЭНДМН АКТИВ ТЗК ХХК
9022080559

РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК

СЗХ
2022.08.21 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-07
БҮРТГЭВ-02



## 9.2 Үнэт цаас гаргагчийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээ

МОНГОЛ УЛСЫН
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

# ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

Дугаар ТЗ 315/47

2022 оны 08 сарын 10 өдөр

Монгол Улсын Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 08 сарын 10 өдрийн 415 дугаар тогтоолоор

**“ЛЭНДМН АКТИВ ТЗК” ХХК** -д

**Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах**

үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрч, энэхүү гэрчилгээг олгов.

ДАРГА Д.БАЯРСАЙХАН

“Тамга”

Энэхүү гэрчилгээ нь хавсралтын хамт хүчинтэй

УЛААНБААТАР ХОТ
ЛЭНДМН АКТИВ ТЗК ХХК
9022080559

РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
RHINOS INVESTMENT UTsK LLC

СЭХ
2022 .09.21 өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -10- 07
БҮРТГЭВ-02



lendmn

*(Энэхүү хавсралт нь тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хамт хүчинтэй)*

**МОНГОЛ УЛС САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО**

**ТЗ 315/47 ТООТ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ХАВСРАЛТ**

"Тэмдэг"

Тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдэд зориулсан тэмдэглэлүүд

НЭГ. Хуулийн этгээдийн оноосон нэр: **"ЛЭНДМН АКТИВ ТЗК" ХХК**

ХОЁР. Хуулийн этгээдийн ангилал: **ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛД ЗОХИЦУУЛАЛТАЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

ГУРАВ. Үйл ажиллагааны төрөл,хэлбэрийн тэмдэглэл:

| Д/д | Үйл ажиллагааны төрөл, хэлбэр | Олгосон огноо | Олгосон шийдвэрийн дугаар | Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, сэргээсэн, сунгасан хүчингүй болгосон огноо, шийдвэрийн дугаар |
|---|---|---|---|---|
| 1. | **Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах** | 2022.08.10 | №415 тогтоол | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |

УЛААНБААТАР ХОТ
ЛЭНДМН АКТИВ ТЗК ХХК
9022080559
ХТҮ4977 СӨ888895

РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
RHINOS INVESTMENT UTsK LLC



УЛААНБААТАР ХОТ

## 9.3 Үнэт цаас гаргагчийн дүрэм

**"ЛЭНД АКТИВ ТЗК"**
**ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ**
**КОМПАНИЙН ДҮРЭМ**

1

## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. **"ЛЭНД АКТИВ ТЗК"** ХХК /цаашид "**Компани**" эсхүл "**ТЗК**" гэх/ нь Компанийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж энэхүү дүрэм /цаашид "Дүрэм"гэх/-ийн хүрээнд үйл ажиллагаа явуулах хязгаарлагдмал хариуцлагатай компани байна.

1.2. Компанийн оноосон нэр (монголоор)

а) Бүтэн нэр: **"ЛЭНД АКТИВ ТЗК"** ХХК

б) Англи нэр буюу товчилсон нэр: **"LEND ACTIVE SPC" LLC.**

1.3. Компанийн оршин байгаа газар:

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 3-р хороо, Жуулчны гудамж-34, Сүвд төв, 1,2 тоот

Харилцах утасны дугаар: 976-77222992, 99014653

1.4. Компанийн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигчийн мэдээлэл

| Хувьцаа эзэмшигчийн мэдээлэл | Регистрийн дугаар | Хаяг | Утас |
|---|---|---|---|
| "ЛэндМН ББСБ" ХК | 5039754 | Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 3-р хороо, Жуулчны гудамж-34, Сувд төв, 1,2 тоот | 77070101 |

1.5. Компани нь өөрийн албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэгтэй байна.

1.6. Компани нь ажилтангүй ба өөрийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой бүхий л үйлчилгээг гуравдагч этгээдтэй гэрээ байгуулж гүйцэтгүүлнэ.

1.7. Компанийн одоогийн болон ирээдүйн өр төлбөр нь (татварыг оролцуулан) тоогоор илэрхийлэгдэх ба түүний боломжит эх үүсвэрээр хангагдахуйц боломжтой байна.

## ХОЁР. КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1. Компани нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасан тусгай зориулалтын компани байх бөгөөд эрхлэх цорын ганц үйл ажиллагаа нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасны дагуу баталгаат үнэт цаас гаргах буюу тэдгээрийн дагуу хийгдэх энэхүү дүрмийн 2.3-т заасан бусад үйл ажиллагаа байна.

2.2. Компанийн зорилго: Компани Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд нийцсэн бөгөөд өөрийн тодорхойлсон шаардлагыг хангасан хэрэглээний болон автомашины зээлүүдийг багцлан худалдан авч, тэдгээрийг өөрийн хөрөнгө болон санхүүгийн тайлан тэнцэлд тусгах бөгөөд тийнхүү худалдан авсан зээлүүдийн төлбөрийг төлөх үүднээс Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргана.

2.3. Компани нь дараах үйл ажиллагааг эрхэлнэ. Үүнд:

- 2.3.1. Хэрэглээний болон автомашины зээл худалдаж авах;
- 2.3.2. Хэрэглээний болон автомашины зээлийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах;
- 2.3.3. Хэрэглээний болон автомашины зээл худалдаж авах зээлийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргахтай холбоотойгоор гэрээг байгуулах;
- 2.3.4. Баталгаат үнэт цаас гаргах, түүний төлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай үйлчилгээ үзүүлэх болон бусад гэрээг байгуулах;
- 2.3.5. Гэрээ болон компанийн байгуулсан бусад баримт бичигт заасан компанийн аливаа үүргийг гүйцэтгэх, эрх болон эрхээ хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх;
- 2.3.6. Бизнесийн үйл ажиллагааны явцад үүсэх хүүгийн болон бусад санхүүгийн эрсдэлийг удирдах үүднээс дериватив болон валютын ханшийн гэрээ ашиглах;
- 2.3.7. Мөнгөн хөрөнгийг Засгийн газрын үнэт цаас, төв банкны үнэт цаас, дотоодын эсхүл олон улсын хөрөнгийн зах зээлд арилжаалагдаж буй үнэт цаас, бусад санхүүгийн хэрэгслийг худалдан авах, банкны хадгаламж, харилцах данс болон банк бус санхүүгийн байгууллагын итгэлцэлд байршуулах;
- 2.3.8. Хууль болон дүрэмд заасан бусад.

2.4. Компани дараах үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно:

- 2.4.1. Дүрэмд зааснаар өөр үйл ажиллагаа эрхлэх, эсхүл үйл ажиллагаа явуулах;
- 2.4.2. Баталгаат үнэт цаасыг худалдсанаас олсон орлогоос эргүүлэн төлөх нөхцөлтэйгээр бусдаас зээл авах;
- 2.4.3. Компанийн гаргасан баталгаат үнэт цаас төлөгдөж дуусаагүй байх үед Санхүүгийн Зохицуулах Хорооноос зөвшөөрснөөс бусад тохиолдолд өөрийн хувьцаа эзэмшигчид ногдол ашиг төлөх, эсхүл аливаа бусад хэлбэрээр ногдол ашиг хуваарилах;
- 2.4.4. Хөдөлмөрийн гэрээ болон бусад гэрээний үндсэн дээр ажилтан авч ажиллуулах;
- 2.4.5. Хорооны зөвшөөрөлгүйгээр Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах.

## ГУРАВ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ БА ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ

3.1. Компани нь нэг бүр нь **1,000,000 (нэг сая)** төгрөгийн нэрлэсэн үнэтэй **80 (наян)** ширхэг зарласан бөгөөд гаргасан энгийн хувьцаанаас бүрдэх нийт **80,000,000 (наян сая)** төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй байна. Компанийн хувьцаа эзэмшигч нь Санхүүгийн Зохицуулах Хорооноос урьдчилан зөвшөөрөл авалгүйгээр өөрийн хувьцаагаа худалдах, арилжих, барьцаалах, эсхүл шилжүүлэх эрхгүй.

3.2. Компанийн хувьцаа эзэмшигч нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Компанийн эсрэг өөрийн гаргасан шаардлага, эсхүл түүний өмнө Компанийн хүлээх аливаа үүрэг, хариуцлагатай холбоотойгоор ямар нэгэн хууль зүйн маргаан үүсгэх, хянан шийдвэрлэх ажиллагаа эхлүүлэх, Компанид хариуцлага хүлээлгэхээр санал гаргах буюу санал өгөх, эсхүл Дүрмийн 8.2-р заалтад зааснаас бусад тохиолдолд Компанийг татан буулгахаар хүсэлт гаргаж үл болно.

## ДӨРӨВ. КОМПАНИЙН УДИРДЛАГА



УЛААНБААТАР ХОТ
ЛЭНДМН АКТИВ ТЗК ХХК
9022080559
ХТУ4977 С888895

РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
RHINOS INVESTMENT UTsK
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
20.. он ..сар .. өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-07
БҮРТГЭВ-02

4.1. ТЗК-ийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал /цаашид "**ХЭХ**" гэх/ байх ба ХЭХ-ын эрх хэмжээ болон бусад асуудлыг Компанийн тухай хуульд заасан журмын дагуу зохицуулна. Компанийн ХЭХ-ын бүрэн эрхийг энэ дүрмийн 1.4-т заасан цор ганц хувьцаа эзэмшигч болох "ЛэндМН ББСБ" ХК хэрэгжүүлэх бөгөөд ингэхдээ "ЛэндМН ББСБ" ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлөөс томилсон бүрэн эрхт төлөөлөгч буюу "ЛэндМН ББСБ" ХК-ийн Гүйцэтгэх захиралаар дамжуулан хэрэгжүүлнэ. "ЛэндМН ББСБ" ХК-ийн Гүйцэтгэх захирал нь өөрт олгогдсон бүрэн эрхийн хүрээнд Компанийн ХЭХ-ын эрхийг хэрэгжүүлж, шийдвэр гаргана.

4.2. Компанийн ХЭХ-ыг хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай Компанийн ТУЗ-ийн шийдвэр гарснаас хойш 5-аас доошгүй хоногийн дараа хуралдуулна.

4.3. Компанийн ХЭХ-ын чөлөө цагт Компанийн эрх барих дээд байгууллагын бүрэн эрхийг Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл /цаашид "**ТУЗ**" гэх/ хэрэгжүүлнэ.

4.4. ТЗК-ийн ТУЗ нь Компанийн үйл ажиллагааг удирдаж, хяналт тавьж ажиллах чиг үүрэгтэй байна. ТУЗ нь өөрийн үйл ажиллагаандаа ТУЗ-ийн үйл ажиллагааны журмыг баримтална.

4.4.1. ТЗК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь **3 (гурав)** гишүүнтэй байх бөгөөд нийт гишүүдийн **2 (хоёр)** нь хараат бус гишүүн байна. Компанийн ТУЗ-ийн гишүүдийг ХЭХ-ын шийдвэрээр томилж, чөлөөлнө.

4.4.2. ТЗК-ийн ТУЗ-ийн гишүүд нь Компанийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журамд заасан шаардлагыг хангасан байна.

4.4.3. ТЗК-ийн ТУЗ-ийн гишүүнийг чөлөөлсөн, эсхүл аливаа шалтгаанаар гишүүний эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсон тохиолдолд Компанийн ХЭХ-ын шийдвэрээр нөхөн сонгоно.

4.4.4. ТЗК-ийн ТУЗ нь Компанийн тухай хуульд заасан бүрэн эрхээс гадна дор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

4.4.4.1. Компанийн дүрмийн хэрэгжилтийг хангуулах;
4.4.4.2. ТЗК-ийн хөрөнгийг хадгалж, хамгаалах;
4.4.4.3. Эрх бүхий байгууллагаас хөрөнгө итгэмжлэн удирдах тусгай зөвшөөрөл авсан этгээдтэй гэрээ байгуулсны үндсэн Компанийн өдөр тутмын удирдлагыг гүйцэтгүүлэх,
4.4.4.4. Компанийн хөрөнгийг Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт заасан хөрөнгө итгэмжлэн удирдагчийн эзэмшил, удирдлагад шилжүүлэх. Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээг байгуулснаас хойш хууль тогтоомжид заасны дагуу хөрөнгө итгэмжлэн удирдагчийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохыг хориглоно.
4.4.4.5. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасны дагуу хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд заасан эрх үүргийн дагуу хяналт тавих,



УЛААНБААТАР ХОТ
ЛЭНДМН АКТИВ ТЗК ХХК
9022080559
ХТҮ4977 С888895

РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
150
RHINOS INVESTMENT UTsK LLC
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ

СЭХ
2022 .09.21
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-10-07
БҮРТГЭВ-02



4.4.4.6. Энэхүү дүрэмд заасан Компанийн зөвшөөрөгдсөн ажил хэрэг болон үйл ажиллагаатай холбоотой гэрээ болон бусад баримт бичиг байгуулах,

4.4.4.7. Компанийн нэр дээр банкны данс нээлгэх, аудит, тайлан бүртгэлийг хянах, хөрөнгө оруулагчдад төлөх төлбөр болон бусад төлбөр, зардлын төсвийг батлах,

4.4.4.8. Компанийн худалдан авсан зээлийн хөрөнгөд үйлчилгээ үзүүлж буй этгээдийн гүйцэтгэлийг хянах, шаардлагатай бол тэдгээрийг солих санал гаргах,

4.4.4.9. Компани нь өөрийн байгуулсан гэрээ болон бусад баримт бичгүүдээр хүлээсэн үүргээ чанд мөрдөж, гүйцэтгэж байгаад хяналт тавьж, хангуулах,

4.4.4.10. Компанийн байгуулсан гэрээ болон бусад баримт бичгүүдээр Компанид олгогдсон бүх эрх болон эрх хамгаалах хэрэгслийг хэрэгжүүлэх,

4.4.4.11. ТЗК-ийн үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулж буй хууль тогтоомж, Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын Хөрөнгийн биржийн журам болон Компанийн дүрэм, Компанийн дотооддоо дагаж мөрдөж буй журам, зааварт заасан бусад бүрэн эрхийг хэрэгжүүлэх.

4.4.5. ТЗК-ийн ТУЗ нь улиралд нэгээс доошгүй удаа хуралдана. Шаардлагатай гэж үзвэл ТУЗ-ийн даргын санаачилгаар, эсхүл ТУЗ-ийн гишүүдийн олонхийн санал, эсхүл Хөрөнгө итгэмжлэн удирдагч, Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн санал, шаардлагаар ээлжит бус хурлыг хуралдуулж болно.

